

Дэлхийн төв рүү аялсан нь

I

1863 оны тавдугаар сарын 24-ний ням гаригт миний нагац ах профессор Лиденброк Ханбург хотын Конигстрасс гудамжин дахь 19 номерын бяцхан байшиндаа яаран буцаж ирэв.

Өдрийн хоёр цаг болоогүй учир үдийн хоол ч бэлдэж амжаагүй байлаа.

Зарц эмэгтэй Мартэ хоолны тасалгааны үүд нээж:

-Ноён Лиденброк, ирчих нь энэ үү! гэж дуу алдав. Үүнийг сонсоод “Нагац лав ууртай ирэв бололтой” гэж намайг бодох зуур Мартэ:

-Ороод ирлээ. Би явалгүй горьгүй нь. Ноён Аксель та, түүнийг тайвшруулж үзээрэй гээд гарч одов.

Би ганцаар үлдсэн боловч профессорын хэл амыг татлах зүрх хүрсэнгүй. Гэрийн эзэн гаднаас ирээд ажлынхаа тасалгаа уруу шууд гүйж орох үед би өөрийн жижиг өрөөг янзалсан болж байлаа. Нагац таягаа тасалгааны булан руу шидэж малгайгаа ширээн дээр хаямагц:

-Аксель нааш ир! гэж дуудав.

Намайг хөдөлж ядсаар байтал профессор бүр тэсэж ядан

-Хүүеэ! чи чинь байна уу, үгүй юу? гэж дахин хашгирав. Би ч нагацын өрөө уруу ухасхийв.

Отто Лиденброк төрөлхийн хатуу, этгээд зантай боловч хүнээр муугүй бөлгөө. Тэр, эрдэс судлалын ухааны хичээл заадаг багш байв. Эрдэс судлалын ухаанд хэл хугалчихам хэцүү нэр томъёо өдий төдий байдаг бөгөөд хичээл заах үед оносон нэр нь олдохгүй байх явдал олонтаа тохиолдох тул ах тэр тоолон л уцаарладаг байв.

Нагац бол бусдын тулд биш өөрийнхөө төлөө ажилладаг хувиа хичээсэн эрдэмтэн байлаа. Ийм эрдэмтэн Германд цөөнгүй байдаг юм. Гэвч нагац ёстой эрдэмтэн хүн билээ. Лиденброкийн нэр тус орны олон сургууль, нийгэмлэгт алдаршсаны учир Ханбургээр дайрч өнгөрөх эрдэмтэд цөм түүнийг эрж уулздаг байлаа. Түүнээс гадна тэрээр эрдэс судлалын баялаг үзмэрийг хадгалагч бөлгөө.

Тэр, яс ханхардуу хир нь туранхай, шаргал үстэй, төмөр мэт чийрэг биетэй, тавь орчим настай билээ. Түүний алаг нүд нь нүдний далбагар шилний цааны үл тогтон эргэлдэнэ. Явахдаа зангидсан гараа савлаж хол хол алхална. Зан ааш ширүүн догшин учир үерхэж найзлахад эелдэг ялдам биш билээ.

Намайг тэвдэн уцаарлаж дуудсан хүний байдал иймэрхүү байв.

Нагац, германы баян профессоруудын нэг тул түүний мэдэлд хуучин байшин суугч хүмүүсийн хамт байх бөгөөд үүнд: нагацын загалмай зүүлгэсэн охин, арван долоон настай Граюбен, зарц эмэгтэй Мартэ болон би багтана. Профессорын зээ болох миний бие хичээлийн элдэв туршилт хийхэд нь түүнд юмы нь бэлтгэн туслагчийн үүрэг гүйцэтгэдэг байлаа.

Би геологийн шинжлэх ухаанд дуртай, мах цуснаасаа л эрдэс судлагч болж төрсөн юм шиг хүн билээ.

Нагац хэдийгээр хэцүү хатуу зантай боловч надад хайртай сайн учир би дурдсан гудамжны мөнөөхөн жижиг байшинд жаргалтай сайхан амьдардаг байлаа.

Эрдэмтэн нагац гар хумхин зүгээр суухыг ер мэдэхгүй. Дөрөвдүгээр сар гарч

хавар болмогц хашаан дотроо цэцэг тариад түүнээ хурдан ургуулах гэж өглөө бүр иш навчий нь хүртэл илж чангааж байдаг билээ.

Ийм зан байдалтай хүний үгэнд орохгүй байж яахин болох вэ. Ингээд би өрөөнд нь гүйж орлоо.

Түүний тасалгаа нь ёстой үзмэрийн газар билээ. Эрдэсийн баялаг цуглуулгаа туйлын нямбай өрж тавьсан байна.

Чулуу нэг бүрийг би сайн мэддэг, ихэд хайрладаг байсныг хэлээд яах вэ?

Гэвч би энэ удаа тасалгаанд орохдоо тэр тухай биш, харин нагац яах нь юм бол л гэж бодож байлаа. Тэр гартаа нэг ном барьж том гэгчийн зөөлөн сандал дээр суугаад:

-Ямар сонин ном бэ? Яасан жигтэй юм бэ? гэж үглэж байв. Эрдэмтэн нагац маань аливаа ном, ялангуяа эртний ховор номд гойд дуртай билээ.

-Үгүй, чи хараач, ёстой эрдэнэ гэдэг энэ байна. Үүнийг өнөө өглөө Хевилиусийн дэлгүүрээс авлаа гэж хэлэхэд нь баахан зориг орж:

-Ямар сайхан хэрэг вэ? гэж хариулав.

Үнэндээ ч тэр нь удаж шарласан их хуучин ном байлаа. Профессор залгаж:

-Хараач, асуулт, хариултыг нэг дор бичсэн байна. Мөн сайн хэрэг шүү. Энэ номыг нээхэд амархан ч гэсэн хамхиж цааш тавихын аргагүй юм. Тэгээд долоон зуун жил болсон гээч! гээд л ярьж гарахад нь би:

-Тэгээд энэ сайхан ном ямар гарчигтай юм бэ? гэж асуув.

-Арван хоёрдугаар зууны үед Снорре Тюрлесон хэмээх нэг исланд хүний зохиосон "Хеймс-Крингла" гэдэг бүтээл.

-аа тийм үү? тэгээд энэ чинь тэр номын герман орчуулга уу? гэхэд нагац их л урамтайгаар:

-Тийм, орчуулга нь. Гэвч исланд хэлээрээ бичсэн эх нь байвал би түүний орчуулгаар юу хийх билээ гэв.

-Түүний бичиг үсэг ийм чамин гоё юм уу даа гэж намайг улам сонирхон асуухад:

-Юун бичиг үсэг! Хэн бичиг үсгийн тухай ярьсан юм бэ, эрт урьдын зураг тэмдгэн бичгийн тухай ярьж байна шүү дээ, Аксель минь

-Зураг тэмдэг ий?

-Тийм ээ, нэг үе Исландад зураг тэмдгийг бичиг үсэг болгон хэрэглэж байсан юм гэв.

Гэтэл санамсаргүй өнөөх номын нь завсраас тос хир болсон цаасны тасархай хийсэж газар унав.

-Энэ чинь юу билээ? гэж нагац гайхан асуув. Тэр нь хачин тэмдгүүдийг эгнүүлэн зурж дүүрэн цоохорлосон уртаараа тав, өргөнөөрөө гурван ямхын хэмжээтэй тасархай цаас байлаа.

Чухамхүү эдгээр зураг, XIX зууны үеийн хамгийн гайхалтай сонин эрэл хайгуул хийхийг профессор Лиденброк бид хоёр арга буюу шаардав.

Профессор бичгийг хэдэн минут ажиглаж харснаа:

-Тэмдэг бичиг л байна даа. Гэхдээ юу гэсэн утга тэмдэглэсэн юм бол?... Лав эртний исланд хэлээр бичсэн хэрэг дээ! гэв.

Профессор Лиденброк үнэхээр олон хэл сурсан бөгөөд дэлхий дээрх хоёр

мянган хэлээр цөмөөрөнгөөр эс яривч тэдний нилээдийг мэддэг байлаа. Тэгээд ч нагац одоо огт мэдэхгүй бичигтэй тулгарсандаа тэчъяадан уурлаж байлаа. Ханын жижиг цаг хоёр жин цохиход түүнийг уурлаж сүйд болох вий гэж би бодлоо.

Гэтэл зарц Мартэ тасалгааны хаалгаар шагайж:

-Шөл бэлэн боллоо гэж хэлэлэд нагац:

-Шөлий чинь чөтгөр долоог! гэв.

Мартэ ч бушуухан алга болов. Би хоолны өрөөнд орж өөрийнхөө байранд суув. Хэдэн минут өнгөрлөө. Профессор ирсэнгүй. Нагац ийнхүү анх удаа үдийн хоолонд байсангүй. Тэр өдрийн хоолны амтыг яана! Би дүү нь болохоор өөрийнхөө хоолыг нагацынхтай хамт идэж билээ.

-Ноён Лиденброк ширээнд суусангүйеэ!

Хоол идээд бараг дуусаж байхад нагац намайг хашгиран дуудсанд би тэр даруй ажлын тасалгаанд нь гүйж оров.

-Энэ гарцаагүй, зураг тэмдэг байна. Үүнд ямар нэг нууц байна даа. Үүнийг заавал тайлж мэднэ! ... Чи тэнд суугаад бич гэж профессор ширээ заагаад

-Би чамд исландын эдгээр үсэг бүртэй дүйх манай цагаан толгойн үсгийг дуудъя. Тэгээд юу болохыг нь үзье! Харин алдахгүйг хичээгээрэй! гэв.

Үсгээ дуудаж эхэллээ. Дуудсан үсгүүд нь нийлээд ийм зүйл болов.

mm. rnlls estreuel seecJde

sg tssmt unteief niedrke

kt, samm atrateS Saodrrn

em tnael nuaect rrilSa

Atvaar .nscrc ieaabs

Ccdrmi eeutul frantu

dt ias oseibo KediiV

Нагац, үсгүүдийг дуудаж дуусаад миний цоохорлосон хуудсыг шалавхан авч удтал ажигласны сүүлд:

-Энэ юу гэсэн үг байх вэ? Үүнийг нууц бичиг мөн гэж үзвэл тусгай журмаар байрлуулж өрсөн эдгээр үсгүүдийн цаана ойлгомжтой өгүүлбэрээр илэрхийлсэн ямар нэг утга нуугдаж байх ёстой. Тэр нь мэдэгдээгүй нэгэн их нээлтэй тайлбар ч байж магадгүй гэв.

Энэ үгийг сонсоод “юу л байв аж, шал дэмий юм” гэж би бодсон боловч ил хэлсэнгүй.

Профессор ном, цаас хоёрыг авч дахин ажигласнаа:

-Нууц бичгийг энэ ном хэвлэгдэн гарнаас нилээд хожим бичсэн байна. Харин миний бодлоор бол номын эзэн л энэхүү зураг тэмдгүүдийг бичсэн бололтой. Гэвч тэр эзэн нь хэн байх билээ? Нэрээ хуучны энэ бичиг дээр тавиагүй болов уу? гэв.

Тэгээд сайн томруулагч шил барьж номын эхний хуудсуудыг шинжин нэгжсээр хоёрдугаар хуудсанд бэхэн толбо шиг юм байхыг олж харав. Сайтар ажиглавал хэдэн үсэг байв. Нагац түүнийг хамгийн сонирхолтой зүйл гэж томруулагч шилээр тодруулан ажиглан хараад эцэст:

Гэсэн зураг тэмдгэн бичгийг уншиж чадлаа

-Арне Сакнусем!

-Энэ чинь ХҮҮ зууны үеийн исландын нэгэн алдарт алхимичийн нэр байна! гэж

гайхан дуу алдахад нь би түүнийг бахдан харж суулаа. Нагац үргэжлүүлэн:

-Алхимич Авиценка, Бэкон, Луллий, Парацельс¹ нар бол тэр үедээ үнэхээр том эрдэмтэд байсан юм. Тэд гайхамшигтай сонин нээлтүүд хийж байлаа. Тэгэхээр Сакнусем ч ямар нэг нээлтээ энэ хачин бичгээр нууцалсан байж мэднэ. Ер нь тэгсэн хэрэг болох нь ээ гэв.

Тэгээд профессорын сэтгэл сэргэж:

-Ер нь би энэ бичгийн нууцыг тайлахаас нааш хоол ч идэхгүй унтаж ч амрахгүй, чи ч ялгаагүй гэхэд би “чөтгөр шиг юм боллоо доо. Нагацын хоолыг хамт идсэн маань л сайн боллоо” гэж бодож суутал нагац:

-Эхлээд энэ “нууц түлхүүрийн” бичиг чухам ямар хэлээр бичигдсэнийг олох хэрэгтэй. Энэ ч амаргүй л дээ. Бичигт 79 гийгүүлэгч, 53 эгшиг байна. Энэ бол өмнө үгийн хэлний авианы харьцаа байна. Харин умар зүгийн хэл бол үүнээс олон гийгүүлэгчтэй байх ёстой. Ингэхлээр өмнө зүгийн нэг хэлээр бичсэн бололтой гэв.

Энэ нь үнэхээр тийм байлаа. Нагац цааш нь:

-Ямар хэл байж таарах вэ? Сакнусем бол эрдэмтэн хүн болохоор ХҮИ зууны үеийн эрдэмтдийн сонгомол хэл болох латин хэлээр бичсэн байж болох юм. Гэвч цэвэр латин биш холимог латин хэл байх. Сайн ажиглав. Энд, зуун гучин хоёр үсгийг эмх журамгүй тавьсан шиг байна. Жишээ нь нэгдүгээр мөрний mils гэдэг нь дан гийгүүлэгчээр бүтсэн байхад зарим мөрөнд олон эгшиг орсон байна. Миний бодоход өгүүлбэрийг эхлээд бичдэг ёсоор нь бичээд дараа нь түүний үсгүүдийг үл мэдэгдэх нэг дүрэм горимын дагуу өөрчилж тавьсан шиг байна. Түүнийг л мэдэх хэрэгтэй гэв.

Энэ үед би хананд өлгөөстэй байсан Граюбений сайхан хөргийг харж байлаа. Одоо тэр бүсгүй Альтон хэмээх газар байгаа эцэг, эхийндээ очихоор явчихсан тул эзгүйд нь би баахан уйтгартай байсан билээ. Бид харилцан бие биедээ сэтгэлтэй болсон боловч геологийнхоо мөрийг хөөхөөс өөр хайр дурлал мэтийг мэдэхээ больсон нагацаас эмээхдээ нууцгайхан дурлалцах бөлгөө.

Граюбен бол цайвар үстэй, цэнхэр нүдтэй хөөрхөн бүсгүй бөгөөд ааш зан харцдуу, оюун ухаан сэргэлэн ажээ. Тэр над их хайртай, би ч түүнд ухаангүй сайн байлаа.

Нагацыг гэнэт хуруугаар ширээ тогшиход би хулжсан байдлаас сая ангижрав.

-Өгүүлбэрийн үсгүүдийг хольсон ухааныг олох нэгдүгээр арга бол үсгийг дээрээс доош цувруулан бичих арга байна гэж хэлэхэд би:

-За гэлээ.

-Ингээд юу болохыг үе. Аксель, чи энэ хуудас цаасан дээр ямар нэг өгүүлбэрийг дээрээс доош нь зургаан мөрөнд багтааж бич гэхэд нь би:

Б д й ш р н
И и р ү а м
ч х т ү ю и
а х а, б н
м а й Г е ь

гэж бичив.

-Сайн байна гэж профессор хэлээд

-Одоо тэр үсгүүдээ хөндлөн тийш нь нэг шугаманд эгнүүлж тавь гэхэд би түүний хэлсэн ёсоор гүйцэтгэвэл:

Бдйшри иирүам чхтүюи аха, бн

Май Гей гэсэн хачин үгнүүд боллоо.

-Маш сайн байна. Сакнүсемийн бичсэн эртний бичгийн төрх байдал мэдэгдлээ. Чиний наад өгүүлбэрийг уншъя. Эхлээд үг бүрийн эхний үсгүүдийг нэг авч, дараа нь хоёр дахь үсгүүдийг, цааш нь гурав дахийг гэх мэтээр авах хэрэгтэй дээ гээд ах миний бичсэнийг харж “Би чамд их хайртай шүү, Граюбен минь” гэж уншаад ихэд гайхаж “Аан, тийм болсон бий” гэхэд нь би бүр яах ч учраа олохгүй болж санамсаргүй бичсэн минь нэр хугалах ажил болоо шив гэж бодлоо.

-Уухай, чи Граюбенд хайртай болоо вий! гэхэд би

-Тийм... үгүй... гэж хэлэх үгээ олохгүй сандарч байлаа.

-Чи Граюбенд хайртай гэнээ! гэж санаандгүй дахин өгүүлээд

-За тэр ч яах вэ? Саяын аргаа энэ бичиг дээр хэрэглээд үзье! гэв.

Профессор чичирхийлсэн гараар өнөөх хуучин гар бичмэлийг дахин барьж доорх үсгүүдийг төв хоолойгоор над дуудаж бичүүлсэн нь:

mmessunkaSenrA. IcefdoK. Segnittamurtn
ecertserrette, rotaivsadua, ednecsed sadne
IacartniiluJ siratracSarbmutablem
meretarcsiluco VsleffenSnI. Гэжээ.

Нагац маань энэ латин өгүүлбэрийг нь гаргаж унших уу гэж миний бодтол гэнэт нударга ширээн дээр тас буув. Миний барьж байсан харандаа гараас суга үсрээв явчихав.

Энэ шал буруу, ямар ч утга алга гэж профессор хашгираад тасалгаанаас огло харайн гарч гадаа гудамжаар хар хурдаараа гүйгээд алга боллоо.

-Яваад өгөв үү? гэж Мартэг асуухад би:

-Тийм, явчихлаа гэж хариулав.

-Тэгвэл хоолоо яах юм бол?

-Хоол идэхгүй байх аа.

-Оройныхоо хоолыг идэх болов уу?

-Идэхгүй байх

-Юу болоо вэ?

-Мартэ гуай минь, нагац нэг хуучин гар бичмэлийн учрыг тайлах гэж байгаа юм. Одоохондоо ухааны нь олоогүй байна. Ингэхлээр өөрөө ч хоол идэхгүй, энэ байшинд байгаа улсыг ч идүүлэхгүй байх л даа.

-Тэгээд бид чинь өлсөж үхэх хэрэг үү! гээд сэтгэл нь ихэд түгшсэн Мартэ авгай гал тогооныхоо өрөөнд орчихов. Би ч чулууны цуглуулгыг дэлгэцнээ байрлуулах ёстой байсан тул ажилдаа орлоо. Гэвч өнөөх хуучин гар бичмэл ер санаанаас гарч өгөхгүй байлаа. Ёр ёрлож байсан юм билээ л дээ.

Би цагийн дараа ажлаа дуусгаад ахын том зөөлөн сандал дээр суулаа. Гаансаа нэрж, үзэг цоохорлосон мөнөөхөн хуудас цаасыг санамсаргүй авч хараад “энэ юу тэмдэглэсэн юм бол?” гэж бодож суулаа.

Тэдгээр үсгүүдийг үг болгох гэж янз янзаар туршиж нийлүүлж үзэв. Утга болохын аргагүй, үнэхээр хэцүү бичиг байлаа. Нэг зуун гучин хоёр үсэг миний эргэн тойронд хөвөөд байх шиг санагдаад нүд эрээлжилж амьсгаа давхцан дотор эвгүй болоход би барьж байсан өнөөх хуудас цаасыг өөрөө мэдэхгүй дэвж салхи гаргах

гэсэн байжээ.

Тэгээд цаасыг хөдөлгөн эргүүлтэл гэнэт түүн дээр бичсэн латин үгүүдийг гаргаж уншлаа. Хичнээн гайхсан гэж санана. Би нууц бичгийн түлхүүрийг ингээд олчихлоо. Уг бичгийн хэл хийгээд үсгүүдийн байрлалтыг профессор цөм зөв тогтоосон байлаа. Харин нэг “өчүүхэн” зүйл орхисныг нь би санамсаргүй олчихжээ.

-Уншлаа гэж би дуу алдаад бүх өгүүлбэрийг бүгдийг өндөр дуугаар өдий төдий дахин уншив.

Гэвч бичгийг зөв уншлаа гэж ойлгомогц би тэнгэрт ниргүүлсэн мэт болсон билээ. Учир нь энэ маань надад эцэстээ ямар аюул гамшиг учруулахыг гадарласан юм. “Нэг хүн тэнд нэвтрэн орж гэнэ ээ!”... Үгүй, хэрхэвч үгүй, нагац үүнийг мэдээгүй нь дээр! Ийм жугуулчлалыг мэдвэл өөрөө бас явах гэнэ! Нэг шийдвэл түүнийг юу ч саатуулахгүй! Тэр заавал явна, явахдаа намайг бас дагуулна, ингээд бид дахин эргэж ирэхгүй гэсэн үг! Үгүй, хэрхэвч хэлэхгүй! Ийм юманд хүргэхгүй. Хэрэв нагац гар бичмэлийг эргүүлж тойруулсаар байгаад санамсаргүй өнөөх нууц түлхүүрийг олчихвол яана! Ер нь энэ бичгийг үгүй хийж орхиё!” гэж бодлоо.

Зууханд гал дүрэлзэж байна. Өнөөх цоохорлосон бичигтэй хуудас цаас, Сакнусемийн гар бичмэл хоёрыг шүүр аваад гал руу шидэх гэтэл тасалгааны үүд нээгдэн нагац ороод ирлээ.

Би өнөөх бичгийг ширээн дээр яаран буцаан тавив. Профессор Лиденброк гүн бодолд автагдсан хэвээр бөгөөд бичгийн байдлыг эрэгцүүлэн шинжиж байгаа нь маргаангүй байлаа.

Тэр зөөлөн сандалд суугаад харандаа авч алгебрын томъёо мэт зүйлсийг бичиж эхэллээ.

Би түүний хөдлөх бүрийг алдалгүй ажиглаж суулаа.

Нагац бүтэн гурван цагийн турш толгой өргөлтгүй дув дуугүй ажиллав. Хэрэв янз янзаар тавьж үзэж эцэст нь үсгүүийг тааруулчихвал өгүүлбэрийн утга илхэн болох байлаа. Гэвч хорьхон үсгийг ч болов хичнээн олон янзаар байрлуулж болно гэдгийг би мэдэж байсан юм. Уул бичигт байсан 132 үсэг нь 133 нууц тэмдгээс бүрдсэн хэд хэдэн өгүүлбэр болох ёстой байсан билээ.

Цаг мөч өнгөрсөөр шөнө боллоо. Нагац үүнийг анзаарсангүйгээр барахгүй Мартэг хаалга онгойлгож

-Ноёнтон, өнөө орой хоол зооглох болов уу? гэж асуухад нь ч хариу дуугарсангүй. Зарц баахан хүлээж байгаад цааш оров.

Намайг зөөлөн буйдангийн буланд хөдлөхгүй суусаар зүүрмэглэн унтах зуур нагац үргэлж юм бодож эрээчсээр л байжээ.

Нойроос сэрэхэд нэгэнт өглөө болсон байх боловч профессор ажиллаж л байв. Их ядарч царай нь хувхай цагаан болоод хоёр нүд нь улайсан байв. Түүнийг хараад над өрөвдөх сэтгэл төрлөө.

Би цорын ганц үг хэлэхэд л нагацыг энэ зовлонгоос ангижруулчих байсан. Гэвч “үгүй, хэлэхгүй. Хэлбэл тийшээ явах гэнэ, би сайн мэдэж байна. Бусад геологчдын хийгээгүй зүйлийг хийхийн тулд амь биеэ бодохгүй зүтгэх хүн Ингэхлээр манай олсон нээлт бол профессор Лиденброкийг алах зүйл мөн. Тэгэхийг би юун бодох билээ. Тэгэхлээр бичгийн нууцыг илчлэхгүй нь зөв” гэж шийдээдхүлээзнэж байв.

Зарц Мартэ идэж уух юм цуглуулахаар гэрээс гарах гэтэл байшингийн үүд

түгжээстай байлаа. Зарц эмэгтй үүнийг тун сүрхий юм болгож ихэд тэвджээ. Харин би өглөөний хоол идэхгүй тэсвэрлэх хэрэгтэй болсныг ойлголоо.

Нагац ч ажилласаар л байна. Түүний бодол санаа газар дэлхийгээс ангижран зайлж туршин байрлуулах ер бусын ертөнцөд замхарчаа.

Үд дөхөхийн үед гэдэс баахан өлсөж эхлэв. Гэвч би тэссээр байлаа.

Хоёр цагийн жин цохив. Би ядаж түүний жуулчлал хийх зоригийг мохоох зорилгоор уг бичгийг тийм сүрхий зүйл биш гэсэн маягийн юм хэлэхэд нагац түүнийг өөрийгөө мэхлэн төөрөгдүлэх гэсэн хэрэг гэж мэдээд ер тоосонгүй. Тийнхүү оролдон эцэстээ “нууц бичгийн” түлхүүрийг өөрөө олов бололтой...

Профессор босож малгайгаа өмсөөд гарахаад завдахад нь “Биднийг түгжиж орхиод явчих юм биш байгаа! Тэгж ч ярихгүй шүү! гэж бодоод дүүрсэн хэрэг бүх зүйлийг хэлье” гэж шийдэв. Тэгээд

Нагац аа! гэвэл тэр дуулсангүй бололтой

-Лиденброк нагац аа! гэж дахин дуудахад

-Юу гэв! гэв

-Түлхүүр нь энэ биш үү?

-Ямар түлхүүр? Түлхүүр хаалганд алга уу?

-Үгүй ээ, бичгийн түлхүүр хэлж байна гэж би залруулав.

Профессор намайг нүднийхээ шилэн дээгүүр өнгийж харснаа гарыг минь шүүрэн атгаж юу ч хэлэлгүй ширтээд байв.

Намайг “нээрээ” гэж батлан дохиод түүний нүд гялалзан сэргэв.

-Нээрэн түлхүүр нь энэн!... би санамсаргүй... гэхэд тэр:

-Чи юу хэлэв гэж ихэд баярласан байдалтай дуу алдав.

-Та үүнийг аваад унш даа гээд хуудас цаасыг түүнд өгөхөд нагац хараад:

-Ойлгогдох юм юу ч алга байна шүү дээ гэлээ.

-Зүгээр та уншихдаа эхнээс нь биш харин сүүлээс нь урагш нь...

-Тийм байна. Сакнусем гэж байна. Чи ингэж тонгоргоод өгүүлбэрийг уншчихаа юу? гэв.

Тэгээд нагац хуудас цаасыг ажигласаар эртний бичгийг үсэг дараалан уншиж дуусгав.

Мөнөөхөн латин эхийг орчуулбал:

“Зургадугаар сарын хуучдаар Скартарисын сүүдэр буумагц Снеффельсийн Ёкюлийн тогоо цармаар орж уруудвал дэлхийн голд хүрнээ. Би туршсан билээ. Арне Сакнусем” гэжээ.

Нагац магнай хагартлаа баярлажээ. Хоёр гараар толгойгоо атган нааш цааш холхиж энд тэнд сууж босож байснаа зөөлөн сандал дээрэ лагхийн суугаад:

-Хэдэн цаг болж байгаа бл? Гэж асуухад нь би:

-Гурван цаг гэж хариулав.

-Байз! Би өлсөж үхэх шахжээ. Хоолоо идье. Тэгээд дараа нь:...

-Дараа нь яах гэж?

-Чи миний чемоданыг зэхчих гэв. Би гайхаж:

-Та нээрээ хэлж байна уу? гэж дуу алдваас:

-Өөрийнхийгөө ч гэсэн бас зэхээрэй гэж нэмж хэлээд профессор хоолны өрөө рүү орчихов.

Эдгээр үгсийг сонсмогц “Дэлхийн төв уруу явах гэнэ үү! Ийм юм хүний санаанд яаж орно вэ? гэсэн аймшигт бодолд автагдав.

Нагац маань хоол идэх зуураа их л хөгжөөнтэй байлаа. Сүүлчийн зуушийг идсэний дараа намайг дагуулаад тасалгаандаа орлоо.

-Аксель, чи тун ухаантай хүү юм. Над маш их тус хүргэлээ. Би зээгээ хэзээ ч мартаггүй. Чи миний алдар гавъяанаас хуваалцах болно. Харин энэ нууцыг хэрхэвч задруулж болохгүй. Үүнийг мэдвэл өдий төдий эрдэмтэд жугуулчлах гэнэ гэж нагацын өгүүлэхэд би:

-Тэднийг үнэхээр тэгнэ гэж та бодож байна уу? гэж асуулаа.

-Яриагүй тэгнэ. Хэрэв энэ бичгийг мэдчихвэл геологчдын бүхэл бүтэн архи Арне Сакнусемийн замаар хуйлран орцгооно!

-Нагац минь, би ер нь тэгнэ гэж итгэхгүй л байна. Учир нь энэ эртний гар бичмэл чулуу хөөлгөж байж ч болно шүү дээ гэхэд профессор инээмсэглэн:

-Гайгүй, бид удахгүй нүдээрээ үзнэ гэв.

-За тэгвэл та юуны өмнө надад Ёкюль, Снеффельс, Скартатис гэсэн үгсийг тайлбарлаж өгөөч! гэхэд минь нагац газрын зургийн атлас нээж өгүүллрүүн:

-Исланд нутгийн шилдэг сайн зургийн нэг энэ байна. Энэ арал дээрх олон галт уулыг нийтэд нь Ёкюль гэдэг юм. Исландаар Мөс гэсэн үг гэв.

-Тэгвэл, Снеффельс гэдэг нь юу юм бэ?

-Исланд нутгийн баруун эрэгт түүний нийслэл Рейкьявик хот байгаа биз? За, тийм, тэндээс хойт зүйгт гарсан далайн хавцал булангуудыг дагуулж 65 дугаар өргөрөг хүртэл хар! Тэнд юу байна?

-Нэг уул байна.

-За тэгвэл, түүнийг Снеффельс гэдэг юм.

-Энэ үү?

-Тийм, өндөр нь таван мянган фут¹ уул байгаа юм. Хэрэв түүний тогоо цармын ёроол дэлхийн голд хүрдэг бол ертөнц дахинаа хамгийн алдлартай уул болох нь ямар ч маргаангүй.

-Тийм байж болох уу даа!

-Болноо, яагаад болохгүй байх вэ?

-Түүний тогоо дотор хайлмаг лав дүүрэн байгаа шү дээ?

-Хэрэв тогоо нь царцанги байвал яах вэ?

-Царцанги байна гэж үү дээ? гэж намайг эргэлзэхэд нагац:

-Тийм ээ, энэ уул түүхэндээ 1219 онд ганцхан удаа дэлбэрсэн гэлцдэг юм гэв.

-За тэгвэл Скартарис гэж юу гэсэн үг вэ? Зургадугаар сарын хуучдаа тэнд юу болдог юм бэ? хэж өгөөч гэж хүсэхэд анагц

-Снеффельс уул оройдоо хэд хэдэн тогоотой. Харин дэлхийн төв уруу ордог тэр тогоог олох хэрэгтэй. Энэ исланд эрдэмтэн туршсан нь үнэн бол түүний бичсэнээр зургадугаар сарын хуучдаа Скартарис уулын сүүдэр, тогоо дээрээ бууна гэжээ. Үнэн бол бид явсан замыг нь олж болно гэлээ.

Ийнхүү асуусан бүгдий маань хариуллаа. Нагац хуучин гар бичмэлийн үгсийг тун сайн ойлгожээ.

-Одоо Сакнусемийн бичсэн зүйл тодорхой боллоо. Тэр эрдэмтэн Снеффельс ууланд очоод Скартарисын сүүдэр нүх тогооны амсарт тусахыг харсан юм байж гэв.

Гэвч тэр хүн дэлхийн төв рүү жуулчлалд буцаж ирсэн гэдэг ор үндэсгүй худал зүйл мөн! гэж намайг хэлэхэд:

-Яагаад худал гэж? гэж нагац сарган асуув.

-Газрын гүнд доошлох тутам улам халуун болсоор дэлхийн төвд бүр хоёр мянган градус хүрдэг нь бүхэнд илэрхий билээ. Ийм халууны дотор тэр эрдэмтэн нэвтрэн орж чадаа гэж үү гэж хэн ч асууна шүү дээ. Зөвхөн хоёрхон бээрийн гүнд л гурван зуун градус халуун байдаг гэдэг биз дээ.

-Аксель, чи хайлчих вий гэж айж байна уу?

-Үгүй, би энэ асуудлыг танаар нотлуулах гэж танд тавьж байгаа юм гэхэд профессор Лиденброк ихэмсэглэн маргаж өгүүлсэн нь:

-Дэлхийн бөмбөрцгийн дотоодод чухам юу болж байгааг чи ч гэсэн, бусад хэн ч ялгаагүй яг тодорхой мэдэхгүй. Шинэ онол гарах бүрдээ өмнөхийгөө ямагт эвддэг. Хэрэв бөмбөрцгийн дотоодод үнэхээр хоёр мянган градус халуун байдагсан бол газар дэлхий шатчих байсан гэж ёстой их эрдэмтэн хүмүүс баталдаг юм. Тэгээд бас дэлхий үүсэн тогтсоноос хойш галт уулсын тоо өдий төдийгөөр цөөрснийг бодвол дотоодын халуун буурч байгаа хэрэг бишүү. Миний нотолгоо энэ л байна гэлээ.

Профессор цааш нь олон баримт, таамнал гаргаж ердийнхөө бардангуй сэргэлэн байдлаар тайлбарлан ярихад нь би баахан мохож эхэллээ.

-Ингэхлээр энэ талаар геологчдын дунд өдий төдий таамнал байдгийг чи мэдээ биз, харин төвийн халууны тухай яг мэдсэн зүйл үгүй. Миний бодоход тийм халуун биш байх. Бид үүнийг нүдээр үзэж Арне Сакнусем шиг энэ том асуудалд хариу өгнө! гэж нагацыг үргэлжлүүлэн ярихад миний сэтгэл ихэд хөдөлж:

-Тиймээ, тэгэлгүй яах вэ. Хэрэв бид түүнийг харж чаддаг юм бол нүдээр үзэлгүй дээ гэж хариуллаа.

-Яагаад чадахгүй гэж? Хүн өөрийнхөө тусын тулд байгалийн цахилгааныг хүртэл ашиглаж чадсан шүү дээ.

-Тийм ээ, энэ мэтээр бол ч болох л юм даа.

-Энэ ч илэрхий хэрэг л дээ. Харин дуугүй л байх хэрэгтэй, манай аяллын талаар нэг ч үг алдаж болохгүй. Дэлхийн төви йг хэн ч биднээс түрүүлж нээх ёсгүй дуулаа биз? гэж нагац бахдан өгүүллээ.

Би нагацын тасалгаанаас балай дүймэг хүн шиг гарав. Салхинд гарч Ханбургийн гудамжаар явсан ч огт тус болсонгүй. Тэгээд Эльба мөрний эрэг тийш очлоо.

Дэлхийн төв уруу явах тухай профессорын дүгнэлтийг боломжтой гэж үзэж болох уу? Миний саяын соссон зүйл солиотой хүний дэмийрэл үү, суут ухаантны сургууль уу? Аль нь худал, аль нь үнэн бэ? гэж бодож явлаа.

Нагацын гайхамшигт яриаг сонсож байхдаа зориг орж тийм аялалд даруйхан гараасай гэмээр болж байсан бол нэг цагийн дагаа:

-Шал дэмий. Үүнд үнэн магадтай зүйл алга. Тийм юм гэж ерөөсөө байхгүй. Нойр муугаас болж түүнд дэмий бодол төрж байх шиг байна гэж ганцаар ярьж явлаа.

Эльба мөрний эрэг дагаж явсаар Альтона орох замд хүрвээс Альтонаас Ханбург руу буцаж явсан хайрт Грюбентайгаа дайралдав. Аравхан алхаад хажууд нь хүрч очиход:

-Аксель! Чи намайг тосож ирдэг яасан сайн юм бэ? Үнэхээр таатай сайхан байна, ноёнтон минь! гэв.

Гэвч намайг харангуутаа сэтгэл тавгүй байгааг минь ажиж мэджээ.

-Юу болоо вэ? гээд гарыг минь шүүрэн атгахад, би:

-Юу болох вэ дээ. Граюбен минь гэлээ.

Миний үзэсгэлэнт Граюбен гуравхан үг сольж, хоёрхон агшин өнгөрөхөд хамаг учрыг ойлгожээ. Тэр, нэг хэсэг таг дуугүй болчихов. Гарыг нь илбэхэд ер чичрэхгүй байхыг мэдээд зүрх нь минийх шиг догдлохгүй байна шүү? гэж би баахан гомдсон боловч үнэндээ тийм биш байлаа. Бид нэг ч үг дуугаралгүй зуугаад алхам явлаа. Эцэст Граюбен:

-Аксель аа! гэв

-Юу вэ, Граюбен минь

Тийм бол туйлын сонин аялал болно доо гэв. Энэ үгийг сонсоод миний храмаг бие зарсхийв.

-Нээрээ, Аксель минь, эрдэмтэн хүний дүүд ёстой таарах жуулчлал мөн. Эр хүн ямар нэг томоохон үйл хэрэгт оролцож эрэлхэг зори гтойгоо харуулах хэрэгтэй. Хайрт Аксель минь, би та хоёртой хамт дуртайяа явах байна. Гэвч ядуу эмэгтэй та нарт тээр болно биз дээ.

-Чи нээрээ хэлж байнаа уу?

-Нээрээ! гэв.

Тэгэхэд нь юу болж байна даа! Би түүнд хайртай болоод салж чадахгүй байхад харин энэ бүсгүй намайг зоригжуулж тийм жуулчлалд яв гэж түлхэж байдаг гэж бодоод:

-Граюбен, маргааш болоход чи энэ хэлдгээ л хэлэх үү? Гэж асууваас

-Аксель минь, би маргааш ч гэсэн, өнөөдөр хэлснийгээ л хэлнэ гэлээ.

Бид зэрэгцэн алхсаар байлаа. Өнөөдрийн болсон явдал миний сэтгэл санааг бүрэн эзэмджээ.

“Гэсэн ч зургадугаар сар гартал бас өдий байна тэр болтол нагац маань газар доогуур хийх жуулчлалын тухай мартчихаж ч юу магад” гэд бодож явлаа.

Биднийг байшингийнхаа гадаа ирэхэд нэгэнт шөнө болсон байлаа. Би нагацыг хэдийнээ унтчихсан биз дээ гэж бодсон билээ. Гэтэл тэр унтах ч байтугай харин эд агуурч авчирсан хэсэг ажилчдын дунд ороод ийш тийш гүйж хашгичиж байна. Мартэ авгай маань ч бүр учраа олохоо больсон байв.

Нагац намайг хармагц:

-Хөөрхий, Аксель минь хүрээд ирэв үү! Чи өөрийн семоданыг ч зэхээгүй, миний бичиг цаасыг ч янзлаагүй байх юм. Тэгээд бас би аяныхаа богцны түлхүүрийг олохгүй байна... гэлээ.

Би мэл гайхаж юм хэлье гэвч хоолой зангираад:

-Бид аян замд гарах болж байгаа хэрэг үү? гэж арай хэмээн дуугарвал:

-Тэгэлгүй яах вэ. Хүү минь, чи зугаалж тэнэж л явна уу! гэв.

-Бид ингээд л явах юм гэж үү? гэж намайг нам дуугаар өгүүлэхэд

-Тийм, нөгөөдөр өглөө гарна гэлээ.

Би цааш нь юу ч сонссонгүй өөрийн бяцхан өрөөнд гүйж орлоо. Тэгээд тэр түгшүүрт нэгэн шөнийг арай ядан өнгөрөөж билээ. Өглөө нь Граюбен над хэлсэн нь:

-Аксель! Би нагацтай чинь удтал яриллаа. Энэ хүн эрэлхэг зоригтой хүн юм. Түүний чанар чамд удамшсан байх ёстой. Өөрийнхөө төлөвлөгөөг над ярьж, түүнээ

чухам яаж биелүүлнэ гэж итгэж байгаагаа ч тайлбарласан. Тэр, үүнийг лав биелүүлнэ. Ноён Лиденброк, та хочрыг ямар их алдар гавъяа хүлээж байна гэж санана вэ! Аксель минь гэв. Залуу бүсгүйн эдгээр үгс намайг зоригжуулав. Гэсэн ч одоо ингээд аян замд гарна гэхэд бас л итгэхгүй байна. Би Грюбенийг профессорын өрөөнд дагуулж ороод:

Нагац аа! бид үнэхээр аян замд гарах гэж байгаа юм уу? гэж асуухад

-Яагаад чи итгэхгүй байна? Аль болохоор хурдан гарах хэрэгтэй. Харин чи чемоданаа бушуу зэх! Гэлээ.

Би юу ч хэлэлгүй тасалгаандаа буцаж ороход Граюбен намайг дагалдан ирээд аян замд хэрэгтэй зүйлсийг маань нэгэн жижиг чемоданд хийж гарлаа. Тэр, манай хайгуул аяллын тухай их л тайвнаар элдвийг хүүрнэсээр сүлийн семоданыг зэхэж дуусмагц би гадагш гарав.

Мөн өдрийн туршид физикийн элдэв багаж, зэр зэвсэг, цахилгаан хэрэгслийг зөөж авчирчээ. Үүнийг хараад зарц Мартэ:

-Ноёнтон галзуураа юу! гэж надаас асуухад нь бид тийм гэж дохив.

-Тэр таныг бас хамт авч явах гэнэ үү?

-Тийм

-Хаашаа тэр вэ! гэхэд нь би газар уруу хуруугаар заав.

-Агуйд уу?

-Үгүй, түүнээс доош гэв

Ингэж байтал үдэш боллоо.

-Өглөө болтол баяртай. Өглөө зургаан цагт гарна гэж хэлээд нагац явчихлаа.

Би шөнөжин ёролгүй хар нүхэнд унаж байна гэж зүүдэлж хонов. Таван цагт сэрэхэд хамаг бие ядарсан, сэтгэл санаа үймсэн байлаа. Босож хоолны тасалгаанд орвол нагац хэдийнээ ширээнд суугаад хоолоо ихэд амтархан идэж байна. Би хоол идэж чадсангүй, гагцхүү нагацыг эгдүүцэн харж байлаа.

Таван цаг хагасын үед нэг том тэрэг хүрч ирэв. Бид түүгээр галт тэрэгний буудал хүрэх ёстой аж. Удаж төдөлгүй нагацын юмыг тэргэнд ачааллаа.

-Чиний чемодан хаа байна? гэж нагацын асуухад би:

-Бэлэн гэж дорой дуугаар хариулбал:

-Хурдан авчир, аягүй бол бид галт тэрэгнээс хожимдох нь байна гэв.

Хойш суух арга башир нэгэнт үгүй болжээ. Тасалгаандаа орж чемоданаа аван шатны гишгүүр дээгүүр гулсуулж хаяад араас нь өөрөө дагаж гэлдрэв.

Энэ үед нагац орон гэрээ яаж авч байх тухай Граюбенд тушаал заавар өгч байх бөгөөд залуу гуалиг бүсгүй ердийн тайван байдалтай чагнаж байлаа. Би тэднийг хараад:

-Граюбен гэж дуу алдвал тэр:

-Хайрт Аксель минь, яв даа. Энэ удаа чи намайг орхи од явсан ч эргэж ирээд эхнэрээ болгож аваарай гэв.

Би Граюбенийг тэвэрч үнсээд тэргэнд орж суухад морьд ухасхийн давхилаа. Зургаан цаг хагаст морин тэрэг буудал дээр ирж зогсов. Нагацын их ачааг буулгаж галт тэргэнд ачааллаа. Долоон цагт бид вагонд орж суулаа. Удалгүй бух тэрэг хөдөлж аян замдаа гарав.

Миний сэтгэл тайван бус хэвээр байв. Өглөөний сэрүүн агаар, галт тэрэгний

довтлох хурд, зам дагуу жирэлзэн өнгөрөх элдэв зүйлс энэ бүхэн над их тус боллоо.

Вагон дотор хоёулхнаа боловч бид юу ч ярилцахгүй явав. Нагац халаасаа байн байн тэмитэрч аяныхаа богцыг их л сэргэмжлэн анхаарч явахад би газар орны байдлыг ажиглаж байлаа. Гарсаар гурван цаг яваад тэнгисийн эргээс хоёрхон алхам зайтай орших Киль хотод ирэв.

Бид эндээс ачаагаа Копенгаген хотод явуулахаар болоод өөрсдөө уурын хөлөг онгоцноо шилжин суулаа. Гэвч “Елленора” нэрт хөлөг онгоц шөнө болтол эс хөдөлсөнд профессор Лидпенброк хөлгийн болон төмөр замын албаны хүмүүс, засгийн газрыг хүртэл харааж байдаг муу үгээ барсаар ийнхүү хүлээсэн есөн цагийг өнгөрүүлж билээ.

Эцэст “Елленора” онгоц хар утаа олгойдуулж сая нэг далбилзан хөдлөв. арван цаг арван таван минут болоход онгоц тэнгисийн харанхуй мандал дээгүүр хар хурдаар довтлон хөвж явав.

Дараа өдрийн өглөөний долоон цагт хөлөг Зеланди арлын Корсер хэмээх бяцхан хотод ирж зогсоход бид онгоцноос бууж дахин төмөр замаар цааш явлаа.

Данийн нийслэл хүртэл бүтэн гурван цаг аялах хэрэгтэй байв. Нагац шөнөжин нүд аньсангүй. Түүний тэсэж ядсан байдлыг харахад вагоныг хөлөө жийж байгаа болов уу! гэмээр санагдана.

Өглөөний арван цагт Копенгагенд ирлээ. Бид зургадугаар сарын хоёрт Рейкьявик руу гарахаар зэхэж байсан “Валькирие” хэмээх нэгэн бяцхан хөлөг онгоцноо байр авав. Нагац маань баярлаж.

-Сайн боллоо, маш сайн боллоо. Бэлэн зэхээний ийм хөлөг онгоц олдог байна шүү! Яасан сайн хэрэг вэ! Ямар аз вэ? Одоо өглөөний хоолыг идээд хотоор баахан явъя гэлээ.

Бид нэгэн франц ресторанд өглөөний хоол идлээ. Би тэгээд хүүхэд шиг хөөрч хотоор гүйж гарлаа. Нагац өөрийгөө албадан зугаалахдаа хааны ордон, суваг дээгүүр тавьсан үзэсгэлэнт гүр, бяцхан шилтгээн бүхий сайхан цэцэрлэг, усан буудал, цаз бэхлэлтийн алиныг ч сонирхсонгүй. Би хайрт хүнээ дурсан санаж, хөөлийн Граубен минь ийм алсад байх ч гэж дээ, эргэж харих цаг ирдэг болов уу хэмээн бодож явлаа.

Гэтэл оройдоо хүрсэн ороомог мушгимал шаттай тэнгэрт тулам өндөр гонхон цамхаг байхыг нагац үзэж:

-Үүн дээр гаръя гэхэд нь би

-Толгой эргэвэл яана? гэв.

-Өндөрт гарч дасах хэрэгтэй.

-Үгүй тэгээд... гэж намайг хулгахад:

-Явъя гэж би чамд хэлж байна шүү! Цаг алдаад яах вэ гэлээ.

Арга буюу түүний үгийг дагав. Манаач нь шатны түгжээг тайлж оруулахад бид шатаар өгсөж эхлэв. Нагацыг хурдан авирахад би араас нь баахан зүрх алдан дагаж явлаа. Удалгүй толгой эргэж эхэллээ. Зуун тавин гишгүүр явсны дараа:

-Би явж чадахгүй нь! Гэхэд нагац:

-Яв! яв! гэж шаардав.

Хонхны гонхон салхинд ганхах мэт санагдаад хөл зөөхийн аргагүй болж би шатан дээр өвдгөөр сөхрөөд бүүлд нь бүр элгээрээ гулсаж мөлхөж явахдаа орчин

тойрныг харахаас айж нүдээ тас анив.

Ингэж өгссөөр гонхны оройд арай хэмээн гарав.

-Эргэн тойрныг хараач, сайн ажигла! Энэ бол хөлгүй гүнд ороход чинь бас сургууль болно гэж нагац сургамжлахад би сая нүд нээлээ. Байшингууд няц даруулсан мэт дөрвөлжин хавтгай юмс болжээ. Толгой дэгүүр үлж нүүж алсад тосгон суурин, тэнгисийн ус харагдана. Бүх зүйл нүдний өмнө ив илхэн ажээ.

Цаг хиртэй толгой эргэв.

-Хоёул маргааш дахин гарна гэж профессор хэлэв.

Таван өдрийн турш энэ дасгалыг давтан хийхэд анхныгаа бодвол их дээрдсэн билээ.

Явах өдөр боллоо. Нагац Исландын эзэн захирагч ноён Трампе болон Рейкьявик хотын дарга ноён Финсен нарт өгөх баталгаатай захидлыг хүлээн авчээ.

Зургадугаар сарын хоёрны өдрийн өглөөний зургаан цагт манай ачаар "Валькирие" хэмээх онгоцноо ачиж хөлгийн ахмад биднийг дагуулан бидэнд зориулсан тасалгаанд оруулав. Хэдэн минутын дараа уул хөлөг онгоц буудлаас гарч одлоо.

-Хир зэрэг удаан аялах вэ? гэж ахмадаас асуухад:

-Арван хоёр өдөр гэж хариулав.

Бид сааталгүй сайн явсаар зургадугаар сарын арван гурванд Рейкьявик хотноо хүрлээ.

Нагац, маш урам зоригтойгоор тасалгаанаас гарч ирээд онгоцноос буухын өмнө намайг урдаа оруулан үүл манан бүрхсэн нэгэн өндөр уулыг хуруугаар зааж:

-Снеффельс тэр байна! гэж хэллээ.

Удалгүй бид Исландын газар дээр буув.

Бидэнтэй нэгэн генерал хувцастай хүн хамгийн түрүүнд учирсан нь тус арлын захирагч эзэн ноён Трамп өөрөө байлаа. Нагац түүнд тэдний явуулсан баталгаатай захидлыг үзүүлсэнд тэр профессор Лиденброкийг юу хүссэнийг гүйцэтгэхэд бэлэн байгаагаа мэдэгдэв.

Хотын дарга ноён Финсен ч биднийг найртай сайхан хүлээн авав. Рейкьявик хотын байгалийн шинжлэх ухааны профессор ноён Фридриксон бүр ч онцгой ялдавн эелдэг байлаа. Тэр хүн гурван өрөөтэй байшингийнхаа хоёр тасалгааг бидэнд зориулан гаргасан байв. Хотынхоо элдэв сонин ачааг маань харж байхаан гайхсан боловч бид дорхноо төвхнөж амжив.

-Сайн байна, Аксель минь, хэрэг бүтэж л байна. Ажлын хамаг хүнд нь өнгөрлөө гэж нагацыг хэлэхэд бид:

-Яагаад хамгийн хүнд нь гэж? гэж асуув.

-Тэгэлгүй яах вэ, одоо бидэнд гагцхүү дорогш ураадах л үлдээд байна.

-Та үнэхээр мэдэж байгаа бол сайн даа. Нэгэнт дорогш орвол буцаж дээш гарах ёстой болнхо гэж би бодож байна.

-Би тэр тухай ер санаа зовохгүй байна. Харж л бай! Цаг алдаад явах вэ? Би номын санд очлоо. Сакнусемийн тухай ямар нэг гар бичмэл олдож юу магад. Үзье гэж бодож байна.

-Тэгвэл би таныг иртэл хотоор жаал явах уу?

-Энд над сонирхох юм байхгүй. Иасландад сонирхолтой зүйл газар дээр биш харин газар дор нь бий гэж нагац хэлэв.

Би гадагш гарлаа. Рейкьявик төдий л ихгүй хот тул гурван цагийн дотор түүнийг орчинтой нь хамт тойрон үзэж амжлаа. Ой мод огтгүй ерөнхийдөө баахан уйтгалтай. Галт уулын гаралтай хад хясаа энд тэнгүй харагдана. Исландынхны байшингууд, нам жижигхэн ажээ.Гудамжинд хүн цөөн бөгөөд дайралдсан хүмүүсийн дотор инээмсэглэсэн царайтайг хүсэвч олдохгүй гэмээр.

Намайг эргэж ирэхэд нагац, ноён Фридриксон хамт хэдийнээ ирчихсэн байлаа.

Үдийн хоол бэлэн болжээ. Профессор хоолоо маш амтархан идэв. Тэгээд эрдэм шинжилгээний асуудлаар яриа хөөрөө боллоо. Лиденброк өөрийн зорилго төлөвлөгөөний талаа юу ч дуугарсангүй.

Ноён Фридриксон нагацаас:

-Номын санд очоод хэрэг бүтэв үү? гэж асуусанд профессор:

-Танай номын сан ч бараг хоосон юм юм байна шүү дээ гэв.

-Юу гэсэн үг вэ! Манайд найман мянган боть ном бий. Түүний дотор эртний скандинав хэлээр бичсэн ном олон бий.

-Тэгвэл тэр найман мянган боть чинь хаана байгаа юм бэ?

Ноён Лиденброк минь, цөм орон даяар тарчихсан. Манай энэ мөс цасны хуучин арлынхан тэдгээр номдоо их хайртай байдаг юм. Эндхийн тариачин, загачин бүхэн бичиг үсэг мэддэг учир тэдгээрийг уншицгаадаг. Бид ч номуудыг нэгээс нөгөөд дамжин явах нь зөв гэж боддог юм. Та маай номын сангаас ямар ном үзэж гэв? гэлээ.

Энэ асуулт бидний зорилгыг хөндсөн тул ах баахан түгдэрч байснаа.

-Ноён Фридриксон, би Арне Сакнусемийн захидлуудыг үзэх гэсэн юм гэж шийдсэн байдалтай хэлэхэд Рейкьявикийн профессор:

-Арне Сакнусем гэнээ! Арван зургадугаар зууны үеийн байгалийн их шинжээч, гарамгай алхимич, нэрт жуулчин уу? гэвэл ах:

-Тийм гэлээ.

-Исландын утга зохиол, шинжлэх ухааны алдрыг мандуулсан хүн шүү дээ.

-Таны хэлдэг үнэн.

-Тэр хүн маш алдартай, суут ухаантай гэхэд нь нагац,

-Таны, тэр хүний тухай сайн мэддэгийг үзлээ. Харин түүний бүтээлүүд ийн тухай ярина уу? гэв.

-Бидэнд түүний бүтээлүүд байхгүй.

-Юу гэнээ, Исландад уу?

-Тийм, Исландад ч гэсэн, өөр газар ч гэсэн байхгүй.

-Яагаад тэр билээ?

-Арне Сакнусем бол буруу номтон байсан учраас бүтээлий нь 1573 онд Копенгагенд шатааж устгасан юм гэхэд нагац маш их эгдүүцсэн байдалтай:

-Ухай даа, мөн ч болгож тавьж дээ! гэж ёжлов.

-За одоо дуусаа юу? гэж Фридриксон асуув.

-Дууслаа. Бүгд ойлгогдож, цөм илэрхий боллоо. Сакнусем яагаад зураг тэмдгээр нууцалсныг одоо би ойлголоо гэж санамсаргүй өгүүлтэл нөгөө профессор

өлгөн авя:

-Ямар нууц тэр вэ? гэж яаран асуулаа. Нагац тэвдэж:

-Нэг.. өнөөх... гэж түгдчихэд нөгөөдөх нь:

-Түүний ямар нэг баримт бичиг танд байгаа юм аа даа? гэв. Нагац сандарсан хэвээр:

-Үгүй... Би зүгээр бодоход... гэхэд эрхэм ноён Фририксон баялгийг судлахгүйгээр явахгүй байх гэж итгэж байна гэв.

-Тэгэлгүй яах вэ. Гэхдээ би үүгээр олон эрдэмтэд явж өнгөрсний дараа баахан хожигдож ирж дээ?

-Тийм нь ч тийм, ноён Лиденброк Эрдэмтдийн бүтээл шинжилгээ Исландыг судлахад их тус болсон л доо. Гэвч бас хийх юм бий шүү.

-Бий гэж та бодож байна уу?

-Тийм, өндөр сарьдаг уул, мөсөн гол, галт уул гээд л судлах зүйл зөндөө байна! Жишээ нь, тэртээ тэнгэрийн хаяанд сүндэрлэж байгаа уулыг хараач. Тэр бол Снеффельс гэдэг уул гэхэд нагац,

-Аан мөн. Снеффель гэв.

-Тийм, хүний хөл хүрээгүй шахам онгон галт уул байгаа юм.

-Санасан уул уу?

-Дэлбэрээгүй болсоор таван зуун жил болж байгаа гэдэг гэхэд нагац баярласандаа гуяа алгадан цовхрон шахаж:

-Аан тийм бий, тэгвэл би Сеффель... Фессель... юу гэлээ, тэр ууланд чинь геологийн судалгаа хийе байз гэвэл ноён Фридриксон:

-Снеффельс гэж засаж хэлэв.

Би нагацыг баярласнаа мэдэгдэхгүйг хичээж байхыг хараад инээдээ барьж ядан байлаа.

Таны яриаг сонсоод би бүр зогиг шулуудлаа. Бид тэр Снеффельс ууланд авирна. Түүний цаг тогоог ч судалж магадгүй нагацын хэлэхэд ноён Фридриксон:

Ажил их учраас би тан нартай хамт явж чадахгүй нь даанч харамсалтай байна гэвэл:

-Зүгээр зүгээр, бидний төлөө огтхон ч санаа зовох хэрэггүй. Би танюв чин зүрхнээс баярлаж байна гэж нагац яаран өгүүллээ.

-Ноён Лиденброк та, энэ галт уулнаас эхэлдэг тань маш зөв. Тэнд олон зүйлийн сонирхолтой ажиглалт хийх болно. Гэвч Снеффельст яаж очъё гэж бодож байна?

-Тэнгисээр явж...

-Тэгж болохгүй.

-Яагаад?

-Рейкьявикт нэг ч хөлөгр онгоц байдаггүй юм.

-Еэ, чөтгөр гэж...

-Тэгэхээр та нар эрэг дагаж газраар явж болно. Ингэж явахад нилээд хол боловч маш сонирхолтой.

-Мөн. Тэгвэл газар ч олох хэрэгтэй болох нь ээ.

-Би танд энэ арал дээр суудаг нэг итгэлтэй сайн хүн хэлж өгч болно. Тэр танд лав таашаагдана. Дани хэлээр тун сайн ярьдаг хүн.

-Би түүнтэй хэзээ уулзаж болох вэ?

-Маргааш явуулъя

-Маргааш уу, за за гэж нагац зөвшөөрөв.

Маргааш өглөө нь намайг сэрэхэд зэргэлдээ тасалгаанд нэг хүн нагацтай дүнгэр дангар ярилцан сонсоно. Би даруй босож тэдэн дээр орлоо.

Нагац, махлаг өндөр биетэй нэг хүнтэй дани хэлээр ярилцаж байлаа.н Тэр хүн үзтэл их бяртай нь мэдэгдэнэ. Том толгойтой, цэнхэр нүдтэй, ухаалаг бйрын тэр хүний урт үс, өргөн мөр уруу нь буужээ. Бүх байдал нь түүний налгар тайван занг илчилнэ. Бусдаас юу ч хүсэхгүй, аливаа зүйлд гайхаж хачирах тэвдэж сандрахаа больсон хүн бололтой. Исланд эр манай нагацын урам зоригтой яриаг дув дуугүй сонсож хөдлөлгүй сууна. Ханс Биельке хэмээх нэртэй дуу цөөн удаан хөдөлгөөнт ээ хашиг эр манай ирээдүйн газарчин балйаа.

¹ Ханс, бидний Снеффельс уулын хормойд орших Стапи хэмээх тосгонд хүргэх ёстой бөгөөд тэнд хүртэл долоо найман өдөр явах зайтай байв. Бид дөрвөн морь авч хоёрыг нь унаж нөгөө хоёрт ачаагаа ачих, Ханс дадсан заншлаар явган явах ёстой байлаа. Ханс эрдэм шинжилгээний эрэл хайгуулын үед нагацад үйлчилж долоо хоног тутамд гурван риксдалерийн¹ хөлс авна. Энэхүү мөнгөө гагцхүү бямба гаригийн орой бүр авахыг хатуу шаардсан билээ.

Ингээд бид зургадугаар сарын арван зургаанд аян замд гарахаар тволмогц Ханс даруй гарч одов.

Түүний гарсан хойно нагац:

-Энэ тун сүрхий хүн боловч чухам ямар үүрэг гүйцэтгэхээ мэдэхгүй л байна гэв:

-Биднийг бр газрын төвд... гэтэл нагац миний үгийг тасдаж:

-Тиймээс, Аксель минь бидэнтэй бүр газрын төвд хүртэл хамт явна гэлээ.

Аян замд гартал бас хоёр хоног үлдээд байв. Би энэ хугацааг элдэв юм цуглуулахад ашиглав. Тэгээд бид аппарат хэрэгсэл, зэр зэвсэг, хөдөлмөрийн багаж, идэж уух зүйлсийг тус тусд нь дөрвөн хэсэг болгон баглаж зэхэв.

Авч явсан багаж хэрэгслийн зүйл гэвэл:

1. Зуун тавь хүртэл градусын халууныг хэмжих хуваарьтай термометр. Энэ нь бидэнд нэг бол маш хэрэгтэй, эсвэл төдий л чухал биш байлаа. Хэрэв агаарын дулаан асар халуун болбол түүнийг хэмжихэд маш хэрэгтэй зүйл боловч харин эд бодис хайлж урсахаар халууныг бол хэмжиж чадахгүй байлаа. Үнэндээ тийм халуунд бид өөрсдөө мах шиг чанагдах байсан билээ.
2. Далайн төвшин дээрх атмосферын жирийн даралтаас илүү их даралтыг хэмжих чадах монометр. Газрын гүнд доошлох тутам атмосферын даралт нэмэгдэх ёстой билээ.
3. Ханбургийн цагаар тааруулсан хронометр
4. Хоёр луужин
5. Шөнийн дуран

¹ Риксдалер-нэгэн терел эртний зоос

6. Хурц гэрэл гаргах чадалтай хоёр цахилгаан аппарат.

Бас карабин буу, гар буу хошоодыг авлаа. Би анхандаа зэрлэг ан, араатантай дайралдахгүй атал буу зэвсгээр юу хийх вэ? гэж бодсон юм. Гэвч нагац зэр зэвсэгтэй явах гээд байлаа.

Хөдөлмөрийн багаж гэвэл, хошоод жад, зээтүү, торгон олсоор томсон шат, гурван төмөр саваа, сүх, алт, урт олс зэрэг байлаа. Эдний зөвхөн шат нь томоос том боодол болжээ.

Идэшний зүйл гэвэл м ахан борц, зургаан сар хүрэлцэхүйц хатаасан боов авлаа. Усны тухайд нагац булаг шанд олдоно гэж үзсэн юм.

Бас авч явахад тохиромжтой эмийн сан бэлдсэн билээ.

Нагац, тамхи, дарь, уулаа марталгүй нөөцөлж зургаан хос шинэ гутал базаав. Бас өдий төдий алт, мөнгөн зоос, цаасан мөнгө бүсэндээ хийж авч явах болов. Тэгээд нагац:

-Ийм гутал, хувцас, ачаа бараатай улс алс явахад ажрахгүй гэв.

Зургадугаар сарын 15-нд бүх бэлтгэлээ дуусгалаа. Бидний зочилсон айлын эзэн, профессор нагацыг ихэд хүндэтгэн Исланд нутгийн нэг сайхан зураг бэлэглэв. Энэ нь эрдсийн судалгааны ховор нандин зураг байсан

Сүүлийн оройг бид ноён Фридриксонтой сэтгэлийн үгс ярилцан өнгөрөөв. Би түүнд онцгой таашаагдсан бололтой. Харин шөнөдөө би тун муу унтлаа.

Өглөөний таван цагт босож яаран хувцаслаад гадаа гарав. Дөрвөн морь бэлэн болсонг байх бөгөөд Ханс маай ачааг ачиж дуусаж байлаа. Нагац тэг, ингэ гэж олон юм ярих боловч газар, ч, түүний зааврыг ер анзаарах шинжгүй байна.

Зургаан цаг болоход бүгд бэлэн боллоо. Ноён Фридриксон гарыг маань атгаж салах ёс гүйцэтгэсэнд нагац түүнд хариу талархал илэрхийллээ. Бидний мориндоо мордоход ноён Фридриксон аян замдаа сайн явахыг ерөөн хоцорлоо. Гарсан өдөр халуу ч үгүй, хүйтэн ч үгүй аян замд яг тохирсон өдөр байв.

Үл мэдэх орныг мориор чвж туулах нь надад тааламжтай сайхан санагаж сэтгэл тэнүүн явлаа. Сонин орноор жуулчин өндөр сүрлэг ууланд авирч, царцанги тогоо цармын ёроолд ороход аюултай юм юу байх билээ? Сакнусем ч үүнээс өөр зүйл хийгээгүй нь илэрхий хэрэг. Ийм хайгуул аялалд явалцдаг маань тун сайн боллоо. Дэлхийн голд хүрсэн нүхэн агуй байна гэдэг ч ёстой хүсэл хөрөөдлөөс цаашгүй биз! гэж бодогдоно.

Ханс ачаатай хоёр морийг хөтлөн, түрүүлээд хурдан хурдан алхална, Нагац бид хоёр араас нь дагалдаж явав.

Исланд бол мянга дөрвөн зуун бээрийн уудам дэвсгэр талбайтай атлаа зургаан түмхэн хүн оршин суудаг том арал билээ.

Рейкьявик хотоос гараад тэнгисийн эрэг дагаж явав. Хомс тачир өвстэй газраар дайрч өнгөрөхөд алс тэртээ тэнгэрийн хаяанд өндөр уулын бараа харагдана.

Морьд маань адгуусны заншлаар тэгш зам эрэлхийлнэ. Жижиг морин дээр бараатай гэгч нь лүгхийж суусан нагацыг харахад инээдэмтэй ажээ.

-Сүрхий амьтан шүү! Харав уу чи. Исландын морь тун ч ухаантай. Цас, шуурга, энхэл тонхиол газар, хад хавцал, мөсөн голын алинд ч торохгүй. Энэ янзаар бол өдөрт арван бээр явах юм байна гэж нагацын ярихад би:

-Бид ч тэгэх л байлгүй, харин газарч маань яадаг бол доо гэж хариулав.

-Бид ч тэгэх л байлгүй, харин газарч маань яадаг бол доо гэж хариулав.

-Би ч энэ тухай ер санаа зовохгүй байна. Тэр, явган явахыг огт хайхрахгүй байгаа даг аа. Хэрэв хэрэгтэй бол би морио өгнө гэлээ.

Удалгүй газар орны байдал хоосон цөл мэт боллоо. Хагас бээр хиртэй газар нэг ч хүн амьтантай дайралдсангүй.

Дахин хоёр цаг явсны дараа их тосгонд ирлээ. Ханс тэнд хагас цаг зогсож өглөөний хоолыг хуваарилав. Хооллох зуур нагац түүнээс олонх зүйл асуусан боловч тийм, үгүй гэхээс өөрхариулт сонссонгүй. Хооллож дуусмагц газарч дахин морьдаа хөтөлж цааш алхлаа.

Гурван цагийн дараа үдийн алддад Ежюльберг тосгонд ирж морьдаа амраалаа.

Тэндээс гарч амралгүй явсаар Хвальфиорд хэмээх хавцлын эрэгт орших Сорбоер гэдэг газар ирэхэд дөрвөн цаг болж байв. Гарсаар найман бээр явжээ.

Хавцал нь уужим, бидний очсон газраар хагас бээр өргөн бөгөөд ёроолоор нь ус шуугин урсана. Гурван мянган фут хиртэй өндөр% хүрэнөнгөт хадан хясаа усыг хашаалжээ. Энэхүү хавцлыг мориор гатална гэхээс миний айдас хүрэх бөгөөд “хэрэв эдгээр адгуус ухаантай бол гол гатлахыг огт хүсэхгүй биз” гэж бодогдоно.

Харин профессор өчөөүхэн ч тээнэгэлзэлгүй усны эрэгт тул очоод морио давирав. Гэвч морь толгой хаялан хөдлөхгүй зогсоно. Нагац гуядаад авлаа. Жижиг морь цочин ухасхиймэгц нагац мориноос шувтран эргийн чулуун дээр алцайн зогсож хоцров.

-Ээ! Муу турсага гэж явган хоцорсон ах хашгирахадгазарч, профессорын мөрийг ёворч:

-Farja гэв.

-Юу гэнээ? Юунд суух гэж? гэхэд

Ханс нэгэн завийг зааж:

-Дег гэлээ

-Зүйтэй, яасан сайн юм бэ! Явъя! Гээд нагац, газарч бид гурав дөрвөн морины хамт завинд орж зогсов. Цаг гаруй явж уг хавцлыг гаталлаа.

Тэндээс хагас цаг явад Гердар хэмээр тосгонд ирсэн билээ.

Бидний цагаар бол хэдийнээ шөнө болсон боловч жараг тавдугаар өргөрөгт орших Исланд нутагт зургаа, долдугаар сарын үед өдийд нар шингээгүй байдаг ажээ.

Би даарч, их өлсөж байлаа. Нэгэн тариачин бидэнд хаалгаа нээж өгөв. Гэрийн эзэн олон долоон ёс горим болсонгүй шууд гараа сарвайж дагаад яв гэж дохив. Байшин нь гал тогооны, ажлын, унтлагын, зочдын гэдэг дөрвөн өрөөтэй бөгөөд зочдын тасалгаа нь хамгийн тохилог нь ажээ.

Ганц цонхтой атугай ч танхим мэт уудас тасалгаанд биднийг оруулав. Тэнд хуурай өвс дэвссэн орнууд байна. Ийм тохитой газар ирнэ гэж ер бодоогүй байлаа. Гэрийн эзэн даруй гал тогооны дулаахан тасалгаанд орохыг урив.

Нагац найрсаг урилгыг яаран хүлээн авч явахад би ч бас түүнийг дагалдав. Гал тогооны өрөөний зуух нь эрт дээр цагийн маягтай ажэ. Голотны оронд тасалгааны гол дунд том чулуу тавьж, уур утааг гадагш гаргахын тулд тасалгааны адртт нүх гаргажээ. Гал тогооны өрөө нь бас хооллох тасалгаа болдог ажээ.

Тэнд орж очиход гэрийн эзэн мэнд мэдээд хацар дээр маань үнсэв. Түүний

дараа эхнэр нь мөн түүнчлэн үйлдэв.

Исланд эхнэр гал тогооны өрөөнд байга том жижиг нийлсэн арван есөн хүүхэд төрүүлсэн гэж ярихад би ихэд гайхаж тэдгээр олон шар толгойнуудыг бахан гунигтай харж байв. Бид хоёрын сайн байхыг мэдээд хүүхдүүд дороо дасаж гурав дөрвөөрөө мөр, өвдөг дээр гарч хөлийн хооронд орж суух зэргээр ноол эрхэлнэ.

Удалгүй хоол бэлэн болсныг мэдэгдэв. Яг энэ үед Ханс морьддоо мэжээл өгөөд орж ирэнгүүтээ:

-Сайн байцгаана уу? гэж хүүхдүүдтэй мэндлэв.

-Тэгээд сурамгай тайван байдлаар гэрийн эзэн, эзэгтэй, хүүхдүүдийг ээлж дараалан үнсэв.

Хорин дөрвөн хүн ширээнд сууж цөм багталцахгүй тул томчуудын зарим нь багачуулыг өвөр дээрээ авч, хоёр гурваар нь өвдөг дээрээ сулгав.

Биднийг шөлтэй хол, борцолсон загас, үнээний сүүгээр дайлав. Би өлсөж явсан учир ихэд амтархан хооллов. Оройн хоол идсэний параа цөи угыараао бэлтгэцгээсэн билээ.

Маргааш нь өглөөний таван цаг болж байхад Исланд тариачинтай салах ёс гүйцэтгээд Ханс хөдлөх дохи өглөө.

Гөрдэр тогоноос цаашлах тутам улам бүр эл хувь цөл болов. Байгалийн байдал ч нэн уйтгартай. Өвс ногоо огт үгүй болж ой мод, бут, сөөг, ан гөрөөс үзэгдэхгүй боллоо. Хааяа нэг шувуу бараан үүлэнд тултал хөөлч өмнө зүг нийсэж явах нь харагдана. Хэдэн устай хавцал, нэг том, хоёр нарийн голыг гратлав.

Өид эзэнгүй хоосон саравчин байшитнд хогодон даарч чичирсээр нэгэн шөнийг өнгөрөөв.

Дараагийн өдөр сонин хачин зүйл юу ч тохиолдсонгүй, ургамалгүй газар, уйтгат байгаль үргэлжилсээр л байлаа. Үдэш болоход зорьсон газрынхаа тал дунд орж Кресольбт хэмээх тосгонд хонов.

Зургадугаар сарын арван есөнд тэндээс гарч ганцхан бээр яваад газар бүрхсэн их лавтай газрыг бүхжээ. Тэдгээр уулс цөм сөнөсөн галт уулс боловч энд тэндгүй халуун булгаас уур савсаж байв. Тэр гайхамшигт сонин үзэгдлийг нэгэн хэсэг ажиглаад цааш явлаа. Таван бээр хүрэхтэй үгүйтэй газар Снеффельсийн хос цагаан оргил үүлэнд тулан сүндэрлэж харагдав.

Морьд маань замын бартаанд саатахгүй боловч миний бие туйлын их ядарчээ. Харин нагац эхний өдөр шигэ шулуун шийдэмгий байхыг харахад над бахдах сэтгэл төрнө. Газра ч гэсэн ба энэ аянг юманд тоохгүй энгийн зугаалга мэт үзэж буй бололтой.

Зургадугаар сарын 20-ны бямба гаригийн оройн зургаан цагт тэнгисийн эрэг дээр орших Бедрир гэдэг тосгонд ирлээ. Энд газар ч хөлсөө нэхэж нагац түүнтэй тооцоо хийв. Тус тосгонд суудаг Хансын гэрийнхэн өөрөөр хэлбэл авга ах, бүл дүү нар нь биднийг хүлээн авав. Эдгээр энгийн гүдэс хүмүүсийн эдргэд аян замын ядаргаа гаргах сайхан завшаан гарсан боловч нагац ядраагүй тул дараачийн өдөр аян замд дахин хөдлөх билээ.

Бид галт ууланд нэгэнт хүрсэн тул одоо түүнийг өргөн тэнэгэр хормойгоор яах боллоо. Профессор уулнаас нүд үл салгах бөгөөд “номготгохоор зорьсон сүмбэр их ууландаа хүрээд ирлээ” гэсэн шиг учиртай толгой дохин явна. Дөрвөн цаг явж Стапи

тосгонд хүрээд мори ны амыг татав.

Стапи бол хүрмэн чулуун хясаагаар хүрээлүүлсэн бяцхан хавцлын мухарт орших гучаад байшинтай томоохон тосгон бөгөөд хөрс шороо нь дан лав ажээ. Хүрмэн чулуу бол галт уулын гаралтай хүрэн бор өнгийн хад байдгийг хүн бүхэн мэдэх билээ. Байгалийн хүчин тэдгээр хадыг хүний гараар зассан мэт ер бусын тэгш, зөв дүрс хэлбэртэй болгожээ.

Стапийн хавь газар онц үзэсгэлэнтэй ажээ. Гучин фут өндөр хавцлын хана, эгнэсэн олон багана мэт ховилтон тогтсон агаад хоорондоо адилхан зайтай цоорсон олон дугуй нүхнүүдээр тэнгисийн ус цутган гоожно.

Манай уйтгарт аяллын сүүлч иймэрхүү байна.

Тосгоны гэлэн ламын жирийн нэг намхан байшингийн хаалганд ирж зогсвол нэг хүн гартаа лах барин ажил хийж байсан нь сайхь гэлэн өөрөө ажээ. Газарч түрүүлэн очиж учир байдлыг ярьсанд лам гэргийгээ дуудан биднийг дотогш дагуулан оров.

Зочдын тасалгаа нь тун хариугүй явцуу, тоос шороонд дарагдсаныг үзвэл гэлэн лам бүдүүлэг тариачдаас дээргүй суудаг бололтой. Нагацыг зорьсон ууландаа хүрч хэд хонох тухай тооцоолох зуур бид маргаашийнхаа аян замд бэлтгэв. Ханс морьдын оронд ачаа үүрэх гурван исланд хүн оллоо. Тэд биднийг уулын тогоо цармын ёроолд хүргэж өгөөд буцахаар тохиролцов. Энэ дашрамд нагац уг галт уулыг таван хуруу шигээ мэдэхийг хүсэж байгаагаа Хансад дурсав.

Ханс тонгойн сууна. Ууланд ч гарсан, өөр тийшээ ч одсон, арал дор ч орсон, дээгүүр нь ч явсан над ер падгүй гэсэн байдалтай байлаа.

Миний хувьд гэвэл би аялах зуур ирээдүйн тухай бодлоо бага зэрэг мартзанаснаа харин одоо нагацын үгийг сонсоод сэтгэл дахин түгших боллоо. Яах вэ? Профессор Лиденброктой тулаад үзэх үү? Гэх бодол төрөвч Ханбург хотод байгаа биш, Снеффельс уулсын хормойд нэгэнт ирчихсэн болохоор юу хийх билээ. Аймшигт бодол надаас үл салав. “За яах вэ бидний түрүүчин хүн үүнээс бол үзчихээгүй л юм газар, Снеффельс ууланд гарч тогоо амсрыг нь харъя. Гэтэл ингээд аялал дуусахгүй гэсэн. Хэрэв хөөрхий Сакнусем үнэн хэлсэн байгаад газар доор орох зам олдвол яана. Галт уулын доогуурт агуй хнүхэн дотор дуусна гэсэн хэрэг билээ. Снеффельсийг 1229 оноос хойш дэлбэрээгүй сөнөсөн галт уул гшэж ярьжгаац байсан. Гэвч дахин сэргэж болно шүү дээ. Тэгвэл бид юу болох вэ дээ? гэж бодогдлоо.

Шөнө унтахдаа галт уул дэлбэрч байна гэж зүүдэлж тавгүй хонолоо.

Эцсийн эцэст би манай энэ аялал ерөөс бүтэшгүй хоосон санаархал гэж нагацад хэлэхээр шийдлээ. Тэгээд өөрийн санасан бодсоныг яривал тэр:

-Би ч бас бодож л байна –гэж ердийн байдлаар хариулав. “Энэ у гэсэн үг вэ? Төлөвлөгөөнөөсөө буцах гээ юм болов уу? Ээ, үгүй байх” гэж би бодлоо.

Нагац хэсэгхэн зуур дуугүй байснаа:

-Би энэ талаар бас бодож байна. Стапи тосгонд ирснээс хойш сүрхий асуудал намайг зовоох болсон юм. Снеффельс уул таг чимээгүй болсоор зургаан зуун жил болсон чдуугарах цаг ирж болно шүү дээ. Тийм үзэгдэл галт уулын дэлбэрэлтийн түхэнд олонтаа тохи олддог юм. Би нутгийн хүмүүсэс ч асуусан, өөрөө ч хөрс шороог шиншиж үзлээ. Ингэхлээр, Аксель минь галт уулыг дэлбэрэхгүй гэж чамд батлан хэлье гэв.

Ийм хариулт сонсоод цочсондоо би маргаж эсэргүүцэх үгээ ч олсонгүй. Үүнийг ажиглаад:

-Чи миний үгэнд эргэлзээгүй биз? Их сайн байна Явъя! Гэлээ.

Би даруй түүнийг дагалаа. Профессор байшингаас гарангуут тэнгисийн эргэс алслан холдох зүгийг барин явсанд удалгүй эзгүй хээр боллоо. Газрын байдлыг ажиглаваас галт уулын чулуун мөндөрт балбуулсан бололтой үзэгдэнэ. Энд тэнд халуун булгаас цагаан уур агаарт суунаглах нь галт уулын газар доорхи ажиллагаа хэвээр байгааг гэрчлэх бөгөөд миний болгоомжлолыг батлах мэт ажээ.

-Чи энэ утаануудыг харж байна уу! Галт уул дэлбэрэх аюулгүй гэдгийг баталж байна, Аксель минь гэхэд нь би:

-Яагаад? гэв

-Яагаадтэр вэ? гэвэл уулын амсар тогоотой холбоотой эдгээр бүлгийн уур утаа галт уул дэлбэрэхийн өмнөхөн улам хүчтэй оргилж ирээд чухам дэлбэрэх үед нь алга болдог юм. Ууг, агаараас хүнд учир уулын царамд тунаж суунаглах нь зүйн хэрэг. Иймд галт уул дэлбэрэх цаг болоогүй гэдгийг чи аяндаа мэднэ гэжээ.

-Тэгвэл... гэж маргах гэтэл нагац тасдаж:

-За боллоо. Нэгэнт шинжлэх ухаан нотолсон зүйлийг бид юу гэх вэ! гэлээ.

Нагац ийнхүү шинжлэх ухаанаар гул барьж надад цохилт өгсөн тул би уруу царайлсаар буусан газартаа буцаж ирлээ. Гэвч уулын тогоо цармын ёроолд доод орсон нүх байхгүй байж магадгүй гэсэн найдвар бас л байсаар байлаа.

Шөнө турш газар дор галт уулын дэлбэрэлт дунд орсон байна гэж хар даран зүүдэлж хонов.

Дараагийн өдөр зургадугаар сарын 23-нд Ханс идэш хоол багаж зэвсэг, шинжилгээний хэрэгслийг үүрэх нөхөдтэйгөө биднийг хүлээж байлаа. Бид хоёр тус бүр нижгээд саваа, бууг, долоо хоноги йн усны нөөцний хамт авлаа.

Өглөөний есөн цаг болов. Гэлэн лав, гэргийн хамт бидэнтэй салах ёс гүйцэтгэх гэж хаалгын дэргэд хэдийнэ хүлээн зогсож байв. Ламын өихөрсөн муу байшин, ядуу даржин байдал нь мартагдашгүй сэтгэгдэл үлдээж билээ.

Дэлхийн төвд очих гэж яваа хүнд үнэ хаялцах хэрэг байсангүй тул нагац юу ч хэлэлгүй хоногийн хөлсийг төлөв. Хэдэн минутын дараа Ханс хөдлөх дохио өгч бид Стапи тосгоноос гарлаа.

Снеффельс бол хоёр оргилтой таван мянган фут өндөр уул билээ. Уулын орой цасанд хучигджээ.

Өгсөх зөрөг хоср хүн зэрэгцэж болоохгүй нарийхан бөгөөд бие биетэйгээ элдвийг хөөрөлдөн явах аргагүй тул газарчаа тэргүүд гаргаад үхэрчлэн цував.

Би профессор Лиденброкийн үнэнч зээ болохоор эрдсийн байдлыг сонирхон ажиглахын хажуугаар Исланд орны геологийн бүх түүхийг дурсан санаж явлаа. Исланд бол уснаас цухуйж гарсан галт уулын бөсөл чулуу буюу шороо чулууны бөөгнөдсөөс бүтсэн аралт ажээ. Уг арал дэлхийн дотоод хүчний нөлөөгөөр далайн мандлаас дээш өргөгдсөн байна. Хожим арлын баруун урд зүгээс баруун хойд зүгийг чиглэсэн өргөн ан гарчээ. Тэр ан цаваар дэлхийн дотоод гүнээс хайлмаг чулуу нэвтчин гарч хавийн газрыг бүрхсэн боловч яваандаа хөрч царцсан ажээ. Гэвч газар дор асар их хэмжээний хий хуримтлагдаж зузаан хөрсийг дороос түлхэн цөмөлснөөс галт уул дэлбэрч түүний орой дахь царам тогоо үүсдэг байна. Галт уулын олон

нүхүүдээр нь лав, бөсөл зэрэг халин урсаж уулыг бүрхэн хучдаг байна.

Дэлхийн дотоод халуун хайлмагийн үйлчилгээ хүчтэй болох бүрд тохиолддог чухамхүү тэр үзэгдлийн дүнд Исланд арал үүсчээ. Байгалийн ийм үйлдэл одоо ч бий. Ингэхлээр галзуурсан хүн л дэлхийн төвд хүрэх гэж санаархах бизээ! Гэж бодогдоно...

Зам улам эгц болсоор байх тул нисэж үхэхгүйг хүзн бүр мэрийх хэрэгтэй боллоо. Гагцхүү Ханс л тайван байдалтай алхална.

Гурван цаг яваад у уулын бэлд арай ядан хүрлээ. Ханс зогсох дохио өгч бид өглөөний хоол идэцгээв. Хурдан явахад хүч авах гэж нагац нилээд юм идээд жаахан амрах гэтэл нь ганцхан цаг блоод газарч хөдлөх дохио өгөв. Гурван Исланд хүн ч үг дуугарсангүй.

Снеффельс уулын хажуу өөд мацаж эхлэв. Гишгэсэн чулуу ховхрон өнхөрч тэртээ хорм ойд унана. Хүрэх газар хүртэл хичнээн цаг явж яаж үйлээ үзнэ дээ! Нагац намайг уулын орой хүрч чадахгүй нь гэсэн бололтой хараанаас үл салган дэргэд минь үргэлж дагаж түшиж дэмжиж явлаа. Ядарч м ацсаар нэгэн цаг хир яваад байх үед их цасан хөнжлийн унд чёулуун шат мэт зүйл азаар дайралдав. Тэр шат хүч их хэмнэж чулуун гишгүүрийг дамжин нилээд хурдан явах боломж олгов. Оройн долоон цаг болоход шатаар хоёр мянган алхам өгссөр байлаа.

Гурван мянган хоёр зуун футийн зайтай тэртээ доор тэнгисийн усан цэлийн харагдана. Мөнхийн үүл манангийн заагийг нэгэнт нэвтрэн туулжээ. Хүйтэн жавар сэнгэнэж салхи хүчтэй үлээх болов. Би туйлын их² ядарч байлаа. Профессор хөл дээрээ тогтож ядан байхыг минь хараад газарчид зогсох дохио өгвөл нөгөөдөх толгой сэгсрэн:

-Ofvanfor гэхэд нагац:

-Бушуухан дээшилье гэнээ! гээд зогсож амрах тухай Хансад давтан тайлбарлаж хэлэхэд:

-Mistour гэж хариулав. Энэ үгийг сонсоод ачаа үүрэгч исландуудын нэг нь ихэд цочиж айсан байдалтай

-La, mistour гэж давтан хэллээ.

Би гайхаж:

- Mistour гэж юу гэсэн үг вэ? гэж асуухад нагац шуудхан:

-Чи хараач! гэлээ.

Эргэж уулын хөндийг харвал тэнд элс чулуу, шороо тоос хуйлран хийсэж салхины аясаар наашаа дөхөж харагдав. Төдхөн шороон хөшиг нар халхлан, бүрхэг харанхуй болгов. Энэ гайхамшигт үзэгдлийг исланд Mistour гэдэг ажээ.

-Hastigt, hastigt гэж манай газарч хашгирна. Исланд хэл мэдэхгүй боловч Хансын хойноос хоцрохгүй дагалдах хэрэгтэй болж гэдгийг ойлголоо. Газарч уулын тогоо царам бүхий шовх оройг ороож хажуу тийшээ явлаа. Mistour гэдэг өнөөх угалз салхи даруй ууланд хүрч ирлээ. Галт уулын дэлбэрэлт газрын чулуу мөндөр бороо шиг агаарт ниснэ. Аз болоход уулын нөмөр талд гарч амжсан тул аюулаас зайллаа. Сайн газарчгүй бол чулуун бороонд няц цохиулах байсан билээ.

¹ “Шенийн парны” билэг туяа гэж хойд туйлын туяаг хэлж байна (орчуулагч)

Муруйж тахирласаар уул өөд цааш өгсөв. Үлдсэн 600-гаадхан фут газрыг бүтэн таван цагийн турш явж билээ. Би өлсөж даарч, ядарч бас агаар дутагдсанаас унан тусан явлаа.

Хав харанхуй болж оройн арван нэгэн цагийн үед бид арай хэмээн Снеффельс уулын оргилд хүрлээ. Тэртээ дор нойрсон байгаа арлыг “Шөнийн парны”¹ бүдэг туяа, гийгүүлэнхэн авай.

Манай бяцхан бүлэг хоолоо түргэхэн идээд бль болох тухтайгаар амарч хэвтэцгээлээ. Далайн төвшнөөс дээш таван мянган фут хиртэй өндөрт байр тух муутай, хэвтэх газар ч хатуу явширган байж билээ. Гэвч би бөх унтаж зүүд ч зүүдэлсэнгүй хонолоо.

Дараагийн өдөр тунагалаг нарны туяа уулсын оройд тусахад сая нойрноос сэрцгээв. Хадан орноос үсрэн босож тэртээ дор харагдах гайхамшигт үзэгдлийг бахдан сонирхов.

Снеффельс уулын өмнөд оргилын орой дээр гарсан би тэндээс арлын ихэнх хэсгийг, хотгор гүдгэрийг ялгасн газрын зураг дэлгэсэн мэт ив илхэн харж байлаа. Уудам хөндий, гуу жалга, гол горхи, нуур цөөрөм тодорхой үзэгдэнэ.

Баруун гар талд мөсөн голууд, тоо томшгүй олон шовх оргил, зүүн талд хязгаар хярхаггүй уудам газар, мяралзан долгилох эх төгсгөлгүй далай цэлийнэ. Оргилын өндөрт гарсандаа сэтгэл хөөрч толгой ч сэргэсэнгүй.

Нүдний харц тунгалаг нарны шижир туяанд гялбаж хаа байгаагаа мартаад скандинавын үлгэр домогт гардаг лус савдагуудын оронд очсон мэт байлаа. Гагцхүү профессор, Ханс хоёрыг ирэхэд үнэн байдлаа сая ухааран мэдэж билээ.

-Бид Снеффельс уулын оройд гарлаа. Хоёр оргилын нэг нь урд, нөгөө нь тэр хойно харагдаж байна. Бидний дээр нь зогсож байгаа энэ оргилын нэрийг Ханс хэлж өгнө гэж нагацын ярихыг сонссон газарч даруй

-Скартарис гэж хариулав.

Нагац бахдан баярласан байдлаар намайг хаааад

-Түүний тогоо царамд очъё гэлээ.

Снеффельс уулын тогоо нь хөндлөнгөөр хагас бээр, гүнээр хоёр мянган фут ажээ. Төдий л уудам бус ёроолд хүэрэх хана нь хэлтгий намуу учир доош буухад хялбар байлаа.

Хансыг надад ялгаа алга гэсэн байдлаар бяцхан багийн тэргүүнд гарч цааш явахад би юу ч дуугаралгүй түүнийг дагалдав. Доош буухад амрыг бодон налуу хажууг ташиж уруудав. Хад цохионы дундуур яваад хааяа хөлөөр ховхорсон чулуу их чимээ гарган доош унана. Заримдаа дотогш буусан мөсөн гол дайралдах бөгөөд үүнд Ханс төмөр саваагаархөрсийг атган тэмтэрнэ. Бид нэгийгээ доош унахаас сэргийлэн бие биеэ урт олсоор холбож уяв.

Уруудан буухад хэдий бэрхтэй боловч осол эндэлгүй явсаар үдийн алдад ёроолд хүрч буудаллаа. Дээш харвал тэртээ дээр тогоо цармын ёроолд гурван нүх онгойн үзэгдэнэ. Снеффельсийн дэлбэрэх үед тэндээс лав урсан, уур утаа савсан хөөрдөг байжээ. Нүх тус бүрийн амсар хөндлөнгөөр зуун фут орчим өргөн байв. Эдгээр нүхний хооронд нааш цаашаа харайлгана. Ханс нөхдийнхөө хамт лавын хэлтэрхий дээр суугаад түүнийг галзуурчээ гэсэн байдалтай харж байлаа.

Нагацын гэнэт их дуугаар хашгирахад би нүх уруу ойчив уу гэж бодов. Гэтэл тэгсэнгүй. Харин хонхорын гол дунд байсан нэгэн цохио хадны дэргэд зогсоод ихэд баярлаж гайхсан байдлаар

-Аксель! Аксель! Нааш ир! Нааш ир! гэж дуудаж байв. Гүйж очвол а

-Үүнийг хар! Гэв. тэр хадан дээр

гэсэн өнөөх ёрын муу зураасан тэмдэг бичээстай байхыг хараад би нагацын адил гайхаж билээ.

-Арне Сакнусем гэж байна. Чи үнэмшихгүй байна уу? гэж нагац хашгирна.

Би юу ч дуугарсангүй сууж байсан газар руугаа эргэж явлаа. Энэ явдал санаа бодлыг дахин үхүүлэв. Хэдий болтол гүн бодолдавтагдан сууснаа мэдсэнгүй. Нэг мэдэхнээ нь ачаа үүрэгч исланд хүмүүс алга болоод тогоо цармын ёроолд нагац Ханс хоёр хоёулхнаа үлсдэн байв.

Ханс цохио хадны хажууд нойрсож байх бөгөөд харин нагац торонд орсон зэрлэг араатан шиг холхин эргэлдэнэ. Би босъё ч гэж бодсонгүй хэвтсээр гүн нойронд дарагдан унтав.

Тэр шөнийг тогоо цармын ёроолд өнгөрүүлэв.

Маргааш нь уулын шовх оройг үүл бүрхэж тэнгэр тугалган хөх өнгөтэй болсон байв. Нагац хилэгнэж байх бололтой. Харин надад үл мэдэг найдвар төрж ирлээ. Яагаад вэ? гэвэл хажууд байгаа гурван нүхний зөвхөн нэгээр нь л Сакнусем орсон байх ёстой билээ. Нууц бичигт зургадугаар сарын хуучдаар Скартарисын сүүдэр түүнийг дайрна гэжээ. Одоо тэнгэр бүрхсэн тул сүүдэр ч үгүй, баримжаалах чиг ч үгүй болжээ. Тэр өдөр зургадугаар сарын 25 байсан юм. Хэрэв зургаан өдрийн турш тэнгэр бүрхэг хэвээр байвал бичигт өгүүлсэн учралыг дараагийн жил хүртэл хойшлуулахад хүрэх байлаа.

Нагацын уурыг дарж тайвшруулах ямар ч бололцоо байсангүй. Тогоо цармын ёроолд ашгүй сүүдэр тусангүй өдөр өнгөрлөө. Ханс байрнаасаа ер хөдөлсөнгүй. Нгац дуу шуугаа хурааж гагцхүү тугалган өнгөт тэнгэрийг л ширтэнэ.

Зургадугаар сарын 26-нд өдөржингөө бороо асгаж бас ч ямай өнгөрөв. Ханс лавын хэлтэрхийгээр нэг оромж мэтийг барьжээ.

Дараагийн өдөр тэнгэр бузгай бүрхэг байснаа зургадугаар сарын 28-нд цэлмэв. Тунгалаг нарны туяа тогоо цармын ёроолыг гийгүүлж хад чулуу бүрийн сүдэр газар буув. Скартарисын сүүдэр зураг нэг зурайж нарны аясаар аажимхан нүүнэ. Нагац сүүдрийг даган эргэлдэнэ.

Жин үдийн алдад уулын сүүдэр гал дахь нүхийг бүрхээд ирлээ.

-Энэ байна! Энэ байна! гэж профессор хашгирав. Дэлхийн төв уруу орьё гэж дани хэлээр нэмж хэлэв.

Би Хансыг харлаа. Газарч

-Forut! Гэж тайван өгүүлэхэд нагац:

За явъя гэлээ.

Жинхэнэ жуулчлал маань эндээс эхэллээ. Хүнд бэрх бүхэн тулгараад ирлээ. Нүхэн дотор ороод хаашаа явах нь мэдэгдэхгүй байлаа. Цааш нь явахгүй гэж татгалзаж болох байсан боловч Хансын ер бусын тайван байдал, яахав гэсэн янзтайг хараад

түүнээс зориг дутуу байгаадаа ичих шиг боллоо.

Тэрхэн зуур би ард хоцорсон хайрт хонгор бүсгүйгээ нэгэнтээ дурсан санаад голын нүхний амсартай дэмий очив. Нүхний өргөн хөндлөнгөөр зуун фут аж. Нэгэн хадыг түшин хөндий хар нүх рүү өнгийж харахад оройн үс босож толгой эргээд дайвалзан унамаар болтол нэг хүн намайг барьж авлаа. Энэ бол Ханс байжээ.

Нагац 400 фут урт бүдүүн олсны эвхээсийг задлан нэг үзүүрийг нүх уруу унжуулж талд нь хүртэл явуулаад голоор нь нэгэн багахан шиг хадыг ороож үлдсэн нөгөө хагасыг нүх уруу дахин шидэв. Ийнхүү хүн бүр олсны унжсан хоёр хэсгээс барьж буух болсон бөгөөд хөл гишгэх газар хүрмэгц нэгэн үзүүрийг тавьж нөгөө үзүүрээс татан олсоо хурааж авах ёстой байлаа.

-Одоо ачаагаа өөрсдөө авч явна. Хэдүүл эмзэг багаж хэрэгслээ гурван хэсэг хуваан баглаж тус бүрдээ үүрнэ. Ханс тө хөдөлмөрийн багаж хоол ундны зүйлийг Аксель буу зэвсгээ ав. Нарийн хэврэг хэрэгслээ би авъя гэж хэлэхдээ зоригт эрдэмтэн бидний амь насыг эмзэг зүйл гэж үзсэнгүй бололтой.

-Тэгвэл хувцас хунар, энэ их олс, шат зэргийг яах вэ? гэж асуухад:

-Тэд өөрсдөө бууна биз! гэвэ:

-Яахыг нь чи өөрөө үзнэ гэж хариулав.

Ер нь шийдсэн мэх хэрэглэх явдал нагацад олонтоо тохиолддог байлаа. Энэ удаа ч тэрээр бөөгнүүлж багласан хувцас хунараа нүх уруу зүгээр л хаялж орхиод хойноос нь санаа амарсан байдалтай өнгийж:

-Одоо бидний ээлж боллоо гэв.

Үүнийг сонсоод хэрхэн эмээхгүй байх билээ!

Буух цаг нэгэнт болжээ. Ханс түрүүлж нагац дараалаад би хамгийн сүүлд орлоо. Ду дуугүй таг чиг явав. Би нэг гараар хоёр олсыг байдаг чадлаараа давхарлан атгаж нөгөө гартаа төмөр саваа барьж явлаа. Олс гурван хүнийг даахгүй тасармаар санагдана.

Хагас цагийн дараа нүхний гол дундах нэг хаданд хөл хүрмэгц зогсов. Ханс олсоо татаж аваад дахин доргош шидэхэд түүний хамт нурсан чулуу мөндөр шиг нижигнэн унах нь сонсогдов. Доош харвал нүдний ёроол эс харагдав.

Дахиад л цаашаа дүүжигнэн буулаа. Хагас цаг болсны дараа дахин хоёр зуугаад фут доошилжээ. Хэдийчинээ доошлох тутам миний сэтгэл төдийчинээ тайвширч байна. Төвийн халууны тухай үзэл бүрмөсөн яцаагдана. Өид үүнийг нүдээр үзнэ гэж надад ярьсныг бодвол нагац доош буух зуураа ажиглалт шинжилгээ хийхээр яваа нь маргаангүй байлаа. Үүнд би түүнтэй маргах чадалгүй байсан нь ойлгомжтой биз ээ. Бид доошилсоор л байв.

Гурван цагийн турш явахад нүхний ёроол мэдэгдэхгүй л байв. Дээш харвал алс өндөрт тэнгэрийн өчүүхэн хэсэг үзэгдээд нүхэн дотор улам улам харанхуй болж байлаа. Гэвч зогсолтгүй доошилно.

Хагас цаг бүр арван таван минут амарч арван өрвөн удаа аяллаа дахин үргэлжлүүлж байсныг бодвол долоон цаг явж гурван цаг хагас амарсан байх бөгөөд бүгд нийлээд арван цаг хагас болжээ. Иймд анх өдрийн нэг цагт гараад одоо оройн арван нэгэн цаг хүртэл явахад хоёр мянга найман зуун фут гүнийг туулсан байх ёстой.

Яг энэ үед Ханс:

Halt гэв.

-Хүрээд ирлээ шүү бид! гэж нагацын өгүүлэхэд:

-Хаан? гэж би асуув

-Эгц нүхний ёроолд! гэж нагац хариулаад

-Баруун гар талд байгаа тэрхонгилоор маргааш орно. Одоо оройныхоо хоолыг идээд унтацгаая гэлээ.

Даруй аяныхаа богцыг нээж хоолоо идээд лав чулуун дээр хэвтэцгээв.

Дээшээ харж хэвтээд ажиглавал гурван мянган футийн тэртээ дээр байгаа нүхний амсраар одод гялалзаж үзэгдэнэ. Удалгүй гүн нойронд дарагдан унтав.

Өглөөний найман цаг болж гэгээ орохоор бүгд сэргээв. Гэрэл нилээд хурц тусах учир орчин тойрныгоо харах боломжтой байв.

-Акесль, чи юу гэж бодож байна? Кенигстрессын гудамжин дахь манай муу байшинд шөнийн бор хоног чимээ чийр түр намдаад өглөө болохоордахиад л дуу шуугиан, орилоон бахираан болдог сан? гэж нагац алгаа үрэн хэлэхэд:

-Нүхний ёроод ч яриагүй тайван л байна. Гэхдээ энэ нам гүм ч нэг л аймшигтай байна- гэж би хариулав. Тэгэхэд нагац:

-Болж үз! Чи өдийд айж байж сүүлд юу болох вэ? Дэлхий дотор орох бас ч болоогүй байна шүү гэв.

-Тэгээд та юу гэх гээ вэ?

-Бид одоогоор арлын зөвхөн шороон хөрсийг нэвтэрч далайн төвшний тушаа ирээд байгааг хэлэх гэсэн юм.

-Нээрээ юу?

-Чи өөрөө барометрийн заалтыг хар л даа. Агаарын даралтын нэгж хэмжээнд л байна шүү дээ. За дэмий цаг алдаад яах вэ. Түрүүн шийдэж орхисон баглаатай хувцас хунар маань хаана байгаа бол? гэж Хансад хандаж асуухад нөгөөдөх нь:

-Der Hurre! Гэв.

-Дээр ий! нагац давтан хэллээ.

Үнэхээр боодолтой юмс биднээс дээш зуу орчим фут өндөрт хаданд өлгөгдсөн санжигнаж харагдав. Газарч исланд муур мэт шаламгай авирч хэдхэн минутын дараа тэнд хүрээд боодлыг бидний хажууд унагалаа.

-Одоо өглөөнийхөө хоолыг тавтай сайн идэж авъя. Сүрхий удаан аяллаа шүү гэж нагац өгүүлэв.

Хоол идсэний дараа нагац тэмдэглэлийн дэвтрээ авч багаж хэрэгслэлийн заалтыг тэмдэглэсэн нь:

Зургадугаар сарын 29. Даваа гариг.

Хронометр: өглөөний 8 цаг 17 минут

Барометр: 756 километр

Термометр: 6 градус

Луужин: (хонгилын чиглэлээр) зүүн, зүүн хойно зүгт гэжээ.

-Аксель Одоо дэлхий дотор орно. Эндээс жинхэнэ аяллаа эхлэнэ гэж нагац урам зоригтой хэлэв.

Нагац Ханс хоёр гэрэл гаргагч аппаратаа ажиллуулж бариад аян замдаа орлоо. Хүн бүр тус тусын боодлыг авсны дараа Ханс баглаатай хувцас хунарыг

нэмэн авч урдаа тэврээдхонгил руу орцгоов.

Энэхэн мөчид “хөх тэнгэрийг дахин хэзээ ч харахгүй боллоо” хэмээн толгой өргөж исландын тэнгэрийг эцсийн удаа харлаа.

Дотор тал нь нэлэнхүйдэ хайлмаг лааар бүрхэгдсэн дөчин таван градусын налуу хонгил нүх нь явахад хальтарч өнхрөх аюулгүй байлаа. Хонгилын хананд шохой ургж цан хөөрөг шиг харагдаад гялалзсан болор талст, бөнжийсөн шилэн дусал гялтганан туяарах нь нүхний эзэд газрын гийчдийг угтан авах гэж орд харшаа гэрлээр чимэглэсэн мэт ажэ.

-Ямар гоё, яасан үзэсгэлэнтэй юм бэ? Хүрэн улаан байс наа хурц шар болон хувирч байгаа лавын солонгорох өнгийг та хараач. Гялтганах болорын туяа ёстой тэнгэрийн оддыг санагдуулах биш үү? Гэж намайг дуу алдваас:

-Эш ш! Миний дүүд энэ бүгд тийм сайхан харагдав уу? Үүнээс ч илүү гоё юмыг яваандаа үзнэ гэж би найдаж байна. Яваад бай! Яваад бай! Гэж нагац хариулав.

Бид налуу газраар зогсолтгүй уруудсаар бөгөөд луужин ямагт зүүн хойд зүг заасныг үзвэл хонгил нү тэр зүг шув шулуун үргэлжилжээ. Термометрийг хичнээн харавч халууны хэмжээ тун ялимгүй нэмэгдэж бүтэн хоёр цаг болоход дөнгөж 10 градусаас үл хэтэрсэнд бид доошоо биш хажуутийшээ тэгш шахам явж байгаа юм байна гэж бодлоо. Нагац профессор янз бүрийн судалгаа шинжилгээ тасралтгүй ажиглалтаас ямар дүгэлт гарч байгаагаа хэнд ч хэлэхгүй дотроо чанд хадгалж явлаа.

Оройн найман цагийн орчим зогсох дохио өгөв.Цэнгэг агаартай уудам агуйд иржээ. Туйлын их өлсөж ядарсан учраас цэвэр агаар хаанаас орж байна вэ? гэдгийг бодох ч тэнхэлгүй байлаа. Долоон цаг зогсолтгүй уруудахад тэнхээ тамир бүр алдарчээ. Зогс гэсэн үг үнэхээр тааламжтай сонсогдож билээ. Ханс идэж уух юм гаргаж чулуун дээр тави хад цөм ихэд амтархан хооллолоо. Гэвч усны нөөц бага болж байсан нь намайг түгшүүлж байв. Нагац, газар дор булаг дайралдан гэж итгэвч одоо болтол юу ч олддоогүй тул түүний анхаарлыг би энэ асуудалд хандуулсан юм.

-Бидэнд дөнгөж таван өдөр хэрэглэх ус үлдлээ гэж хэлэхэд нагац

-Сэтгэлээ бүү зов. Аксель минь, ус олноо гэв.

-Хэдийд

-Лаван хөрсийг өнгөрөхөөр олноо. Лавын ханыг булгийн ус нэвтэлч чадахгүй байгааг чи мэдэхгүй байна гэж үү?

-Лав, газрын маш гүнд хүртэл үргэлжилж мэднэ шүү дээ? Миний бодоход бид эгц доошоо төдий хол яваагүй байх

-Яагаад чи тэгж бодов?

-Их дор орсон болхалуун улам ихсэх ёстой биз дээ?

-Чиний үзлээр бол тийм л байх. Тэгээд термометр юу гэж зааж байна?

-Дөнгөж арван таван градус

-Нээрээ юү?

-Энэ байна. Зарим хүн газрын гэнд зуун фут доошлох тутам нэг градус халуун нэмэгдэнэ гэдэг юм. Гэвч тодорхой нөхцөл энэ хуваарийг өөрчилж болно. Жишээ нь: Сибирийн Якут нутагт гучин зургаан фут бүрт нэгградус нэмэгддэг байна. Галт уулын хавь газарт бол халуун зуун хорин таван фут доошлох тутам сая нэг градусаар ихэсдэг ажээ. Бид сүүлийн таамналыг баримтлан тооцоолж болох юм-гэж нам

айгхэлэхэд нагац:

-Тооцоол, тооцоол хүү минь! гэлээ.

-Тооцоолоход ядах юм алга гэж хэлээд би тэмдэглэлийнхээ дэвтэрт хэдэнх тооц бичиж,

-Зуун хорин таван футыг ес дахин авахад гүний хэмжээ мянга нэг зуун хорин таван фут болно гэхэд нагаж:

-Зөв гэлээ.

-Мөн биз дээ?

-Мөн чмөн. Гэхдээ миний ажигласнаар бид далайн төвшнөөс доош арван мянган фут яваад байна.

-Тийм байж болох уу даа?

-Тиймээ. Тоо, тоо байхаа болиогүй л бол болно! гэж нагац хэлэв. _

Профессор тооцоо үнэхээр мадаггүй байлаа. Учир нь: бид тус бүрдээ зургаан мянган фут гүнзгийг туулсан байв. Гэтэл халууны хэмжээ наян нэгэн градус байхын орон арван тав байлаа!

Дараагийн өдөр зургадугаар сарын 30-ны мягмар гаригт өглөөний зургаан цагт цааш дахин уруудаж эхлэв. Лаван хонгилоор үригэлжлэн явахад газрын налуу бараг үл мэдэгдэнэ. Үдийн арван хоёр цаг арван долоон минутад Ханс зогсов.

-За! Бид одоо хонгилын мухарт хүрлээ гэж нагац өгүүлэв. Эргэн тойрныг ажиглавал бидний өмнө хоёр хар нүх харагдав. Алинаар нь орвол зөв бэ? гэдэг асуултыг онож таахад хэцүү байлаа.

Нагац зүүн талынхы нь нэгэнт сонгосон учир бид даруй тэр нүхээр оров. ХОнгилын налуу түрүүчийхээс арай гадарган, халуун нь ч бас төдий л их бус байлаа. Хайлмаг лав цутган урсаж байсан тэр цагт энэ хонгил одоогийнх шигээ айван тайван байв уу? Эсвэл хөгшин галт уул бидни йг хуурч байна уу? гэж бодогдоно. Үүнийг би дотроо л бодож явснаас биш бусад хэнд ч хэлээгүй билээ. Гагцхүү нагацын зориг л биднийг урагш түлхэж явуулна. Тэрбээрхальтарч гулгаж, унаж тусан алхална.

Оройн зургаан цаг блоход бид өмнө зүгт хоёр бээр газар явж милийн дөрөвний нэг хиртэй гүнд орсон байлаа.

Нагац амрах дохио өгөв. Хоорондоо үг ч солилгүй хоолоо иэцгээж аяныхаа хөнжилд ороод тэр дороо унтацгаав. Африкийн ойд яваа жуулчид нойрсох үедээ бие биеэ манаж сэргийлдэг бол энд араатан соёотон, ан гөрөөсний алин ч үгүй тул айх эмээх зүйл огт үгүй байлаа.

Маргааш нь нойроос сэрэхэд бие сайхан амарсан байв. Тэгээд аялалдаа гарлаа. Лаван зам урьд адил үргэлжилнэ. Хонгил баахан тэгширч ирснээр барахгүй газрын гадарга өөд өгсөх мэт боллоо. Өглөөний арван цаг болоход хамаг бие сульдан ядрав.

-Хүүе, Аксель! Гэж дуудахад би:

-Над цашлах чалдал алга гэлээ.

-Яаж байгаа чинь энэ вэ! Ийм сайхан замаар гуравхан цаг яваад уу?

-Би замыг нь хэцүү гээгүй байна. Харин хамаг бие сульдаж ядраад байна.

-Юу гэсэн үг вэ? Уруудаж явахад!

-Үгүй өлсөж байна шүү дээ гэхэд нагац гайхаж,

-Өлсөж гэнээ гэж мөрөө хавчисхийн өгүүлэв

-Тийм ээ. Хэрэв ингэж өгсөөд байвал эцэстээ Исландын нутагт буцаж очих болно гэж би хэллээ.

Нагац юу ч хэлсэнгүй явах дохио өгөв. Дуугаа хурааснаар нь нагацыг уурлаж байна гэж мэдэв. Боодолтой юмаа аваад тэр хоёрыг арга буюу даган гэлдрэхдээ тэднийг алдчих вий гэж айж явлаа. Учир нь ухаан олдохгүй гүзгий нүхэнд нөхдөөс төөрөлдвөл яана гэж бодохоос үнэхээр хамаг бие чичирнэ.

Үди йн хирд хонгилын ханын гадарга өөрчлөгдөж ирлээ. Лаван бүрхүүл үгүй болж хад чулуу үзэгдэх болов. Хадан хана үелсэн босоо судлуудаас тогтжээ.

-Энэ бол яриагүй дэлхийн хоёрдогч галавын үед усанд идэгдэж тогтсон давхраа мөн. Ингэхлээд бид боржин чулууны үеэс холдож байгаа юм байна гэж хэлэхэд нагац:

-Юу гэнээ! гэв. Би ханын судлыг заажэ:

-Та хараач гэлээ.

-За тэгээд?

-Бид анхны ургамал, анхны амьтан бий болсон үеийн давхрагад одоо ирээд байна!

-Иш, чи үнэхээр тэгж бодож байна гэж үү?

-Та өөрөө харж ажиглаж шинжил л дээ гэв.

Профессор хонгилын хананд дэнгийнхээ гэрлийг тусган ийш, тийшээ гүйлгэж хараад нэг ч үг дуугарсангүй цааш явлаа.

“Мань хүн буруу хонгилоор орсон бололтой. Үүнийгээ өөрөө мэдэж байна уу, үгүй юу? Энэ зам биднийг Снеффельс уулын голомт уруу ч хөтлөн оруулж болох юм. Ах явж буй замаа юунд хүрэхийг ойлгож байгаа болов уу? үгүй болов уу? Эсвэл би буруу шинжиж байна уу? Хэрэв миний бодсон зөв бол бүдүүлэг ургамжлын мөр үлдэц олдох ёстой билээ. Харж л бая! Гэж бодов. Зуун алхмын төдий цаашилбал хатуу лаван хөрсөн дээгүүр явж дадсан хөл гэнэт зөөлөн сул шоронд гишгэв. Тэр нь үнэхээр элдэв амьтан, дун хорхойн үлдэцээс тогтсон газар байлаа.

Профессор Лиденброк алдаа хийсэн нь илэрхи й болохоор нүдэн балай чихэн дүлий дүр үзүүлэн цааш явж байх шиг санагдана. Би бараг гэмтээгүй бүтэн дун газраас авч:

-Хараач гэж ахад хэлэхэд

-Ай тий, дун байна гэж тайван хариулав

-Та юу гэж бодож байна?

Чи өөрийнхөө бодлыг зөв боллоо гэж санаж байна уу? Бид боржин чулуун давхарга, лаван замыг рдаа хийх нь хийсэн. Би алдаж байж болно. Зөв буруугаа шалгахын тулд энэ хонгилын мухарт хүрэх хэрэгтэй байна.

-Тиймээ, таны зөв. Гэхдээ нэг аюул байх шиг байна.

-Ямар?

-Ус дуусах!

-Зүгээр, түүнийг хэмнэнэ гэлээ.

Үнэхээр усаа хэмнэх хэрэгтэй байлаа. Усны нөөц гурван өдөр дөнгөх төдий үлджээ. Би түүнийг үдшийн хоол идэх үед харсан билээ. Замд булаг дайралдаж магадгүй гэж найдсаар л байв.

Дараагийн өдөр турш бид бараг солихгүй дув дуугүй явцгаав. Зам маань

өгсөхөө больж зарим газар уруудах маягтай болов. Гагцхүү үет давхарога хэвээр байв.

Цахилгаан дэнгийн гэрэл хананд тусаж мянган өнгийн туяа цацрах н хонгилын туурга цагаан судалтай саарал буюу улаан, шар өнгийн үзэсгэлэнт гантин чулуунаас толтсоных ажээ. Гантигийн ихэнх нь эртний бүдүүлэг амьтдын мөр үлдцийг хадгалсан байлаа.

Гэтэл профессор Лиденброк энэ бүгдийг үл сонирхон, гагцхүү эгц доошоо орсон нүх буюу эсвэл одоогийн явж буй замыг хөндөлдсөн саад дайралдаасай гэж хүсэж явсан юм.

Шөнөдөө миний ам цангаж хонолоо. Баасан гаригийн өглөө манай жижиг баг хонгилоо дагаад цааш явав. Арван цагаас хойш гялалзсан гантигийн оронд хар бараан юм нүхний хананд харагдав. Хонги лын зай явцууран маш давчуу болж ирэхэд би түүний ханыг гараар тэмтэрч үзэв. Харвал, гарын алга хав хар болсон байх бөгөөд гайхаж дахин сайтар ажиглав.

-Нүүрсний уурахай байна-гэж би дуу алдав.

-Уурхайч үгүй уурхай юу даа?

Хүн ч гаргасан юм билүү, хэ мэдэх вэ?

-Би мэднэ. Хонгил нүх хүний гараар хийгдээгүй нь лав гэж нагац хэлээд:

-Одоо оройн хоолны цаг боллоо. Хооллоцгооё! Гэв.

Ханс оройн хоол зэхэв. Би ялимгүй юм идэж дуусаад ус залгиад хооллосон болов. Хоолны дараа нөгөө хоёр маань хучлага дэвсгэртээ орж нойрслоо. Миний нойр хулжиж өглөө болох цаг мөчийг тоолон ядаж шөнийг өнгөрөөв.

Бямба гаригийн зургаан цагт дахин замд гарлаа. Хорь гаруйхан минут яваад уудам зайтай агуйд орж ирлээ. Тэр агуй өргөнөөр зуун фут, өндрөөр зуун тавь орчим фут ажээ. Үүнийг хүн бүтээсэнгүй гэдгийг бая сая ойлгов. Ямар нэгэн онц хүчтэй түлхэлтийн улмаар газрын гүнд ийм зай тогтжээ. Газар дэлхийн оршин суугчдаас энд анх түрүүнд ирсэн нь бид байлаа.

Түүний хар бараан хананд чулуун нүүрсний үе хэмээхдэлхийн хөгжлийн эртний нэгэн үеийн бүх түүх илэрхий харагдах бөгөөд геологич хүн түүний үе шатуудыг хялбархан тогтоож болох байлаа.

Тэр эртний үед цаг агаар халуун бөгчим, уур манан даяар бүрхмэл, нарны хурц гэрэл нэвтрэхгүй байсан учраас газар дэлхий өтгөн ургамлаар битүү хучигдсан байжээ. Тэр цагт уур амьсгалын өөрчлөлт байсангүй, Экваторт ч, дэлхийн туйлд ч ялгаагүй халуун дулаан байжээ. Тийм халуун уур асыгал хаанаас ирж байв? Гэвэл дэлхийн дотоод гүнээс галт хүчний үйлчилгээнээс шалтгаалан дэлхийн дотоод гүнээс ирж байсан ажээ. Нарны гэрэл үздэггүй байсан ургамал нь цэцэг ч үгүй, анхилам үнэр ч үгүй, харин үндэс нь тун бат бөх байжээ. Өтгөн их ургамал хожмоо чулуун нүүрс үүсэх сурвалж болсон байжээ. Тэр үед газрын хөрс нилэнхүйдээ усаар мэлтийж, усанд унасан ургамал байгаль дахь химийн урвалын нөлөөн дор чулуун нүүрсний асар их үе давхраа болон хувирчээ. Хүн төрөлхтөн тэр нүүрсийг дахиад өдий төдий зуун жил ашиглаад ч барахгүй юм.

Чулуун нүүрсний элбэг баялгийг гайхан бахдаж байхад саяын бодол төрсөн билээ.

Бид төдий удалгүй цааш явлаа. Дулааны хэмжээ лав дундуур явж байсантай л

адил байв. Зам ч жигд жигдхэн. Нүхэн хонгил хэдийд дуусахыг мэдэх аргагүй тул ер нь төгсгөл мухаргүй байж ч болно гэж бодогдоно.

Зургаан цагийн хирд бид гэнэт ханан хөшгөнд тулав. Хананы хаана ч зай завсар алга. Үүнийг үзээд нагацыг:

-Уухай! Тэгвэл бүр сайн гэхэд нь би базаахгүй болж гэж мэдсэн юм. Нагац цааш нь:

-Бид Сакнусемийн замаар орсонгүй. Буцах хэрэг боллоо. Одоо эндээ амарч хоноод дараа нь энэ хонгилоос гарахыг бодно доо гэв.

-Тиймээ, тийм чадал тамир байдаг л юм бол

-Яагаад байдаггүй юм бэ?

-Яах юу байх вэ? Маргааш усны нөөц бүрмөсөн дуусна шүү дээ гэхэд профессор:

-Тэгээд зориг тэсвэр бая дуусчих хэрэг үү? Гээд над руу харж хөмсөг зангидав. Сөргөж эсэргүүцэх зүрх над яахин байх бэйлээ.

Яарах хэрэгтэй байсан тул дараагийн эртлэн гарав. Газар дор орсоор таван өдөр явжээ. Буцах замын хүнд бэрхийн талаар олон юм ярихгүй. Нагац их ууртай, Ханс нэн тайван байх юм. Над бодож санах ч юм байсангүй.

Анхныхөө өдөр усаа бүрмөсөн дууслаа. Халууны хэмжээ эрс нэмэгдэж, би ядарч сульдаж унав. Байсхийгээд л зогсож амарна. Сүүлдээ бүр мөлхөх болов.

Долдугаар сарын 8-ны мягмар гаригт улаан голтой амьтад зам салсан газар арай гэж хүрч ирлээ. Аман дотор халуун шатаад би бөөн мах шиг лаван хөрс дээр гулдайж ойчлоо.

Нагац даруй дэргэд минь ирж намайг тэврэн өнийлгөөд:

-Хөөрхий амьтан гэж үнэн санаанаас хайрлан энхрийлэв.

-Ширүүн дориун профессорын ийм үг надад дэмжлэг боллоо. Би чичирхийлсэн гараар түүний гарыг шүүрэн атгав. Намайг энхрийлэн ширтэх түүний нүдэнд нулимс мэлтгэнэж харагдана. Тэгээд бяцхан ташмаг гарган уруулд минь ойртуулж:

-Уу! гэхэд нь тун их гайхлаа. Би буруу дуулавуу, эсвэл нагац солиорч байна уу? гэж мэл гайхаж цэл хөхрөн харваа:

-Уу! гэж нагац давтан хэлээд ташмагаа ам руу минь нэгмөсөн хөнтрөв.

-Ая! Юутай жаргал вэ? Улайссан хуурай аманд дуссан хэдхэн дусал ус тасрах шахсан амин голы минь дэвтээлээ.

-Ус шүү! Сүүлчийн дусал нь энэ дээ, сонин байна уу? Сүүлчийнх нь. Ташмагийн ёроолд зориуд хадгалж явсан юм. Ууж орхиё гэж би хорин удаа, зуун удаа бодож байлаа. Гэвч чамд зориулан хадгалж байсан юм гэхэд нь:

Нагац минь! гээд би баярласандаа бөөн бөөн нулимс бөмбөрүүлж билээ.

-Хөөрхий дүү минь, чамайг энд хагас голтой амьтан үхэтхэн унана гэдгийг мэдэж байлаа. Тэгээд амий чинь аврах гэж усны эцсийн шавхрууг хайрлаж явлаа гэхэд

-Их баярлалаа! Гялайлаа гэв.

Ус хэдий ялимгүй ч хүч чадлы маань сэлбэж өглөө. Аман дотор халуу шатахаа больж үг хэлж болохтой болов.

-Одоо усгүй боллоо. Ингэхлээр буцъя. Уулын орой хүртэл хурдхан өгсье гэж би хэллээ. Миний дээр тонгойж байсан ах маань үүнийг сонсоод:

-Буцъя гэнээ.! гэж өөрөө өөртөө хэлж байгаа мат аман дотроо бувтнав.

-Тиймээ, буцъя, нэг ч минут дэмий газдалгүй явъя гэвэл нагац нилээд удаан дуугүй байснаа:

-Юу гэсэн үг вэ? Аксель минь. Саяын хэдэн дусал ус чамд зориг хүч өгсөнгүй юу? гэв.

-Зориооч алд аа!

-Чи бас л найдвал алдсан хэвээр байх шив! Гэлээ.

Ямар хаашаа хүн бэ! Бас яах санаатай байгаа юм бол? гэж бодоод

-Тэгээд яах гэж? Буцахгүй гэж үү? гэж асуулаа.

-Зорьсондоо хүрч болох байтал аяллаа зогсоох гэж үү? Яалаа гэж! Би чамайг үхүүлэхгүй. Чи Хансыг дагуулаад буцвал буц л даа. Харин намайг энд орхи!

-Та ганцаараа хоцрох гэж үү?

-Намайг үлдээ гэж чамд хэлж байна. Би аяллаа үргэлжлүүлнэ. Нэг бол зорьсондоо хрнэ. Эсвэл бүрмөсөн буцахгүй болно. Аксель минь яв. Одоо яв гэлээ.

Нагац сэтгэл ихэд хөдөлж дуу хоолой нь ч эрс шийдэмший болжээ. Тэрбээр болохгүй юмыг болгох гэж хар хүчээр тэмцэж байлаа. Ёроолгүй нүхний хажуугаар нь амиа хаацайлах зөн намайг нөгөө тийш нь түлхээд байлаа.

Газарч ер санаанд ч үгүй харж сууна. Наад зах нь дохиж зангаж байгаагаар маань ч гэсэн тэр бидний юу ярилцсаныг ойлгосон нь лав боловч гагцхүү эзэн юу гэхийг хүлээж буцахад ч бэлэн, үлдэхэд ч бэлэн байлаа. Харин намайг буцъя гэвэл яах юм бол!...

Би түүний дэргэд очоод гараа гар дээр нь тавив. Ханс хөдөлсөнгүй. Тэгэхэд нь уулын оройгоос ирсэн замыг түүнд дохиж харуулав. Бас л хөдөлсөнгүй. Гэвч эцэст тайван байдлаар ахыг заажээ:

-Master гэв.

-Эзэн явахгүй. Тэр чиний амь насны эзэн биш шүү дээ! Харин амь насыг чинь үрэгдүүлэх гэж байна. Миний үгийг дуулж байна уу? Ойлгов уу? гэж би хашгираад хоёр гараараа түүнээс зуурч албадан явуулах гэж тэмцэлдэв. Нагац үүнийг хараад:

-Аксель тайвшир. Ханс чиний хэлсэн зоргоор явахгүй. Би чамд юм хэлье гэхэд би нагацыг эгцлэн харлаа.

-Усгүй болсон явдал бол замд тохиолдож байгаа цорын ганц тотгор юм. Нилэнхүйдээ лав, чулуун нүүрснээс бүтсэн зүүн талын энэ хонгил дотор бид усны молекул төдийтэй ч дайралдсангүй. Ус нь баруун талынхаар нь орсон бол илүү аз жавшаантай болж магадгүй байж гэхэд би толгой сэгсрэн:

-Үгүй, үгүй гэв. Нагац профессор цааш үргэлжлүүлэн:

-Чи дуустал сонс. Чамайг үхсэн хүн шиг хэвтэж байхад би тэр хонгил нүхийг ажиглахаар явсан. Шууд дэлхийн гүн рүү орсон нүх байна лээ. Түүгээр явбал би дорхноо боржин чулуун давхраанд хүрнэ Тэнд зөндөө булаг тааралдана. Үүнийг хэлэх гэсэн юм. Колумб шмнэ газар очихын тулд өөрийн багийнхныг 5 өдрийн турш гуйсан гэдэг. Эцэст нь өвчинд нэрвэгдэж айж сандарсан багийнхан нь зөвшөөрснөөр шинэ дэлхий нээсэн юм. Би үнэндээ газар доорхи дэлхийн Колумб болоод байгаа болловч чамаас ганцхан өдөр л тэсвэрлэхийг гуйя. Хэрэв ус эс олбол газрын гадарга

өөд буцахыг амлая гэлээ.

Би түүний үгэнд үнэмшиж:

-За яах вэ, таны хүссэнээр болог! Та үнэхээр гайхамшигт эр зоригтой хүн юм. Явцгаая! гэлээ.

Энэ удаа бид нөгөөдөх хонгилоор уруудах боллоо. Ханс хуучнаараа түрүүлэн алхахад Профессор:

-Яваад бай! Яваад бай! гэж хашгирна.

Хонгил нүх жигтэйхэн их муруй тахир байлаа. Боржин чулуун хаданд янз бүрийн үе судал гарчээ. Байгалийг газар дээр нь шинжлэх ийм сайхан завшаан эрдэм судлалын шинжээч хүнд хэзээ ч тохиолдож байгаагүй билээ. Юу байдгийг цөмийг нь бид нүдээрээ харж, гараараа барин судалж болох байв. Газар дэлхийн гүн дотор юутай их баялаг вэ? Гэрэлтүүлэх аппаратын гэрэл хадан хананд тусахад чулууны өнцөг булан бүрээс галын дөл цацрах шиг болно. үүнийг харахад очир эрдэнэсийн сан дундуур явж буй мэт санагдана. Оройн зургаан цагийн орчимд гэрлийн сайхан наадам дуусав. Хананы өнгө бараалж боржин чулуугаар доторлосон шоронд орсон мэт болов.

Үдшийн найман цаг боллоо. Ус олдоогүй л байв. Би тун хэцүүдэж явлаа. Нагац зогсохыг мэдэхгүй түрүүлэн явсаар байна. Нагац зогсохыг мэдэхгүй түрүүлэн явсаар байна. Хүч чадал ч бүрмөсөн барагдлаа. Нагац амласан өдөр ч дуусаж байлаа.

-та минь ирээрэй, үхлээ! Гэж хашгираад намайг үхэтхэн унахад нагац эргэж хараад:

-Бүх зүйл ингээд балардаг байж гэж хэлэх нь сонсдов. Түүний уцаарлаж байхыг дөнгөж мэдээд би нүдээ анив.

Ухаан орон нүдээ нээхэд манай хоёр хучи лгандаа ороод хэвтэж байх нь үзэгдэв. Намайг ганц минутын төдий ч унтаж чадахгүй тарчилж байхад харин эд унтаж амарч байгаа хэрэг үү? Гэж бодлоо. Би тэсэх аргагүй зовж байв. "Ингээд балардаг байж" гэсэн нагацын сүүлийн үгс чихэнд үргэлж сонсдоно. Цөм туйлдаж сульдсан учир одоо дэлхийн гадаргууг хүрэх тухай бодохын ч хэрэггүй болжээ. Нэгэн бээр хагас зузаан хөрс бидний дээрээс хөдөлгөхгүй дараад байх шиг санагдана.

Нам гүмийн дунд хэдэн цаг өнгөрлөө. Гэтэл нэг чимээ гарав. Тэгээд харанхуй хонгил дотор ийш тийшээ анхааралтай харвал газарч исланд маань гартаа дэн бариад явж байх шиг байлаа.

Нагацыг унтаж байхад энэ хаачдаг хүн бэ? Биднийг хаях нь уу? гэж бодоод хашгирах гэсэн боловч чдсангүй. Ханс одоо болтол бидэнд муу юм хийгээгүй болохоор түүнийг энэ удаа арай ч биднээс зугатахгүй байх гэж бодлоо. Нэг хэсэг болоод өнөөх чимээ дахин сонсогдов. Харвал газарч маань дээш өгссөнгүй харин доошоо уруудаад явчихлаа. Ус эрэхээр яваа юм болов уу?

Бүтэн цагийн турш толгойд маань элдвийн дэмий балай бодол хутгалдан үймээд байхаар нь би өөрийгөө солиорч байна уу гэж бодлоо. Тэгж байтал нүхний гүнээс хөлийн чимээ гарч Ханс буцаж ирэв бололтой. Төдхөн дэнгийн гэрэл хонгилын ханыг сүүмэн сүүмэн гэрэлтүүлж дараа нь өрөөрөө гарч ирэв.

Тэр ахын дэргэд очоод мөрөн дээр нь гараа тавиад сэрээхэд нагац өндийж:

-Юу болов? гэхэд газарч

-Vatten гэж хариулав.

Би хэдийгээр дани хэл мэддэггүй ч гэсэн энэ удаа газарчийн хэсэн үгийг ойлгосон юм.

-Ус, ус! гэж намайг алга ташин галзуу хүн шиг бахирахад нагац бас

-Ус! гэж хашгираад Hvar гэж Хансаас асуухад цаадах нь:

-Nedat гэв.

Хаана? Гэж асуухад нь дор гэж хариуллаа, гэдгийг би сайн ойлгохоод баярласандаа ухасхийн түүний гарыг шүүрэн атгавал тэр ердийн тайван байдалтай намайг ши ртэж байв.

Замын бэлтгэл гэж юу байх билээ. Даруй налуу хонгил уруудан доош буулаа.

Цаг гаруйн дотор хоёр мянган фут явав.

Энэ үед боржин чулуун хаханы цаанаас ер бусын чимээ ив илхэн сонсдоно.

Нагац тэр чимээ юунаас гарч байгааг тайлбарлаж хэлсэн нь:

-Хансын зөв байна. Дуулдаж байгаа шуугиан нь усны урсгалын чимээ байна гэв.

-Усны урсгал ий? гэж лавлан асуувал нагац:

-Яриагүй, бидний хажуугааргазрын доорхи ямар нэг гол урсаж байна! гэлээ.

Итгэл найдвар ч аяндаа төрөөд алхаа гишгээ хурдсаад ирлээ.

Усны чимээнд сэргээд ядарснаа ч мэдэхээ болив. Урсгалын шуугиан зүүн гар талд гарч байх шиг бололтой. Хагас цаг хиртэй өнгөрөхөд дахин хагас бээр газар явав.

Одоо харин урсгалын чимээ холдоод явчих шиг боллоо. Буцаад явлаа. Ханс урсгал хамгийн ойр дуулдах газар ирээд зогсов. Би тэнд нь очоод сууж авлаа. Хоёрхон алхмын зайтай газар усны урсгал сонсдовч боржин чулуун хана хүрэх замыг хаажээ. Ингээд сэтгэлээр дахин үхэж эхлэв.

Харсаар байтал Ханс дэнгээ авч босоод хана уруу очиж хуурай чулуунд чихээ наагаад анхааралтай чагнав. Тэрээр усны урсгал хамгийн сайн дуулдах газрыг эрсээр төдий удалгүй зүүн ханын ёроолоос гурван фут дээшээ уул газрыг олов бололтой. Газарт хадыг бут цохисон зээтүүгээ авлаа.

-Аврагдлаа! Аврагдлаа! Гэж амайг хашгирахад нагац:

-Зүйтэй, Хансын зөв Аая! Ёстой сайн эр! Зөв арга олсон байна гэв.

Үнэхээр ч энгийн хялбар арга байж билээ. Харин зээтүгээр хадыг хага цохимогц чулуу нурж држ алах буюу эсвэл гаргасан нүхээр ус цутган орж ирвэл яана гшэсэн аюултай бодол биднийг түгшүүлэв. Гэвч тэр агшинд ийм болгомжлол шийдвэрийг минь зогсоож чадахгүй байлаа.

Ханс ажилдаа орж хадыг хурдан хурдан цохиж хагас фут хиртэй нүх гаргахад усны урсгал улам тод дуулдаж уруул минь усанд хүрэх шиг боллоо.

Удалгүй хана цоорч цаанаас нь их чимээ гарахад нагац ч зээгүүгээ аваад хүч хавсран оров. Би ч бас тэсэж хүлээх аргагүй боллоо. Цаг гаруй ажилласны дараа ханын цоорхойгоор ус хүчтэй орж ирэв.

Ханс баярлаж нэг их сүйд болсонгүй. Харин би л баярлахдаа дуу тавьж хоёр гараа усанд шургуулав. Ус учиргүй халуун ажээ.

-Усны халуун лав зуун градус бололтой гэж намайг өгүүлэхэд нагац:

За яахав, хөрнө биз гэв.

Хонгилын дотор битүү уур болж хөлийн хажуугаар горхи урсаж ирэхэд бид түүнээс ууцгаав._

Аяа! хичээн сахан жаргал ва? Голыг минь дэвтээж амьдрал авачрагч рашаан гэгч энэ бик ээ. Ус халуун боловч ууж ханашгүй байлаа.

-Энэ горхийг Хансын нэрээр нэрлэе гэж нагац хэлэхэд би:

-Зүйтэй гэлээ.

Ингэж уул горхи-Hans-bash¹³/Ханс горхи/ гэдэг нэртэй болжээ.

Одоо энэ усыг дэмий орхиж болохгүй Ташмагуудаа дүүргэж авъя! Тэгээд нүхийг буцааж таглая гэж намайг санал гаргахад бусад маань зөвшөөрөв. Ханс ханыг таглахаар оролдоход халуун ус гары нь халааж, урсгалын эрч дэлдэхгүй байв.

-Аргагүй. Энд атомсферийн даралт лав мянгаас доошгүй байгаа. Усны урсгал гучин хоёр мянган фут өндрөөс бууж бий. Ингэхлээр над нэг санал байна гэж нагац өгүүлэв.

-Ямар санал вэ?

-үхийг бөглөөд яах вэ?

-Бөглөхгүй бол.... гэтэл нагац үг таслан:

-Ташмагтай усаа дуусчихаар дахин ус олно гэж бат итгэж болох уу? гэв.

Үгүй санахгүй хэрэг

-За тэгвэл энэ ус урсаж л байг. Жс тэртэй тэргүй доош буух учир бид түүнийг дагаа цангасан цгтаа уугаад л явж бая.

-Ёстой зүйтэй санал байна! Ийм горхитой хамт явбал ч бид зорьсондоо хүрч болно гэхэд:.

-Миний дүү үнэхээр ойлгож байна. Нагац профессор инээмсэглэв. Тэгээд хэдэн цаг амрах боллоо.

Өдөр шөнийн алиыг ч мартчихсан бид сая ухаан орж цагаа харвал нэгэнт шөнө болчихсон байв. Төдхөн дор бүрнээ гүн нойронд дарагдан цөм унтсан билээ.

XXIY

Маргааш болоход өнөгөрсөн зовлон хэдийн мартагджээ. Өглөө ам цангаагүй боссондоо юуны өмнө их гайхлаа. Яагаад тэр билээ гэдгээ хажуугаар урсаж байгаа горхийг хармац мэдлээ.

Өглөөнийхөө хоолыг идэцгээж өнөөх уснаас ууцгаав. Чадал тэнхээ бүрэн сэргэж хичнээн хо ч явчихмаар санагдана. Ханс шиг газарчтай, над шиг туслагчтай нагац шиг хүн яагаад зорьсондоо хүрэхгүй байх билээ? гэсэн сайхан бодол дотор ороод байв. Снеффельсийн орой өөд буцахыг хэдийнэ больжээ. Уруудах тухай л ярилцахаас биш өгсөн тухай хэн маань дурссангүй.

-Явцгаая! гэж намайг хашгирахад бөглүү цууриа дууриан давтав.

Пүрэв гаригийн өглөөний найман цагт замдаа гарлаа. Хонгил нхүх үргэлж муруйж тахирлах боловч үндсэндээ зүүн өмнө зүгийг барина. Явах замын чигийг тогтоохын тулд нагац луужинг байнга харна.

Хонгилын ёроол бараг тэгшхэн болж горхи, маань хажуугаар намуухан урсана.

¹ bash гэж германаар горхи гэсэн үг.

Тэгш газраар явахдаа нагац уцаарлаж бухимдана. Ер нь “нагацыг эгц огцом, эрс тэс хүн” гэж болох бөгөөд дэлхийн раидиусыг даган газрын төвд гулгаад оччих санаа бий дэг ээ.э

Явсаар байтал налуу нь баахан ихдэж нилээд хурдан уруудах болов. Эхний хоёр өдөр ерөнхийдөө доошоо бага, хажуу тийшээ иххэн шиг явлаа.

Долдугаар сарын 10-ны баасан гаригийн орой бид Рейкьявик хотоос гучин бээр холдож, газрын гадаргаас доош хоёр хагас бээрийн гүнд орсон байв.

Явах зам тун аймшигтай боллоо. Гэвч нагац алга ташиж:

-Биднийг алс холдхөтлөх зам энэ дээ, зассан шат шиг явахад хялбар сайхан байна гэнэ.

Бид олсноосоо барьцгаан уруудаж эхэллээ.

Арван таван минут яваад л амрахаад зогсоно. Тэгээд чулуун дээр сууцгааж юм идэнгээ ярих юмаа ярилцаад горхиноос ууаг байв.

Эргэлдэж мушгиралдан явсаар газрын хөрсөнд дахиад хоёр бээр хиртэй нэвтэрлээ. Өөрөөр хэлбэл далайн төвшнөөс доош таван бээр орчимд орсон хэрэг билээ. Хэсэг зуур болсны дараа замын эгц тэгширч 45 градусын хазгай болоод зүүн өмнө зүг чиглэв. Зам явахад хялбар, жигд налуу болжээ. Гэвч энд байгалийн гойд үзэсгэлэн харагдсангүй.

Долдугаар сарын 15-ны лхагва гаригт газрын гүнд долоон бээр орж Снеффельс уулаас тавин бээр холджээ. Биес бага зэрэг алжаасан атугай ч эрүүл энх сайн байлаа.

Нагац, луужин, хронометр, манометр, тернометрээ цаг үргэлж ээлжлэн харна. Тэднийг хармагцаа байдал төлөвийг хялбархнаар мэдэж чадах ажээ. Нэг удаа нагацыг хөндлөн тийшээ бүгд тавин бээр яваад байна гэж хэлэхэд нь би бүр цочиж дуу алдчихав.

-Чи юу болов? гэж ах ауув

-Зүгээр нэг юм бодоод л...

-Юу вэ? Миний дүү?

-Бид Исландын арлаас хэтрээд явчихжээ.

-Чи тэгж бодож байна уу?

Үзтэл тийм байна шүү дээ гээд газрын зураг дээр хэмжээ авч:

-Би алдаа хийгээгүй байх, би одоо энгүй далайд байна-гэв. Нагац алгаа үрж:

-Энгүй далайн дороо? Гэж маргахад би:

-Тиймээ, далай бидний толгой дээр байгаа шүү дээ! гэв.

-Аксель минь, гайхах юу байх вэ? Жишээ нь Английн Кьюкасль хотонд усан дор ортол ухсан нүүрсний уурхай байдаг юм гэж нагац ярилаа.

Профессор оршиж байгаа нөхцөл байдлаа ердийн зүйл болгож байна. Харин энэ их хавтгай усан доогуур тэнэж явна гэдэг намайг түгшүүлж балаа. Гэхдээ боржин чулуун хад бөх зузаан, бас хонгил нүх маань биднийг улам гүн тийш хурдан аваачих учир тьүгшээд ч яах вэ.

Дөрвөн өдрийн дараа долдугаар сарын 18-ны бямба гаригийн орой нилээд уужим нэгэн агуйд орж ирэв. Нагац газарчдаа гурван ри ксдали йг нь өгөв. дараагийн өдөр нь амарч өнжихөөр шийдэв.

Ням гаригийн өглөө нойроос сэрээд өнөөдөр аялалд гарахгүй шүү дээ гэж бодохоос хичнээн сайхан байсан гэж санана. Бид үнэдээ агуйн гүний байдалд бүр дасчихжээ. Миний хувьд бол хүнд гарцаагүй чухал нар, сар, од, мичид, мод ургамиал, байшин хашаа рхот суурин зэрэг зүйлс ер бодогдохоо больжээ. Харин энэ мэтийн ашиггүй чамин юмсад баахан зэвүүцдэг болжээ.

Агуйн зай уудам цэлгэр бөгөөд боржин чулуун хөрсөн дээгүр нь найдвар болсон горхи маань алгуурхан урсана. Салаалсан газраас энд хүртэл урссан горхины ус хөрч уухад тааламжтай болжээ.

Өглөөний хоол идсэний дараа нагац профессор тэмдэглэлээ хөтлөх ажилд оров.

-Юуны өмнө тооцоо гаргая. Буцах замдаа аяллынхаа зургийг хийнэ биз гэж ярихад нь би:

Нагац минь тэр чинь нээрээ маш сонирхолтой шүү. Харин таны ажиглалт хнгагдсан юм уу.

-Хангагдсан. Би хонгилын өнцөг булан, налуу хазгай бүгдийг мадаггүй тэмдэглэж авсан. Эхлээд одоо хаа байгаагаа үзье. Луужин аваад ямар зүг зааж байгаа нь хэлээдэх гэхэд уул багажийг авч анхааралтай хараад:

-Зүүн, зүүн өмнө зүг гэв.

За яамай гэж түүнийг тэмдэглэн бас бус хэдэн тоо тавьж тооцоолоод

-Бид гарсаар 85 бээр явжээ. Гэв.

-Атлантын далай доогуур явж байгаа хэрэг үү?

-Яриа юу байх вэ?

-Одоо бидний толгой дээр шуурга болж хөлөг онгоц давалгаанд сэгсчүүлэн явж байх нь ээ?

-Тийм ч байж магадгүй. За тэр ч яах вэ. Тооцоогоо бодъё. Одоо бид Снеффельсийн хормойгоос зүүн өмнө зүгт 85 бээр зайтай газар байгаа бөгөөд тэмдэглэлийн ёсоор арван зургаан бээрийн гүнд ороод байна.

-Арван зураан бээр гэнэ ээ?

-Яг ти йм

-Тэгвэл энэ чинь шинжлэх ухааны ёсоор шороон хөрсний хязгарт хүчр шүү дээ.

-Хүрээгүй гэж би хэлээгүй шүү

-Тий бол халууны хэмжээ мянга таван зуун градус байх ёстой бишүү?

-Ёстой нь чёстой л доо, дүү минь

Боржин чулуу бүхэл цулаараа байхгүй цөм улайсаж хайлах ёстой юм биш үү:.

-Чамайг харахад ямар байна? Шал өмнөө байгаа биз дээ. Баримт онолыг няцааж байгаа биз.

-Харин тийм байна. Би бүр гайхаж байна.

-Термометр юу гэж зааж байна.

-Хорин долоон градус

-Эрдэмтдийн зөвийг нотлоход 1473 градус дутаж байх шив дээ. Ингэхлээр их халцууны тухай онол буруу шиг байна. Чи юу гэх вэ?

-Над юу чя гэх юм алга. Таны тооцоо цөм яг таг байна. Харин танд нг чухал зүйл хэлэх үү!

-Хэл, хэл, дүү мсинь.

-Одоо бидний байгаа газар, Исландын дор байна.

Тэгвэл газрын радиусыг 1583 бээр гэдэг биш үү?

-Тийм 1583 бээр.

-За яах вэ? барагцаалахад 1600 бээр болог. Бид энэнээс арван зургаагийн нь аялжээ.

-Тэгээд?

-Гэтэл та түрүүн хөндлөөшөө 84 бээр явсан гээгүй билүү?

-Тэгсэн.

-Хорь орчим өдөрт үү?

Тийм, хорин өдөрт

-Арван зургаан бээр гэдэг чинь дэлхийн радиусын зууны нэг гэсэн үг. Ингэхлээр энэ л багцаатай яваап бая гэж үзвэл хоёр мянган өдөр буюу таван жил хагас уруудах нь шив дээ гэж намайг хэлэхэд нагац

-Тооцоог чинь чөтгөр алгадаг! Таамналыг чинь шугал аваг! Гэж их л ундууцан өгүүлээд

-Юун дээртулгуурлаж ийм дүгнэлт хийж байгаа юу бэ? Зорьсон газар хүртэл дандаа муруйж тахирлаж явах юм хэн чамд хэлээ вэ? Ганц би биш надаас гадна Арне Сакнусем гэдэг хүн байсан байна. Би бол хүний хийснийг л хийж, хүний зорьсныг зорьж яваа хүн гэв.

-Үүнийг ойлгож бана. Гэвч...

-Чамайг иймэрхүү зүйл ярилгүй дуугүй байгаасай гэж гуйя гэхэд нь би профессорын уурлаж байгааг ажиг мэдээд дуугүй боллоо.

-За одоо манометри йг үзье. Юу зааж байна? гэж нагацыг асуухад:

-Тун их даралттай байна гэлээ.

-Мөн, чи мэдэж байна уу? Бид аажуухан уруудаж яваа болохоор агаарын даралтад дасаж их зовохгүй бол л дээ.

-Нээрээ тийм: Агаарын ийм их даралтанд зохих нь байтугай бүр таалхмжтай байна... Ер нь дуу чимээ нь чанга сонсогдох болж байгаа нь танд мэдэгдэж байна уу?

-Яриагүй мэдэгдэж байна.

Харин агаарын нягт нэмэгдэж байна уу? үгүй юу?

-Нэм эгдэж байна. Доошлох тутам юмын жин багасаж байгаа нь лавтай. Газрын гадаргуу дээр хүн хүндийн жинг маш мэдрэмтгий байдгийг чи мэднэ.

Гэтэл бөмбөрцгийн голд бодис юмс огт жингүй болно гээч.

-Үүнийг мэднэ. Гэвч доошлох тутам агаарын нягт эмэгдсээр усны нягттай аидл болох уу даа?

Атмосферийн даралт долоон зууд хүрвэл тэгнэ.

-Түүнээс илүү болбол?

-Илүү болбол нягт нь улам л ихэднэ биз.

-Тэгвэл бид яаж цааш явах юм бэ?

-Яах юу байх вэ, халаасандаа чулуу дүүргээд л явна биз гэхэд нь би:

-Нагац минь, одпоо бүгдийг ойлгож мэдлээ гэв.

Нагацын уурыг хүргэхгүйн тулд өөрийнхөө таамналыг зүрхэлж хэлсэнгүй.

зогсов. Үнэндээ явсаар батйал атмосферийн даралт хэдэн мянгад хүрч агаар хатуу байдалд шилжиж болно. Ингэвэл зогсохоос өөр аргагүй болно шүү дээ.

Арван зургадугаар зууны үедбарометр, манометрийн альин нь ч байсангүй. Гэтэл Сакнусем бөмбөрцгийн голд хүрснээ яаж мэдсэн байх нь вэ?гэдэг бодол над төрсөн боловч бас л хэлэлгүй дотроо хадгалав. Үүнийг хэлбэл нагац дахиад Сакнусемийн нэрийг барих учир энэ тухай асуудлыг сөхсөнгүй. Гэвч миний тэр эргэлзлийг тайлахад тун амархан байсан юм билээ.

Бүхэл өдрийг ийнхүү тооцоолж, ярилцсаар өнгөрөөв.

Энд хүротэл бүх зүйл сайн сайхан байсныг хэлэх хэрэгтэй. Саад эрхшээл нэмэгдээгүйсэн бол бид зорьсондоо хүрч чадах байсан юм. Тэгсэн бол юутай их гавъяа байгуулах агсан билээ. Тэр үед би ийнхүү маш ер бусын байдалд амьдарч байхдаа нагацын төлөө үнэн голоос санаа зовж явсан билээ.

Хэдэн өдрийн турш зам улам хазгай болсоор сүүлдээ бүр эгц ташуу болж газрын хөрсөнд алс гүнзгий орлоо. Алхам бүр аюултай байсан байсан энэ уруудалтын үед Ханс туйлын их тус болсон юм. Эхний й хоёр долоо хоногт газарч маань онц хэрэг явдал хийсэнгүй боловч дараагийн өдөр маш чухал зүйл үйлдсэнийг одоо ч нэг, нэгдгүй санаж байна.

Наймдугаар сарын 7-ны өдөр байлаа. Газрын гүнд гучин бээр ороод байв. Өөрөөр хэлбэл, бидний толгой дээр гучин бээр зузаан боржин чулуу, бүхэл бүтэн тив, хот тосгод байсан хэрэг билээ. Энэ үед Исландаас хоёр зуун бээр холдсон байлаа.

Мөн өдөр хонгилын налуу бага зэрэг тэгширч ирэв. Би боржин чулууны үе давхаргааг ажиглангаа түрүүлэн явж байсан юм. Нэг мэдэхнээ бусад маань алга болж цор ганцаар болсон байлаа.

Хэтэрхий хурдан явж тэндээс түрүүлсэн юм уу эсвэл тэр хоёр замдаа зогсож дээ гэж бодоо буцаж явлаа. Арван таван минут хиртэй алхлаа. Хэн ч харагдахгүй байх юм. Хашгирч дуудаж үзлээ. Цуурайнаас өөр хариу алга... Сэтгэл бахан түгшиж хамаг бие арзайгаад явчихлаа. Гайгүй гайгүй. Нөхдөө ололгүй яахав. Залаа зам дайралдсан биш! Түрүүлж явсан боловч буцаад явахад олдох л ёстой гэж өөрөө өөртөө ярьж байлаа.

Хагас цаг өгслөө. Чагнавал уудам хонгилын дотор ер бусын нам гүм ажээ. Би зогсов. “Ганцхан л зам байгаа даа. Бид цөм түүгээр явж байсан. Тэгэхлээр тэд олдох л ёстой. Гэвч үүнээс хол өгсүүлмээргүй юм. Ер нь түрүүлж явсан маань үнэн байдаг байгаа даа? Тийм яах аргагүй үнэн. Ханс миний араас дагаж, газарчийн хойноос нагац явсан. Тэр ч байтугай нагац хэдэн минут саатаж зогсоод дараа нь бид үргэлжлэн явсан” гэх мэтээр болсон явдлыг дэс дараалан санаж шалгав. “Энэ муруй саруй хонгил нүхэд төөрөхгүй итгэлтэй сайн арга над бий. Найдвар болсон горхи маань байсан цагт түүнийг дагаад өгсөхөд нөхдийнхөө мөрийг заавал олно гэж бодоход сэтгэл тайвшраад хурмын төдий ч алдалгүй явмаар санагдана.

Дахиад өгсөж гарлаа. Гар нүүрээ угаамаар санагдпахаар нь Ханс горхиосоо ус авах гэж тонгойж тэмтэрвэл хув хуурай гагцхүү хатуу боржин чулуу гарт дайралдав. Би тэнгэрт ниргүүлсэн мэт хиртхийн цочлоо. Хажууд минь урсаж байсан горхи алга болжээ.

Цөхрөлөө барж мухардсан байдлыг одоо дүрслэн бичих арга алга. Тэр үед миний санаа сэтгэл чухамхүү ямар байсныг аль ч улс үндэстний элээр илэрхийлж болохгүй байсан бизээ! Би өлсөж, цангаж үхэхээс өөр замгүй газрын гүнд амьдраараа булшлуулаад байлаа.

Өөрийн эрхгүй чулуун хөрсийг хичнээн тэмтчивч хув хуурай! Яагаад горхио алдчихав аа? Энэ хавьд байхгүй гэж үү дээ? Түрүүн нөхдийгөө дуудаад хариу чагнахад ер бусын нам гүм байсан нь санагдлаа. Тэр үед л горхи маань үгүй болоод байсныг би анзаарсангүй хэрэг байжээ. Тэгэхэд л миний өмнө өөр нэг хонгил зам дайралдаж би түүгээр ороход Ханс горхи нөхдийг минь дагуулж, % нөгөө салаагаар урссан нь маргаангүй боллоо.

Боржин чулуун дээр хүний ул мөр үлдэхгүй гэдгийг мэдсээр байж тэнд юу олж харах билээ? Гарах арга юу билээ гэж хичнээн бодовч нөхцөл байдал “өнгөрсөн!” гэдэг гагц бодполд тулгаж байлаа. Тиймээ Ёроолгүй багил харанхуй нүхэн дотор ингээд өнгөрдөг байж! Гучин бээр зузаан хөрс хөрс шороо миний дээрээс дарж байна гэж бодогдоно.

Газар дэлхий дээрх зүйлс санаанд орж Ханбург хот, Конигстрассын гудамжин дахь гэр орон, хөөрхий Граубен цөм сэтгэлийн үзүүрт жирэлзэн дурсагдав. Бас явж өнгөрс өн зам, Исланд арал, ноён Фридриксон, Снеффельс уулс нүдэнд дүрслэгдэн үзэгдэв. Миний одоогийн байга ши г байдалд амь аврагдах арга зүй огт үгүй билэ. Үнэхээр ч намайг дэлхийн гадаргуу дээр хэн гаргаж өгөх билээ? Хэн над дөт сайн зам зааж хамт явах билээ?

Зовлонт нагац минь намайг алга болсонд хичнээн их зовж эржхайж явааг би мэдэвч цөхөж мухардахдаа дэмий л “Хүүе, Нагац аа!” гэж хашгирч байлаа. Байдал ямар байв гэвэл амьд явах хоноги йн тоошноос гуравхан өдөр үлдээд байлаа. Житжиг дашмаг тэрхэн үед дүүрэн устай байсан ч хичнээхэн удах билээ. Юутай ч атугай өгсөх, уруудахын аль нэгийг хийх хэрэгтэй гэж бодоод зогсолтгүй өгсөхөөр шийдлээ!

Юуны түрүүнд горхиноос салж төөрсөн тэр газар л хүрье Горхийг олбол Снеффельсийн оройд хүрч чадна гэж бодохдоо ийм бодол эхлээд толгойд орохгүй яав гэж гэвшив. Юу ч гэсэн Ханс горхийг аль болох түргэн олох хэрэгтэй гээд босож хонгилоор өгсөж алхлав. Анхандаа их л итгэл зоригтой саад бүхнийг даван хагас цаг хиртэй явав. Хонгил нүхний хэлбэр бадйал, зарим хад чулууны янз дүрсээр явсан замаар танихыг хичээж байв. Гэтэл энэ хонгил нам айг горхинд хүргэхгүй гэдгийг дорхноо мэдэв. Үнэхээр ч тийм боллоо. Гэнэт өмнө ми нь ханан хад тээглэхэд би боржин хадан дээр үхэтхийн ойчив. Түмэн зүгт салбарласан хонгилтой, ухаан нь олодохгүй энэ нүхэнд гарах газаргүй тул үхэхээс өөргүй боллоо.

Ингэж цөхөж байтал бас нэг аюул нөмөрч ирлээ. Дэнгийн шил хагарч аргалах аргагүй болсонд би түүнээс нүд салгалгүй ширтэж байв. Дэнгийн гэрэл сүүмэлзэн бүдгэрч, хар сүүдэр агуйн ханыг улам улам бүрхэнэ. Эрдэнэ мэт гэрлийн гагц цацрагийг алдах вий гэхээс нүд цавчих ч зүрх хүрэхгүй байлаа. Багил харанхуй дундаа живж шингэх нь тэр! Айхдөө өөрийн эрхгүй муухай бахирав. Газар дээр бол ямар ч харанхуй шөнө гэрэл гэгээ эрхбиш байдаг тул нүд дассан хойно орчноо ялган хардаг билээ. Харин энд гэгээний зүйл өчүүхэн ч үгүй ёстой тас харанхуй болов.

Би юу ч мэдэхээ болив. Хоёр гараа урагш сарвайж газрын уруу хашгиран

гуаглан унан босон хар эчээрээ гүйж гарлаа. Урд маань ханан хад буюу бөөн чулуу дайралдаж толгойгоо хага мөргөөсэй гэж бодож явлаа. Хаашаага ч мэдэхгүй хэдэн цаг гүйсний эцэст тамир тэнхээ барагдаж чулуун хананы хажууд бөөн мах шиг түсхийн ойчоод мэдрэл айлдав.

Ухаан орвол хацар нүүр нулимсанд норчихоод байв. Цаг мөчийг мэдэх ямар ч бололцоо байсангүй. Унахдаа шархдаж их цус алджээ. Аяа! Ингж байснаа үхэх минь яалаа!

Нүхний гүнд гэнэт аянга ниргэх мэт их дуун гарахад дахин ухаан орлоо. Юун дуу хаанаас гарч байна! гэх чих тавих чагнав. Арван таван минут өнгөрлөө. Хонгил дотор чив чимээгүй нам гүм ажээ.

ОТэгэхлээр нэг чулуунд чихээ нааж чагнавал алсад хүмүүс дүнгэр дүнгэр ярилцах дуу сонсдох шиг болов. Эхлээд хий юм сонсдож байна уу гэж бодсон билээ.

Гэтэл тэгээгүй байв. Сайтар анхаарч сонсоход үнэхээр хүний дуу хоолой яриагүй дуулдана. Эцэж сульдсан бие минь тэр яриаг ялган ойлгох хүч өгөхгүй байжээ Гэвч хүн ярилцаж байгаа нь илэрхий болсон юм.

Босож дуу гарсан зүг тийш чүү гэж хэд алхвал яриа улам тод болж үл ойлгогдох хачинх үгс дуулдаж “For lorad” гэдэг үг хэд хэд давтагдав. Хэн юу гэж байгшаа нь энэ вэ? Нагац Ханс хоёроос өөр хэн байх билээ. Тэдний дууг би сонсож байхадп миний дууг тэд дуулах ёстой гэж бодоод

-Нааш ир ээ! Нааш ир! гэж хамаг чадлаараа хашгирав.

Тэгээд юу дуулдах бол гэж харанхуйн дунд чагнаваас хариу эс сонсогдов. Хэдэн минут өнгөрлөө. Миний дуу сул дорой болоод нөхдөд маань хүрч чадсангүй дээ гэж бодлоо. Үнэхээр тийм хэрэг боллоо. Гучин бээр гүн газар дор тэднээс өөр хэн байх билээ.

Дахиад л чагнав. Чагнасаар тэдний дуу арай тод дуулдах газрыг эрж оллоо. “Forlorad” гэдэг өнөөх үг бас л сонсогдоно. Дараа нь аянга ниргэх мэт хүчит их дуун дахингарав.

Үгүй ер нь зузаан хананы цаана гарч байгаа дуу биш хонгил дотроо гарч гагцхүү дуу чимээний тархалтын нөлөөгөөр гажуудан дуулдаж буй хэрэг бололтой!

Дахиад л чагнав. Энэ удаад миний нэрийг дурсан газарчтай ярилцаж яваа хэрэг. Харин “Forlorad” гэдэг нь дани үг байх нь. Учрыг нь сая оллоо. Үгээ дуулгахын тулд хонгилын туургыг дагуулж хэлэх нь зайлшгүй гэж санамагц даруй туурганд ойртож:

-Лиденброк нагацаа! Гэж чадлаара хашгирав.

Тэгэд хариу юу сонсдох бол гэж түгшин хүлээв. Дуу төдий л хурдан дамжагүй бололтой. Хэдэн секунд өнгөрлөө. Тэгж байснаа:

-Аксель, Аксель! Чи юу? ... гэх нь дуулдав.

-Тийм! Тийм!... гэж би хариулав.

Дахин чимээгүй болов...

-Миний муу дүү, чи хаа байна?...

-Багил харанхуйн дунд хаашаага ч мэдэхгүй болоод байна... гэв. Эг хэсэг нам гүм болов...

-Дэн чинь яасан бэ?

Унтарчихсан...

-Горхи яагаа вэ?

-Бас алга болсон...

-Аксель! Миний дүү, сэтгэлээ чанга барьж сэргэ!

Жаахан байзна. Над үг хэлэх ч чадал алга. Харин бага юм яривал ярь!...

-Зоригтой бай. Бүү ярь, миний үгийг сонс! Бид өгсөж, уруудаж хичнээн эрэвч чамайг олсонгүй. Аяа! дүүгээ би гомдоолоо! чамайг Ханс горхио алдалгүй дагаж явсан гэж бодсон юм. Тэгээд хий буу хэд хэдэн тавилаа.. Бидний дуу дууны тархалтын нөлөөгөөр харилцан баахан гажуудаж сонсогдож магад. Одоохондоо гар барилцаж чадаагүй ч гэсэн нэгэнт дуу дуугаа авалцаж байгаа болохоор Аксель минь чи өнгөрөхгүй...

Аврагдах найдвар төрж эхэллээ. Юуны урьд нэг зүйлийг мэдэх хэрэгтэй гэж бодоод хошуугаа хананд ойртуулан

-Нагац аа! гэв...

-Юу гээ вэ? Миний дүү?..

-Бид хоорондоо хичнээн зайтай байгаа мэдэх гэсэн юм?

-Үүнийг мэдэхэд амархан

-Хронометр тань бий юу?

-Би

-За тэгвэл та миний нэрийг хэлээд секундээ тэмдэглээрэй. Би түүнийг дууламгц бас нэрээ давтан хэлье тэгээд миний хариуг сонсмогц сонссон цагаа бас тэмдэглээрэй...

-Зүйтэй, асуулт, хариулт хоёрын хоорондох цагийн тэн хагасыг олох гэж байгаа юм биз дээ?

-Тийм, ахаа аа....

-Зачм бэзэн үү?

-Бэлэн

-За тэгвэл анхаарч байгаарай, чиний нэрийг хэллээ гэв.

Би хананд чихээ нааж чагнавал "Аксель" гэх дуу хүрээд ирэв. Урьдаас нь бас Аксель гэж хариулаад хүлээлээ... цэст:

-Дөчин секунд, хоёр үгийн хооронд дөчин секунд боллоо. Ингэхлээр эндээс гарсан дуу чамайг хүртэл хорин секунд явжээ. Энэ нь бүтэн хагас бээр зайтай гэсэн хэрэг гэж нагац хэлэх сонсдов.

-Бүтэн хагас бээр ий?...

-Тиймээ, их хол газар ч биш шүү, Аксель!

-Уруугаа юу, өөдөө юү?...

-Доошоо уруугаа! Яагаад вэ гэвэл бид нэг уудам агуйд ирээд байна. Тэр агуй өдий төдий хонгил нүхний уулзвар байна. Чиний байгаа хонгил ч бас энд нийлэх ёстой. Ингэхлээр боёсвол л замдаа рорлоо гэсэн үг. Чи гишгэж чадвал газрын налуу руу алхаад, эс чадвал мөлхөж гулгаад ч болсон ир. Замын үзүүрт бид чамайг тосон тэвэрч авна. Миний дүү одоо явж үз! гэв.

Эдгээр үгс миний сэтгэлийг үнэхээр сэргээлээ.

Нагац минь одоо явлаа. Яриагаа завсарлая, баяртай!...

-Баяртай, дахин уулъя. Аксель! Гэсэн сүүлчийн үгс сонсогдов. Зузаан хөрсийг

нэвтлэн ярилцсан ер бусын яриа итгэл найдварын ийм үгсээр дууссан юм.

Нагацын дуу хоолой надад хүрч дуулдахыг бодоход бидний хооронд хаалт саад үгүй бололтой. Дуу гарсан газрыг чиглээд явахад тэнд зайлшгүй хүрэх ёстой байлаа.

Би өндийн газрын налуу уруу гулгаж гарлаа. Удалгүй доош гулгах хурд аймшигтай нэмэгдэж биеэ татаж зогсоох хүч хүрэхгүй боллоо.

Ингэж явтал гэнэт ёроолгүй нүхэнд унах мэт болоод толгойгоороо хад цохиж ухаан алдав.

Ухаан орвол бүрэг харанхуйн дунд зузаан хөнжил дээр хэвтэж балаа. Нагац маань хажууд суугаад амьд байна уу, үгүй юу гэсэн байдалтай царайг минь ширтэж байна. Намайг шүүрс алдахад гарыг атгаад нхүдээ нээхэд минь баярласандаа тэр,

-Амьд байна, амьд байна гэж өөрийн эрхгүй хашгирав

-Тиймээ, амьд байна гэж би сулхан дуугаар хариу өгүүлэв

-Дүү минь одоо дажгүй гээд нагац намайг тэвэрлээ. Ахын үг минь сэтгэлийг ихэд хөдөлгөв

Ханс ч хүрч ирэв. Тэр, нагац миний гар барьж суухыг хараад сэтгэл ханамжтай байхыг нь би ажиж мэдэв.

-God bag гэж түүний хэлэхэд би:

-Сайн байна, Ханс сайн байна уу? гэж хариу мэндлээд

-Одоо бид чухам хаа байна вэ, нагацаа гэж асуув

-Маргааш ярьъя, Аксель минь Өнөөдөртөө бие чинь тун ядуу байна. Унтаж амар, миний дүү, маргааш бүр зүгээр болно.

-Ядаж ямар өдрийн хэдэн цаг болж байгааг хэлж өгөөч!

-Оройн арван нэгэн цаг болж байна. Өнөөдөр наймдугаар сарын 9-ний ням гариг. Наймдугаар сарын 10 болтол чамайг юм ярихыг зөвшөөрөхгүй гэв.

Үнэндээ миний бие маш дорой байсан бөгөөд хоёр нүд өөрийн эрхгүй анилдаж нэг шөнө ч атугай амрах хэрэгтэй байлаа. Бүтэн дөрвөн хоногийн туршид ухаангүй хэвтсэн байна шүү гэж бодсоор зүүрмэглэн унтав.

Дараагийн өдөр сэрээд орчин тойрныг ажиглавал аятайхан агуй нүхэн дотор аяны бүх хөнжил дэвсгэрийг дэвсэж нөдөд ор зассан байв. Алтан шаргал өнгөтэй элсэн хөрс нүдэнд дулаахан харагдана. Дэн асаагаагүй боловч агуй нүхний бяцхан цоорхойгоор бүдэг гэрэл нэвтлэн гийгүүлнэ. Бас далайн давалгаа шуугих мэт сонсогдов.

Анхандаа зүүдэлж байна уу гэж бодсон боловч нүдээр харж чихээр сонссон зүйл яаж худал байх вэ?

“Агуйн дотор өдрийн гэрэл тусаж, давалгаа шуугинх салхи исгэрч байхыг бодвол бид газрын гадаргуу дээр буцаж ирсэн хэрэг биш байгаа. Нагацын удирдсан аялал юу болсон байх нь вэ” гэж бодогдоно.

Нагацыг орж ирэхэд би саяын зүйлсийг асуув.

-Сайн байна уу? Аксель минь! Дээрдсэн байна шүү гэж түүний хөгжилтэй өгүүлэхэд би дэвсгэр дээрээ өндийнгөө:

-Тийи гэж хариулав

-Чи тун тайван унтаж байна билээ. Ханс бид хоёр чамайг ээлжэр сахиж байсан.

-Үнэхээр тамир тэнхээ орсон юм шиг байна. Харин өглөөний хоол өгөхийг эрхэм танаас хүсье!

-Идэлгүй яах вэ, хүү минь одоо халуунгүй болж гэлээ.

Нагац надтай ярилцах зуур өглөөний хоол бэлтгэж өгсөнд би түүнийг гагц минутад хоосолж орхив. Энэ завсар нагацаас өдий төдий зүйл асууж шалграав.

Дээрээс нурсан чулуун нургийн дунд нэг том хадны хэлтэрхийн хамт намайг хэрхэн тэдий гар дээр цус нөж болчихсон ухаангүй унаж ирсэн тухай нагаж надад яриад:

-Чулуун нураг чамайг үнэхээр миянга дахин алж болох байсан. Одоо бид салахгүй. Бие биетэйгээ үүрд уулзахгүй болох шахсан шүү гэв.

“Бид одоо салахгүй” гэдэг чинь аяллаа үргэлжлүүлнэ гэсэн үг үү? Гэж бодоод гайхаж нүдээ бүлтийлгэн харахад нагац:

-Аксель! Чи яав? Гэв

-Би нэг зүйл асууя. Та намайг эрүүл энх, бүрэн бүтэн байна гэв үү?

-Яриагүй тийм

-Хө, гар минь зүгээр байна уу?

-Зүгээр,

-Толгой минь?

-Толгой чинь мөрөн дээрээ яг байдаг газраа байна.

-Ухаан минь ямар байгаа бол?

-Толгой, тархи өвдөөд ч байх шиг!

-Ухаан чинь үү?

-Тийм. Бид дэлхийн гадаргуу дээр эргэж гараад байгаа биш биз?

-Үгүй, яалаа гэж!

-Тэгвэл би солиорч байнаа даа! Надад нарны гэрэл үзэгдэж салхи исгэрэх чимээ, далайн ус эрэг цохилох шуугиан сонсдох юм!

-Аяа! Чи ердөө энэ төдийг мэдлээ гэж үү?

-Юу болоод байгаа юм бэ? Та тайлбарлаач!

-Энэ бол ер бусын тохиолдол болох учраас би огт тайлбарлаж чадахгүй байна.

Гэвч геологийн ухаан тайлбарлаж чадах л ёстой. Чи өөрөө хар, тэгээд юу болсныг ойлгоно гэхэд би орноос өндийн босоод:

-Одоо гадагш гарах уу? гэв

-Үгүй хэрэггүй! Цэвэр агаар гэнэт амьсгалбал чамд муу болно

-Цэвэр агаар уу?

-Тийм, одоохондоо салхи хүчтэй байна. Гараад хэрэггүй байх.

-Миний бие их сайн байна шүү дээ

-Ядаргаа чинь сайн гараагүй байна, хүү минь, дахиад хэвтэж орхиж миэднэ.

Цагаа хайрлах хэрэгтэй, явах зам урт ч байж болно.

-Явах зам ий?

-Тиймээ. Чи өнөөдөртөө амар. Бид маргааш хөлөг онгоцноо сууна гэв.

Энэ ч юу вэ? Хөлөг онгоцноо сууна гэнэ үү? Бидний мэдэлд ямар нэг гол мөрөн буюу нуур, тэнгис байгаа хэрэг үү? Бас тэгээд ямар нэг боомтод усан онгоц байжээ?

Орчны байдал миний сонирхлыг нэн их хөндсөн учир ах намайг хориглож

чадсангүй. Би бушуухан хувцаслаж нэг хөнжлөөр биеэ ороогоод агуйгаас гарав.

Хурц гэрлд нүд гялбаад анхандаа юу ч үзсэнгүй Баахан азнаж нүдээ нээгээд цэл гайхаж, гайхсанлаа

-Тэнгис! Гэж дуу алдвал нагац:

-Тийм, Лиденброк гэдэг энэ дээ. Үүнийг миний нэрээр нэрлэх нь зүйтэй гэж би бодож байна.

Уудам их усан мандал нүдний хараа үл гүйцэх алсад мэлтийн цэлийнэ. Давалгаа эрэг мөргөн шуугиж өзөөлөн салрхи сэвэлзэн үлээнэ. Тэртээ алсад үзэгдэхгүй болж одох тэнгисийн дундаас хадан хясаа өндөрт сүндэрлэн цухуйж харагдана._

Хязгаар хярхаггүй их далай нэг л зэрлэг аймшигтай санагдау.

Далайг “тусгай” ер бусын гэрэл гийгүүлэх тул тртээ алсыг хүртэл үзэж байв. Тэр гэрэл нарных ч биш сарных ч биш харин яах аргагүй цайлгаанаас үүссэн зөвхий хүйтэн цагаа нгэрэл байлаа. Дээш харвал аадар борооны өтгөн үүл тэнгэр бүрхсэн мэт ажээ. Цаашилбал гэрэн холын үүлэнд тусаж, сонин жигтэй сүүдэр үүсгээд хугарч ойсон туяа эгэж буух нь чамин гайхамшигтай үзэгдэл биш үү! Тэр гэрэл нарын туяатай адил илч дулаан үгүй тул гуниг төрүүлнэ. Тоо томшгүй одод гшялалзсан тнгэрийн оронд боржин чулуу толгой дээр үүл мэт дүнсийжээ.

Олон бээрийн өндөр адартай хязгаар хярхаггүй уудам хөндий агуйг бид туулж өнгөрөх хэрэг болжээ. Аялал, жуулчлалын түүх зохиолоос нэртэй агуйнууд олныг мэдэх атугай ч геологийн хувирал энэ мэт том агуй үүсгэдгийг огт мэдэхгүй байла.

Ийм гайхамшигийг бахдан сонирхохдоо хэлэх үг олдохгүй байлаа. Дэлхийгээс алс хол орших далайн ван, тэнгэрийн ван зэрэг гариг дээр ирсэн мэт санагдана. Шинэ юмыг шинэ үгээр нэрлэх хэрэгтэй тул над ти йм үгс яаж байх билээ. Айх, гайхах, ажиглах тогтоохоос өөр зүйл үгүй байлаа.

Гайхамшигт үзэгдэл миний царайд эрүүл энхийн өнгө жавхаа оруулав. Гайхаж долгилсон сэтгэл сэргэж өтгөн цэвэр агаар намайг эдгээв. Явцуу бөглүү хонгил нүхээд дөчин долоо хоног яваад салхины амьсгал, тэнгисийн ус үзнэ гэдэг юутай жаргал болохыг хэн ч хялбархан ойлгох бизээ. Нагац маань энэ бүгдэд дасаад гайхаж сонирхохоо хэдийнээ больжээ.

-Жаахан зугаалах чадал чамд байна уу? гэж асуухад нь би

-Өйлгүй яах вэ, түүн шиг сайхан юм хиаа байх билээ гэсэнд

-Тэгвэл намайг хөтөл, хоёул эрэг дагуу жаахан явъя гэв.

Ингээд шинэ далайн захмаар зугаалахаар гарлаа.

Дэр нь давхарлан тавьсан мэт овоорсон хад цохио лүглэгэр том уул болоон тогтжээ. Тэндээс тоо томшгүй олон усан хүрхрээ дорогш бууна. Энд, тэндгүй суунаглах уур, халуун рашаан хаа байгааг гэрчлэх бөлгөө. Олон гол горхи зөөлөн дөлгөөн урсаж далайд цутгана.

Тэдний дундаас замын хань газарч болсон өнөөх Ханс горхи би олж таньсан билээ. Горхи маань газар дэлхий буй болсноос хойш үргэлж ингэж урсаж байсан мэт их тэнгист дөлгөөхнөөр цутган орж замхрахыг хараад:

-Энэ маань биднийгээ ингээд орхидог байжээ гэж би шүүрч алдаж билээ.

Яг энэ үед нэг үзэгдэл анхаарлыг татлаа. Биднээс таван зуун алхмын зайтай

газар нэгэн өндөр бөгөөд өтгөн ой харагдав. Төдий том биш, дугуй хэлбэртэй модод нь чулуун уохио мэт салхинд огт хөдлөхгүй ажээ. Түүний зүг яаран алхав. Гэвч тэр хачин ургамлыг нэрлэж чадсангүй. Моддын сүүдэрт хүрэхэд миний гайхал бахархлаар солигдов. Модод хэдийгээр аварга том боловч газар дээр бас тохиолддог зүйл байлаа. Нагац түүний газрын нэрээр нь нэрлэж::

-Энхэ чинь дан мөнгөн ой байна гэсэн билээ

Нээрээ моднууд нь гучаас дөчин фут хиртэй өндөр цагаан мөөгнүд байлаа. Нэг дор хэдэн мянгаар ургасан моддыг гэрэл нэвтэлж чадахгүй тул мөөгөн ойн дотор хав харанхуй ажээ.

Очиж үзмээр санагдаад дөхөж ойртвол “моддоос жихүүн жавар сэнгэнэнэ. Бид тэр харанхуй хүйтэн газраар хагас цаг явж үзэд эргэж далайн эрэг дээр ирэхэд над хичнэн тааламжтай байсан гэж санана.

Гэвч танихгүй, одоо ургамалтай газар доорхи агуй шүү дээ. Холхонд бас цайвар навчистай төгөл мод багшран үзэгдэв. Тэр нь газар дээр байдаг хөвдтэй нэгэн төрөл энгийн уршамал гэж амархан танигдавч ургаа мод шиг том бөгөөд зуун фут өндөр ховор чухаг хөвд байлаа.

-Гайхаж ханашгүй сонихон оо! Дэлхийн бөмбөрцгийн эхний зуун жилүүдэд ургаж байсан бүдүүлэг модод байна шүү дээ. Хараач, сонирхооч Аксель минть! Урогамал судлагч ямар ч хүний толгойд иймэрхүү зүйл төрөөгүй байх гэж нагацыг бахдан өгүүлэхэд би:

-Та ёстой зөв ярьж байна. Одоо эрдэмтдийн сэргээн дүрсэлдэг эдгээр ургамлыг байгаль дэлхий энд хэвээр нь хадгалж үлдээжээ гэв.

-Тийм, хүү минь, бидний хөлийн дор гишгэгдэж байгаа амьтны ясны үлдэгдлийг бас хар гэхэд нь би:

-Ясны үлдэгдэл гэнээ? Нээрээ эртний амьтдын яс байна гэж би дуу алдан аварга биетний ясыг олж хараад ясны хэлтэрхийн зүг ухасхийв.

-Энэ мастдонтын яс, тэр динотерийн шүд энд мегатерийн ясны хэлтэрхий байна гэж шууд нэрлээд

-Эдгээр амьтад газар дорхи энэ тэнгисийн эрэг дээр ийм ургамлын сүүдэрт амьдарч байж. Байз! Бүтэн хэлхээ яс ч байх шиг гэв.

-Тиймээ, тэдгээр амьтад агуй дотор амьдарч байсан юм байна. Ер нь одоо ч энэ ойн гүнд буюу тэр хадан хясааны цаана байхыг хэн үгүй гэх вэ? гэж нагац өгүүлэв.

Үүнийг соноод айх мэт болж тэртээ алс дахь бүрэлзэх барааг ажиглан харав. Гэвч ямар чамьтан үзэгдсэнгүй.

Ингэсээр байтал бие жаахан ядрав. Би далайн давалгаа халин цохилох нэгэн том чулуун дээр очиж суухаар явлаа. Тэндээс тэнгисийн нэгэн хэсэг цэлийн харагдана. Тэртээ алсад хоёр хясааны хоорондох зай бяцхан үүд хаалга мэт үзэгдээд тэнгисийн усан тайван мэлтийнэ. Тэр хаалгаар ямар нэгэн онгоц юу юугүй гараад ирэх шиг боллоо.

Гэвч нүдэнд үзэгдсэн зэрэглээ байсан тул дорхноо алга болов. Энд бид хэдээс өөр хэн байх билээ дээ. Салхи намжиж хад чулууны исгэрэх дуун зогсоод далайн давалгаа тогтжээ. Би алс хаяаг ширтсээр бөгөөд тэнгисийн зах хаа байна? Хаа хүрдэг бол! Бид үүний цаад захыг хүрч чадах болов уу? гэж бодогдоно.

Нагац ч хүрнэ гэж бат итгэжээ. Харин би хүрээсэй гэж хүсэвч баахан зүрх алдах шиг боллоо.

Ийнхүү сонин гайхамшигт үзэмжийг нэг цагийн хиртэй бахдан сонирхоод ирсэн замаараа агуйн зкүг буцав. Эргэж ирээд элдвийн хачин жигтэй зүйлсийг эрэгцүлэн бодсоор гүн нойронд дарагдан нойрсов.

Маргааш нь нойроос сэрэхэд биеий байдал ихэд дээрдсэн байлаа. Усанд орвол бүр ч сайн болох байх гэж бодоод ёстой газар дундын энэхүү тэнгист хэдэн минут орохоор явлаа. Газар дундын гэх нь саях тэнгист яг таарах нэр байсан юм.

Тэндээс би юм идэх асар их хүсэлтэйгээр өглөөний хоолонд эргэж ирэв. Голтой, устай болохоор Ханс тун сайхан хоол бэлтгэжээ. Хоолны сүүлд кофе цай өгсөн нь онц таалагдаж билээ.

-Одоо тэнгисийн усны дүүрэлтийн цаг болоод байна. Энэ сонин үзэгдлийг судлах хэрэгтэй гэж Нагацын хэлэхэд би гайхан:

-Юун дүүрэлт билээ гэж дуу алдав.

-Яриагүй тийм

-Нар сар, энд хүртэл үйлчлэнэ гэж үү?

-Яагаад үйлчлэхгүй гэж Биетэй бодитой мо бүхэн ертөнцийг таталцах хүчинд захирагддаг. Ус ч ялгаагүй тэр түгээмэл хуулинд бас захирагдах ёстой гэв.

Ийнхүү ярилцан тэнгисийн захыг дагаж элсэн дээгүүр алхалж явахад усны долгио эргийн зүг улам улам түртсээр байв.

-Нээрээ дүүрэлт болох нь шив гэхэд нагц:

-Тэгнэ, Аксель минь тэнгисийн ус арван фут хүртэл дээшлэхийг чи нүдээрээ үзнэ г эв.

-Ямар хачин юм бэ!

-Юу нь хачин байх вэ, байгалийн жам юм чинь!

-Тэгвэл усанд нь загаж байж болох нь ээ.

-Одоохондаа загаж харагдахгүй л байна

-Дэгээ хийгээд үзвэл яасан юм бэ!

-Тэнгисийн бүхий л нууцыг сайн мэдэхийн тулд дэгээ ч хаяж үзнэ дээ, Аксель минь

-Ах аа, одоо бид чухам аль тушаа хүрээд байна вэ? Үүнийг ер асуусангүй шүү. Багаж хэрэгсэл тань юу гэж байна.?

-Бид Исландаас 350 бээр холдоод байна.

-Луужин зүүн өмнө зүгийг заасан хэвээрээ д байгаа юу?

-Тийм , би түүнийг тун анхааралтай ажигладаг юм. Ер нь их л сонин хэрэг болж байна.

-Ямар сонин хэрэг вэ?

-Луужингийн зүү хоёр туйлыг заахаа больж голоосоо дээшээ сугарч гарчих гээд байх боллоо.

-Дэлхийн бөмбөрцгийн гадаргуу дээр байдаг соронзон хүчний туйлыг энд бас байх ёстой гэж үзэж болох уу?

-Болохгүй яах вэ? Хэрэв дэлхийн туйлын яг дор овчол соронзон зүү чанх дээшээ босох ёстой.н Харин өөр тийшээ бол газрын хичнээн гүнд оровч татах хүчний төв дайралдах ёсгүй л юмсан.

-Тэгвэл, үүнийг шинжлэх ухаан мэдээгүй зүй байх нь дээ.

-Хүү минь, шинжлэх ухаанд чинь зөндөө төөрөгдөл таамнал байдаг юм. Гэхдээ тэдгээр төөрөгдөл таамнал хүнийг үнэн мөний зүгт алхам алхам аар ойртуулдаг

-Одоо хэдийчинээ гүнд ороод байна?

-Гучин таван бээри йн гүшнд гэж нагацыг хэлэхэд газрын зураг дэлгэн харангаа:

-Тийм бол, их Британийн умарт хэсэг, мөс цасанд хучигдсан өндөр уулсынхаа хамт бидний дээр байна дээ гэлээ.

-Тийм, бидний дээр хүндхэн шиг ачаа байгаа боловч боржин чулуун давхарга маань зузаан болохоор гайгүй байх гэж профессор ёжтойхон хариулав.

-Тэнгэр толгой дээр унана байх ч гэж бодохгүй байнха... Харин та одоо яах төлөвлөгөөтэй байна? гэж би асуулаа.

-Буцах уу гэнэ ээ? Юу гэсэн хэрэг вэ? Энд хүртэл сайн сайхан явж ирчихээд байж аялалаа үргэлжлүүлэлгүй яах вэ гэхэд нь би

-Энэ их усан далайн ёроолд хэрхэн нэвтэрч орохыг би мэдэхгүй л байна гэлээ.

-Би ч гэсэн далай руу үсэрч орох гээгүй байна. Гэхдээ энэ тэнгис бүхэлдээ боржин чулуун давхрааны агуу уудам хонхорт тогтсон байх ёсто.

-Тэр ч тийм л байх

-Тэгэхлээр, тэнгисийн нөгөө эрэг дээрээс цааш явах зам олдоно гэж бодож байна.

-Энэ далай хэдий хир өргөн байх вэ?

-Гуч юм уу, дөчин бээр

-Мөөн

-Цаг алдалгүй, маргаашнаас л тэнгист гарч аялъя гэв. Онгоц завиар явахгүй ч гэсэн нэг том сайхан салаар явна даа, хүү минь

-Салыг ч гэсэн завьтай адил дархалж хийх бололцоо энд байгаа юм уу. Юу ч харагдахгүй л юм байна.

-Аксель минь, чамд үзэгдэхгүй, харин сайн чагнавал дуулдаж мэднэ

-Дуулдана аа?

-Тийм, чи Хансын ажиллаж байгааг сонсоно.

-Ханс сал хийж байгаа хэрэг үү?

-Тийм

-Юу! Мод олсон гэж үү?

-Мод ч бүр бэлэн байна л даа. Явъя. Чи хар! Гэж нагац өгүүлэв.

15 минут хиртэй явсны дараа байгалиас заяасан усан буудлын эрэг дээр Хансын ажиллаж байхыг үзлээ. Хэд алхаад дэргэд нь хүрч очив. Элсэн дээр бараг бэлэн болгож боосон сал байхыг хараад ихрэд гайхлаа. Өдий төдий модны зомгол газар дээгүүр хөглөрчээ.

-Ямар мод вэ, нагац аа? гэж асуухад:

-Энэ бол тэнгисийн усны нөлөөгөөр эрдэсжсэн мод байгаа юм гэж хариулав.

-Нээрээ юу? Тэгвэл чулуу шиг хатуу болсон байгаа биз дээ. Усанд яаж хөвөх юм бэ?

-Заримдаа усанд хөвдөггүй босоогоороо живж ордог мод байдаг юм. Харин

эндэхийн мод тэгэхгүй байх.

Хар даа гээд нагац нхэг бяцхан мод авч тэнгист чулуудвал хэсэгхэн зуур алга болсноо усан дээрхөвөн гарч ирэв.

-Одоо харав уу гэж нагац хэлээддүүгүй болов.

Дараачийн өдрийн орой сал бэлэн болов. Сал уртаараа арван фут өргөнөөр таван фут болжээ. Бөх олсоор багласан бат найдвартай хөлгөө усанд оруулж тавихад тэнгисийн мандал дээр зөөлөн дайвалзаж байв.

Наймдугаар сарын 14-нд өглөө эрт сэргцгээв. Аялалаа хурд нэмүү, ядаргаа багатай шиг үргэлжлүүлэх ёстой болов.

Гурван сургааг босгоод нэгэнд нь юм нөмөргөж дарвуул хийв. Олс ё хүрэлцэж, сал ч бэх бат болжээ. Бүх зүйл бэлэн боловч.

Зургаан цагт профессор салан дээр гарах дохио өгөв. Идэшний зүйл, дэвсгэр бүхээ, багаж хэрэгсэл, буу зэвсэг болон их хэмжээний цэнгэг ус гаргаж атвьжээ. Ханс залуурдаж эхэлмэгц бид эргээс даруй холдож одов. Гарах үед нагац тэрхүү бяцхан боомтод миний нэрийг өгье гэв

-Над өөр санал байна гэж намайг хэлэхэд тэр:

-Ямар? Гэв.

-Граюбены нэрийг өгье. Граюбен боомт гэж гэх нь газрын зураг дээр ч зохимжтой харагдана гэв.

-Тэгвэл, яах вэ, Граюбен боомт ч болог гэж зөвшөөрлөө.

Зүүн хойноос аясын салхи салхилж өтгөн агаар салын дарвуулыг хүчтэй үлээх учир хурдан урагш давтолно.

Нэгэн цаги йн дараа хурдын тодорхойлж нагац хэлэхдээ:

-Хэрэв ийм хурдтай явбал өдөрт гучин бээр явж удахгүй нөгөө эргийн бараа харах юм байна гэв.

Би юу ч дуугарсангүй салын хошуунд очиж суухаар явав. Гарснаас хойш, эргийн бараа дорхноо холдож нүдний өмнө уудам тэнгис цэлийгээд усны гадаргуу дээр гагцхүү үүлний сүүдэр буужээ. Энд тэндгүй цахилгаан цахилж гялалзана. Төдий удалгүй газрын бараа бүрмөсөн үзэгдэхгүй боллоо.

Үдийн хирд усны мандал дээр ям ар нэг ургамал үзэгдэв. Тэдгээр ургамал арван хоёр мянга гаруй фут газрын гүнд дөрвөн зуу орчим атмосферын даралт дор ургадаг ажээ. Ургамлын буйр хүрээ гурав, дөрвөн мянган фут үргэлжлэх боловч Лиденброк тэнгисийн хязгааргүй уудамд их нь ер үл мэдэгдэнэ. Би бүтэн цагийн турш энэхүү ургамлын хүрээг нүд салгалгүй ажиглав. Байгаль гэдэг ийм ургамлыг зохион бүтээдэг юутай хүчтэй вэ? Ер газар дэлхий үүссэн тогтсон анхныхаа зуун жилүүдэд ямар сонин байж вэ?

Үдэш боллоо. Гэвч цахилгаан гэрлийн хүч огт буурсангүй. Оройн хоолны дараа би шоргийн ёроод хэвтээд тэр даруй тайван унтлаа.

Залж жолоодох хэрэгцээ байсангүй тул Ханс ч салаа зөнд орхижээ.

Граюбен боомтоос гарснаас хойш профессор Лиденброк “замын тэмдэглэл” хөтлөх ажлыг надад даалгасан юм. Би харсан тохиолдсон бүх зүйл, салхины чиг, аяллын хурд, явсан замын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хийх ёстой болов.

Ингээд аяллынхаа тухай өгүүлэхийн тулд уг тэмдэглэлээ энд ашиглая.

Наймгудааг сарын 14-ний баасан гариг. Баруун хойноос салхитай. Сал урагш шув шулууханх довтлон хурдална. Эргээс гучин бээр холдсон атал эсрэг зүгт харагдах бараа юу ч үгүй. Гэрэл байдаг л янзаар. Тэнгэр сайхан. Өндөрт харагдах үүл бага бага зэрэг өтгөн. Агаар цэвэр, термотетр+32 градус заана.

Үдийн алдад Ханс нэг дэгээ зэхэж үзүүрт нь бяцхан мах өлгөөд усанд шшидэв. Бүтэн хоёр цагийн турш юу чя бари гдсангүй. Эцэсийн удаа дэгээг гэнэт угз татвал нэг загас дүүжигнэн гарч ирэв.

-Загас, загас гэж нагац дуу алдав.

-Загас, загас гэж би ч бас хашгирав.

Профессор загасыг анхааралтай ажиглав. Загасны толго йдугуй хавтгай бөгөөд амандаа шүдгүй, биедээ сүүлгүй ажээ.

Түр зуур ажиглалт хийсний дараа нагац:

-Олон зуун жилийн өмнө соснож үгүй болсон нэгэн төрөл загасны язгуурт хамаарагдах амьтан байна гэхэд нь би:

-Ямар сонин юм бэ? Сая үүнийг амьпаар нь барсан шүү дээ? гэв.

-Тиймээс, ийм амьтныг амьдаар нь барина гэдэг байгалийн ши нжээч хүнд ёстой ховор тохиолдол, их аз шүү. Гэхдээ энэ загас сохор юм байна гэж нагац загасыг ажигласан хэвээр өгүүлнэ.

-Сохор гэнээ!

-Тийм, газрын дорхи усанд оршдог бүх загас сохор байдаг юм. Тэдэнд харах эрхтэн угаасаа байдаггүй гэв.

Соонирхож харвал өнөөх загас үнэхээр нагацын хэлсэнчлэн байв.

Ханс дэгээгээ янзлаад дахин шидэв. Ингээд хоёрхон цөгийн дотор өдий төдий олонх загас барив. Тэд цөм үзэх эрхтэн үгүй байлаа. Үүгээр бид идэх юмнбхаа нөөцийг сэлбэв.

Тэнгисийн мандлыг дурандаа ажиглаж явахад зөвхөн зах хязгааргүй хоосон ус мэлтийнэ. Нөгөө эрэгт хүрэх дөхсөн байлтай билээ!

Өтгөн агаарт шувуу нисэж явдаггүй байгаа гэж бодоод дээшээ харвал юу ч эс үзэгдэв. Хэдий тийм атугай ч миний бодол палентологийн ухааны элдэв таамлалд автагдан үгүй болсон юмыг нүднээ үзэхийг санааши рч усны мандал дээр эртний аварга биетнүүд гараад ирэх ш иг бодож байлаа. Эргийн сүүдрээр эрт балрын өлөн гүрвэлүүд давхилдан хад хясааны цаагуур орж нуугдах ч ш иг, гарьд их шувууд өргөн далавчаа дэлгэн нисэж явах ч шиг санагдана.

Бодол сэтгэлд минь тэр цагийн элхий бүхлээрээ амилан харагдана. Одоо үеийн цаг улирал уур амьсгал гэнэт үгүй болж хөрст дэлхий маш халуун дулаан болсон байх юм. Би хэдэн зуун фут өндөр авраг моддын дундуур сүүтэгнэн явсаар сүүдэрт нь орж хэвтэх юм.

Зуузн зуун жилүүд өдөр хоног мэт хурдан өнгөрнө. Газар дэлхийн өөрчлөлт хувиралтыг сэтгэлдээ дэс дараалан улируулан сэргээж бодлоо. Эхлээд тэр үе ийн амьтад үгүй болно, дараа нь ургамал бас үгүй болно. Халууны эрч улам ихсэж уур манан газар дэлхийг бүрхээд дэлхий нар шиг том сэвсгэр хий болж нэгэн халуун халймаг ертөнц болон дүрслэгдэнэ. Тэр их уур манан сансаро огторгнуйн дунд, би өөрөө өчүүхэн жижиг хумхийн тоос мэт хөвж явах яю. Ямар сонин юм бэ! Тэгж хөвөөд хаа хүрэх бол! Хий бодолхуурмаг үзэгдэлд сэтгэл автагдсаар профессор, газарч

хоёр болон сууж яваа салныхаа аль алиныг хэдийнээ мартжээ.

-Хүүе, чи яаж байна? Болгоомжтой бай. Усанд унах нь гэж нагацын хэлэхэд би нүдээ нээсэн хир нь юу ч үзэхгүй байв. Ханс миний гараас шүүрч авав. Ханс байгаагүйсэн бол хэдийнээ далайд унах байсан юм.

-Чи галзуурав уу? гэж профессор дуу алдахад

-Юу болов, яав? Хрэмээн сая ухаан орлоо би

-Бие чинь муу байна уу?

-Үгүй, миний нүдэнд юи үзэгдээд байсан, одоо зүгээр боллоо. Бидэнд муу юм тохиолдоогүй биз!

-Үгүй, зүгээр. Салхи зөөлөн, тэнгис тогтуун байна! Хурдлан довтолж яваа тул удахгүй нөгөө эрэгт хүрэх байх гэв.

Наймдугаар сарын 15. Бямба гариг. Тэнгисийн ус цэлийсэх хэвээр. Газрын бараа үл харагдана. Тэнгэрийн хаяа тэртээ алсад замхарна. Түрүчийн бодол сэтгэлийн мухарт бас л үлджээ.

Нагац над шиг хий бодолд эс автагдавч сэтгэл санаа нь тайвангүй бололтой. Алсад үзэгдэх бараа бүхнийг урамгүйхэн дурандаж ажиглана.

Гэвч аялал мэнхд сайн, сал хурдан явж байхад юундпаа жуаарлах билээ.

Нагац аа таны сэтгэл баахан түгшиж байх шиг байнаа даа? гэж би асуув.

-Түгших гэнэ ээ? Үгүй ээ үгүй

-Тэгвэл яараа юу, та

-Ай паа, тэгэлгүй яах вэ

-Бузгай л хурдан явж байна даа....

-Тийм ч удан яваагүй, гэхдээ л энэ тэнгис мөн ч их болоод байна шүү! гэв.

Бидний замд гарахын өмнөхөн профессор тэнгисийн өргөний гучин бээр хиртэй гэж байсан. Одоо түүнээс гурав дахин урт замыг тууаад байхад гнь зах нь бас л үзэгдэхгүй байна.

-Доошоо уруудсан ч юм алга. Ингэж явсаар хамаг цагаа алдах нь. Би ер нь хөлөг онгоцоор зугаалахдаа үүн шиг хол явж байсангүй! гэж профессор энэ аяллын хөлөг онгоцооор зугаалах зугаалга гэж нэрлэж ярихад би:

-Хэрэв Сакнусемийн явсан замаар орсон бол.... гэтэл нагац үг тасалж:

-Харин ээ, энэ чинь эргэлзээтэй л болоод байна. Түүний замаар орж чадав уу, үгүй юу? Сакнусем ийм тэнгистэй дайралдсан бол уу? Горхи дагаж урууддаг маань биднийг зөв замд оруулав уу, буруу замаар явчив уу гэв.

-Ямар ч гэсэн байгалийн энэ сонинх үзэгдэл гайхамшигтай... гэтэл нагац дахин үг булууж:

-Зүгээр харж гайхахад хамаг учир байгаа юм биш. Би зориг зорилготой, хүрэх газарт айхүн! Гайхах хачирхснаа бүү ярь! гэв. Тэгэхэд нь би түүнийг бухимдаж л байг гэж бодоод орхив. Оройн зургаан цагт Ханс хөлсөө нэхэж гурван риксдалиа авлаа.

Наймдугаар сарын 16. Ням гариг. Онцын юи юу ч тохиолдсонгүй. Уур амьсгал нэг л янз: Гэрэл буураагүй тул салын сүүдэр усны гадаргууд тусна.

Тэнгис үнэхээр зах хязгааргүй бололтой. Газар дундын тэнгис шиг буюу Атлантын далай шиг их байж ч мэднэ. Ер нь үгүй гэх газаргүй шүү дээ.

Нагац, тэнгисийн гүнийг мэдсе гэж үзүүртэй тээглүүртэй олс авч усанд хаяв. Гүн нь ч ихгүй бололтой Гэвч тээглүүртэй олс хүндэрч арай ядан татсаар сал дээр

гаргаж ирэхэд Ханс түүний зааж:

-Rander гэхэд би түүн рүү харав. Гэвч исланд газарчийн ам байн байн хөдлөхөөс өөр юу гэж байгааг ойлгосонгүй. Харин тээглүүрийг анхааралтай ажин хараад гайхсандаа би:

-Шүд байна гэж дуу алдаад тиймээ яах аргагүй шүд мөн байна. Ийм шүдтэй амьтан асар их хүчтэ байх ёстой. Хэдийнээ сөнөж үгүй болсон гайхалт амьтны төрлөөс нэг нь үлдэж хоцроод усны гүнд амьдарч байдаг юм биш байгаа даа? Миний бодол бодит байдал дээр батлагдвал яана? гэж бодлоо. Энэ бодол бүхэл өдөржин надаас салсангүй.

Наймдугаар сарын 17. Даваа гариг.

Би тэдгээр амьтдын байдал төрхи йн дүрслэн бодохыг оролдов. Тэд аварга их биетэн байжээ. Хүч чадлыг нь яана? Одоогийн хамгийн том матар зөгий боловч анх эртний өвөг дээдсийнхээ дэргэд өчүүхэн жижиг байх билээ. Ийм амьтдыг хэн ч нүдээр үзээгүй. Тэд хүн үүсэхээс олон зуун мянган жилийн өмнө дэлхий дээр бий болжээ. Гагцхүү яс нь манай үед олддог байна.

Ханбургийн үзмэрийн газар уртаараа гучин фут аварга биетний араг яс зсэн билээ. Тийм амьтантай гэнэт тулгарвал яан? Үгүй, тэгэх ёсгүй! гэж бодсон хир нь тэнгисийн усыг харахаас айх мэт болно.

Профессор Лиденброфийг мөнөөхөн тээглүүрээ ажиглаж далайг ширтээд байхад нь надтай адил юм бодож байна уу гэж бодлоо. Энэ тэнгис элдвийн бодол төрүүлж тээглүүрт шүд нь орсон тэр амьтан биднийг дайрах юм шиг дүрслэгдэн бодогдов!... Буу зэвсгээ харвал цөм байр байрандаа бэлэх зэхээстэй байлаа. Усны гадаргуу гүрэлзэн долгиулж аюул ойртох шиг! Ер нь анхааралтай байх хэрэгтэй.

Наймдугаар сарын 18. Мягм ар гариг.

Энэхүү далайд шөнө болох гэж байдаггүй боловч бидний цагаар орой болж унтах боллоо. Ханс харуулд гарч бид унтацгаав. Хоёр цаг хиртэй болсны дараа нэг чанга ёврох шиг болоход нь би сэрлээ. Нэг юм усан дороос хүчтэй цохин муу салыг дөчин фут хол авч шидэв.

-Хүүе, юу вэ? гэж нагац дуу алдав.

Ханс тэртээд харагдах хэсэг хар юмыг хуруугаараа заахад би түүнийг хараад:

-Далайн гахай байна гэж хашгирав.

-Тийм байна. Бас тэнд нэг том далайн гүрвэл байхыг хараач гэж нагац хэлэв.

-Түүний цаана бас нэг мундаг матар зөий байна. Шүдий нь хараач! За тэр, алга болчихлоо!

-Хүүе, халим, халим ус туршин цацаж байгаагийн нь гэж нагац дахин хашгирав.

Үнэхээр хоёр салаа усан багана өндөрт оргилон тэнгисийн усан дээр цацран бууж байв. Бид эдгээр аварга амьтдыг айж гайхах зэрэгцэн харж байлаа. Тэдний хамгийн жижиг нь ганц удаа мөргөхөд л муу салыг бут үсэргэж мэдэх байв. Ханс эргэж зугатах гэтэл нөгөө талд бас өөр аюул гарч ирэхийг харлаа. Дөчин фут том яст мэлхий гучин фут могой хоёр уснаас толгойгоо цухуйлган үзэгдэв.

Зугатах газаргүй байв. Аймшигт амьтад ойртон дөхсөөр салы маань тойрон хүрээлэв. Айхдаа карбин буугаа шүүрч авлаа. Гэвч ганц муу карбин өлөн биет

амьтдад юу болох билээ? Нэг талаас матар зөги й, нөгөө талаас аварга могой ойртож ирэхэд айснаас бидний хоолой зангирч дуу гарахгүй болов. Завшаанаар, бусад нь алга болжээ. Хоёр өлөг биетэн салыг үзсэнгүй хажуугаар нь тван зуугаад алхам зайтай өнгөрч бие биедээ довтолж оров. Аймшигт хоёр амьтан салаас нилээд зайдуу газар тулалдахад өнөөх далайн гахай, халим, гүрвэл, яст мэлхий цөм гарч ирээд тулалдаанд оролцох шиг боллоо. Нүдэнд олон амьтан үзэгдээд байхаар нь тэр зүг зааж газарчид үзүүлбэл

-Туа гэлээ.

-Юу? Хоёр гэнээ? Хоёрхон амьтан байна гэж үү? Гэж лавлахад нүдний шил үргэлж зүүж явдаг нагац хажуунаас

-Тийм, зөв гэв.

-Яагаад?

-Яахав ээ, энэ хоёрын нэг нь гүрвэлийн толгойтой матарын шүдтэй юм байна.

Үүнийг ихтиозавр гэдэг юм

-Тэгвэл нөгөөдөх нв?

-Нөгөөдөх нь хуягт могой буюу плезиовр бана гэлээ.

Нээрээ Ханс зөв харсан байлаа. Тэнгисийн гадаргуу дээр хоёрхон амьтан байсан байж. Ихтиозавр нь хүний толгойн чинээ том нүдтэй зуун фут урт биетэй байв. Байгалийн ши нжээчид түүний шүди йг 132 байдаг гэлцдэг ажээ. Плезиозавр гэдэг нь толгойгоо усан дээр гучин фут өндөр өргөж явдаг богинохон сүүлтэй могой ажээ.

Тэд бие биеэ галцуурсан мэт дайрч далайн усыг хуйлруулан оволзуулахад хүчит давалгаа нь салын ирмэгт ирж бид хорин удаа ус уруу онхолдох шахлаа.

Нэг цаг өнгөрлөө, дахиад бас цаг боллоо. Тулалдааны эрч сүр буурах шинжгүй л байв. Тэд саланд нэг ойртож нэг холдон ноцолдоно. Бид буугаа зэхэцгээн хөдлөлгүй зогсоцгов. Тэгж байснаа нэгэн их эргүүлэг үүсгэн гэнэт алга болцгоов. Тулалдаан усны гүнд шувтрах нь уу? гэтэл плезиозаврын том толгой усан дээр дахин ил гарч ирэв. Аварга амьтан шархаджээ. Амь нь тэмцсэн амьтан нэг өндийж нэг унан ус балбаж цацруулсаар асар удалгүй урт бие нь усны тайван мандар дээр сунан гулдайв.

Харин ихтеозавр нь тэнгисийн гадаргуу дээр эргэж гарах болов уу?

Наймдугаар сарын 19. Лхагва гариг.

Салхи хүчтэй болж бид тулалдааны талбараас хурдан зайлж холдлоо. Ханс залуурын дэргэдээс салалгүй зогсож нагац урьдын адил тэнгисийн мандлыг тэсгэлгүй ширтэнэ.

Аялал дахиад л бахь байдаг янзаар үргэлжлэв.

Наймдугаар сарын 20. Пүрэв гариг. Салхи зүүн хойд зүгээс үлээнэ. Агаар нилээд халуу. Бид цагт гурван бээр хагасын хурдтай явав. Үдийн алдад алсаас ямар нэгэн шуугиан сонсогдов. Юуны чимээ болох нь тодорхойгүй байтал

-Тэнгисийн ус хад цохио буюу арлын эрэг цохилж байх бололтой гэж нагац хэллээ.

Гурван цаг өнгөрлөө. Өнөөх чимээ өндөр дээрээс буух ус ны шуугиан адаил дуулдана. Ус орох ямар нэгэн цооног нүх ти йш давхиж яваа хэрэг биш байшаа? Ийм

учрал тохиолдвол бараг эгц доош унах учир профессор таалагдаж болох юм. Харин надад бол...

Шуугианы чимээ улам тодорсоор боловч тэнгэр, тэнгис хоёрын алинаас гарч байгаа нь хараахан үл ялгагдана.

Агаарт өтгөн манан дэгдэж байна уу гэж дээш харвал тэнгэр тогтуун, үүл хөдөлгөөнгүй сэвсийж, гэрли йн туяанд замхран арилах тул дуу чимээ тэндээс гарах учиргүй байлаа. Тэнгисийн хаяаг ажигласан ч бас л уур манангүй тунгалаг ажээ. Тэгээд энэ шууги ан дорогш буух усны чимээ байх нь уу? Далайн ус цөм цооног нүхэд орох гэж үү? чингэвэл усны урсгал улам хурдсах ёстой билээ. Гэтэл тэгсэнгүй.

Дөрвөн цагийн орчимд Ханс босон салны шорог өөд авирч гараад эргэн тойрныг ажиглаж байснаа нэг зүйлийг онцлон ширтэв.

-Бараа олж харав бололтой гэж нагац хэлэхэд би:

-Би ч бас тэгж бодож байна гэв.

Ханс бууж ирээд өмнө зүг зааж:

-Der here гэхэд нагац:

-Тэнд үү? Гэж асуугаад, дунгаа авч нэг минут хиртэй дурандахад тэр агшин надад бүтэн зуун жил шиг удаан санагдаж билээ. Эцэст нь нагац:

-Тийм байна, тийм байна гэж хашгирав.

-Та юу үзэв?

-Тэнхгисийн мандал дээр нэг их ус оргилж байна.

-Өас нэг амьтан байх нь үү?

-Магадгүй

-Тэгвэл жаахан баруунтайгуур явъя. Аягүй бол өнөөх аймшигт амьтадтай дахиад дайралдаж мэднэ шүү! гэхэд:

-Тэгэх ч үгүй байхаа гэж нагац хариу өгүүлэв

-Тэр газарт арван хоёр бээр орчим дөхөж очиход агаарт оргилж буй усан багана тодхон харагдав. Лав аварга том биетэй амьтан байх нь ээ. Зугатах хэрэгтэй боллоо. Гэвч эн зугатахаар ирээгүй тул урагшлахаас өөр яах вэ? Ойртох тутам усан оргил улам том орно. Юу гэгч аймшигт амьтан байдаг бол?

Оройн найман цаг болоход түүнд хоёр бээрийн газар дөхөж очлоо. Биеийн нь өнгө нь хар бөгөөд том, ямар нэг арал мэт усны мандал дээр бараантан сүглийнэ. Урт нь барагцаалбал долоон мянган футээс дутуугүй бололтой. Юу гэгч амьтан бэ? Нойрсож буй мэт үл хөдөлнө. Таван зуун фжт өндөрт оргилох усан багана аадар бороо шиг эргэж буухдаа их шуугиан үүсгэнэ. Зуун халимыг ч нэг өдөр идчихмээр тэр том юм руу бид хар эрчээр давхиж явна. Хамаг бие арзаганаад цааш явамгүй санагдавч профессор юу ч дуугарахгүй тул хэрхэх билээ.

Гэнэт Ханс босож харайж өнөөх том юмыг хуруугаар заагаад

-Наbme гэхэд нагац:

-Арал гэж дуу алдав

-Арал гэнээ? гэж би бас хашгирав.

-Тэгээд энэ усан багана юу билээ? гэхэд

-Geyser гэж Ханс хариулсан бөгөөд нагац ч:

Өө! Нээрээ исландад байдагтай адилхан оргимол булаг байна шүү дээ гэлээ.

Би арлыг амьтан гэж эндүүрсэн байжээ!

Ойртох тутам усан багана улам томорсоор байв. Уг арал ч үнэхээр уснаас толгойгоо цухуйлгасан асар том амьтантай их төстэй балаа. Халуун булгийн усан дээш оргилоод уур манан үүлэнд тултал хөөрнө. Арал дээр цорын ганц оргилуур халуун булгаас өөр юу ч байсангүй. Булгийн оргилох ус цахилгаан гэрлийн туяанд түмэн өнгөөр солонгорно.

-За бууцгаая? Гэж хэлээд нагац бид хоёргазар дээр үсэрч буухад газарч маань байрандаа үлдэв.

Бид халуун божин чулуун хөрсөн дээгүүр алхалж халуун булаг оргилон буух бяцхан цөөрмийн дэргэд очлоо. Усанд нь термометр шургуулж үзвэл 163 градус байв. Булгийн ус хайлмаг голомтоос гарч буй нь илэрхий бөгөөд профессор Лиденброкийн өнөөх онолтой зөрж байлаа. Энэ тухай бид түүнд дурсахад тэр:

-Тэгээд, юу нь миний баримтлалтай харшилж байна гэж? гэв

Энд хүрч иртэл байдал орчин зохистой тааруухан дулаан байвч газрын төвийн халуу чинээндээ тулсан тийм газар хэзээ нэгэн цагт лав хүрнэ гэж би баттай итгэж явсан юм. Одоо тэнд хүрчээ гэмээр ажээ.

Профессор галт уулын гаралтай ээхүү арлыг ми ний нэрээр энэрлээд хөдлөх дохио өгөв. Би оргилуур булгийг ажиглан хэдэн минут зогслоо.

Ингээд л цаш явлаа. Би ажигласан зүйлээ дэвтэрт тэмдэглэхдээ: Бид Граюбен боомтоос гарсаар 270 бээр хөвж, Исландаас 620 бээр холдоод Английн газар дор ирэв гэж бичлээ.

Наймдугаар сарын 21. Баасан гариг. Дараагийн өдөр гайхамшигт оргилуур булаг харагдахгүй боллоо. Салхи бидни йг Аксель арлаас улам бүр холдуулан хөөсөөр шуугин чимээ ч дуулдахгүй болов.

Цаг агаар ч бас өөрчлөгдөв. Уур манан өтгөрч цахилгаан гэрэл буурав. Үүрс хөшиглөн харанхуйлж их шуурга ойртжээ. Өмнө зүг дэх үүлсийг харахад аадр үер буухын урьд ямар болдогтой адилхан сэтгэл тавгүйрч айх мэт болов. Агаар хүндэрч ус тогтуун болов. Агаарт нэлэнхүйдээ цахилгаан дүүрч бидний толгойн үс өөдөө арзайн босчээ.

Өглөөний арван цаг болоход салхи, үүлс шуурганд бэлхэн болсон м эт харагдаад аадар бороо юу юугүй цутгах нь бололтой.

-Агаар тун муухай боллоо! Гэхэд далайн эрэг харагдахгүйд ихэд бухимдаж явсан нагац профессор эс дуугарав.

-Аадар цутгах нь. Үүлс тэнгис дээрээс дарж унах гэж байгаа шиг! Гэж тэртээ хаяаг заан би дахин өгүүлэв.

Эргэн тойрон ер бусын нам гүм болж, салхи ч тогтов. Байгаль дэлхийн амьсгал тасарч үхсэн мэт болжээ. Сал маань долгионгүй тэнгисийн гол дунд хөдөлгөөнгүй зогсов.

Хөдлөхгүйгээс хойш дарвуулын хэрэг юу билээ? гэж бодоод

-Шоргоо эвдэж унагаая гэхэд нагац:

-Юу гэсэн үг вэ! Яах вэ, салхи болбол болог, аадар бороос асарвал асгаг! Эцэстээ биднийг эргийн хаданд ойртуулахдаа л ойртуулна! Муу салы минь чулуу мөргүүлж зомгол болгосон ч яадаг юм бэ! гээд

-Өмнөө ирсэн уур манан бороо болон орно, агаар тэнгэр догшин шуургаар дүүрнэ гэх зэрэг эцэс төгсгөлгүй олон юм ярилаа. Эргэн тойрон улам бүр

харанхуйлав.

Сал маань гэнэт овосхийгээд буухад нагац гуйвж унав. Би түүн тийш мөлхөж очвол тэр олсны үзүүрээс чанга зуураад болж буй үзэгдлийг ихэд сонирхсон янзтай ажиглав байв. Ханс ургаа хад шиг хөдлөлгүй зогсох бөгөөд цахилгаажиги гэрэлтсэн үс нь нүүр рүү нь унжиг сэглийгэд ер бусын хачин дүртэй болжээ.

Сал гэнэт аймшигтай хурадн довтолох болов. Сул асгах аадар бороо бидний өмнө өндрөөс буух усан хүрхрээ болон хөндөлсөнө. Тэнгэр нижигнэн аянга тасралтгүй бууж гялбаа гялбаад тэнгис дүүриэн гал болох шиг болоход шорогноосоо л сайн зуурвал дээр...

Ингээд цааш нь тэмдэглэж чадсангүй. Ямар байдалд орсныг уншигч та үүгээр ойлгох бизээ.

Наймдугаар сарын 23. Ням гариг. Хаа яваа нь ч бүү мэд! Үл мэдэгдэх зүгт хар хурдаар довтолно. Аадар шуурга намжаагүй л байна. Эргэн тойрон аянга ниргэж тэнгэр дуугаран тийм гэхийн арга алга. Дээрээс аянга бууж, дороос цахилгаан харваж боржин чулуун тэнгэрийг доргилуулах нь дорогш нурж унуузай гэмээр ажээ. Заримдаа гал бөмбөлөг хэлбэртэй цахилгаан их дуугаар дэлбэрнэ. Агаарт усан багана оргин далайдаа буцаж бууна.

Хаашаа явж байна вэ?... Халуун нэмэгдсээр....

Наймдугаар сарын 24. Даваа гариг. Шуурга дуусахгүй бол яана! Сал маань ямагт зүүн өмнө зүг довтолно. Аксель арлаас хоёр зуун гаруй бээр алслан холджээ.

Үдийн алдад шуурга улам ширүүсэв. Баглаатай ачаагаа даруулж өөрсдөө тэврэлдэн зууралдав. Том том давалгаа толго дээгүүр дүүлнэ. Гурван өдрийн турш юм ярилцах ч бололцоогүй явлаа. Юм яривч дуулдахын аргагүй нэгийхээ чихэнд хашгиравч үл сонсдоно. Нагац над руу дөхөж хэдэн үг хэлэх нь бид одоо өнгөрлөө гэж байх шиг байлаа.

Гэнэт нэг том гал бөмбөлөг салын ирмэг дээр гарчч ирэв. Тал ннь цагаан, тал нь цэнхэр, хүний толгойн чинээ бөмбөлөг хр шиг эргэлдэн, алгуурхан хөвж хайрцагтай юман дээгүүр дамжин хүнстэй хүүдий дээр гарч лдахин хөөрөх зэргээр энд тэнд тэнэнэ. Тэгсээр өнөөх бөмбөлөг бидэнд ойртоо ирэхэд Ханс түүнийг ширтсэр байсан бөгөөд нагац түүнд хиүэрхгүй тул навтасхийн хоёр өвдөг дээрээ сөхрөв. Бөмбөлгийн хурц гэрэлд миний царай хувхай цайж хам аг бие дагжин чичрэв. Аяа! Яасан хурц гэрэл вэ? гэж бодох зуур бөмбөлөг тасхийн дэлбэрч гал цахилгаан бүрхэв.

Тэгээд эл хуль чив чимээгүй болов. Нүд ээж харахад нагац салан дээр тэрийж хэвтэх бөгөөд харин Ханс байрандаа л зогсож байна

Бид хаана байна? Хаашаа явна вэ?

Наймдугаар сарын 25. Мягмар гариг. Бид удтал ухаангүй байгаад сая сэргэв. Шуурга үргэлжилсээр. Эргэн тойронд аянга бууна.

Тэнгистээ байна уу, үгүй юу? Маш хурдан довтолов сайхь тэнгисээс гарч чадаагүй л байлаа. Энэ янзаар бол Английн арал, Ламаншийн хоолой, Францын нутаг, ер бүх Европ тивийг хэдийнээ доогуур нь явж өнгөрсөн ч байж мэднэ

Бас нэг их чимээ сонсогдов. Лав хадан хясааг мөргөн цохилох тэнгисийн

долгион биз ээ! Тэгвэл...

“Замын тэмдэглэл” гэж нэрлэсэн зүйл ингээд дууссан билээ. Одоо би цааш нь өөрөө хүүрнэн ярьъя

Муу сал маань хөд мөргөх үед чухам юу болсныг бүү мэд! Усанд шидүүлчих шиг л болсон. Ханс намайг дахин аюулаас татан аварсан учир амьд үлдсэн юм. Эрэлхэг исланд намайг халуун элсэн дээр аваачиж нагацын хажууд тавиад ачааныхаа заримыг гаргаж авахаар сал руу буцаж явав. Би ядарч суоьдсан, гайхаж алмайрнаас болоод юу ч хэлж чадсангүй. Тэнхэл орж бослоо бүтэн цаг боллоо.

Бороо ороод байхаар нь бид нэгэн агуйд орж хоргодов. Ханс хоол зэхсэн боловч би түүнд гар ч хүрсэнгүй. Бид гурван өдөр гурван шөнө нойргүй явсан тул төдий удалгүй цөм гүн нойронд дарагдан унтацгаав.

Маргааш нь бороо арилж гайхамшигтай сайхан өдөр болов. Тэнгэр цэлмэж тэнгис тогтоод салхи шуурганы мөр тэмдэг ч алга болжээ. Профессорын сэргэлэн дуун намайг сэрээв.

-За яамай, миний дүү сайн нойрсов уу? гэж Кёнигстрассын гудамжин дахь байшиндаа өглөөнийхөө хоолонд орохоор яалагүй яваа юм шигээ туйлын хөгжилтэй хашгирна.

Гэтэл бид Герман нутаг, элэсэг дотно Ханбург хот, оршин идээшсэн гудамж энэ бүгдийн доогуур хэдийнээ явж өнгөрөөд наад зах нь дөчин бээр зузаан боржин чулууны гүн дор байж билээ. Дөчин бээр зуун шүү! Үнэндээ мянга гаруй бээр аялсан хэрэг шүү дээ. Ингэж бодоход үнэхээр уйтгартай байлаа.

-За яаж орхив? Сэрээгүй л байна уу? Яагаад дуугарахгүй байна? гэж нагацыг дахин асуухад

-Зүгээр, ядаргаа арай л гараагүй банха. Удахгүй зүгээр болно биз гэв.

-Ямар ч гэмгүй.

-Та өнөө өглөө тун хөгжилтэй байх шив.

-Тэгэлгүй яах вэ, дүү минь! Зорьсондоо хүрсэн газар!

-Аяллынхаа эцэс т үү?

-Аяллын эцэст ч биш л дээ. Гэхдээ хязгаар хярхаггүй энэ тэнгисийн эрэгт ирлээ дээ. Одоо цаашаа усан дээгүүр биш хөрсөн чулуун дээгүүр явна. Явсаар бөмбөрцгийн дотоодод орно доо.

-Нагац аа! Танаас нэг зүйл асууя.

-Тэг, тэг, би сонсьё. Аксель минь

-Бид ер нь буцах уу?

-Буцах гэнээ! Хүрэх газраа хүрээгүй байж буцах тухай бодож байна уу?

-Үгүй, зөвхөн яаж буцахыг л мэдэх гэсэн юм

-Түүн шиг амархан юм байхгүй. Дэлхийн төвд очвол дээшээ зам аяндаа олдоно, эс олдож гэхэд ирсэн замаараа буцна. Ирсэн зам маань битүүрчихгүй гэдэгт бат итгэж байна.

-Тэгвэл муу салаа засаж сэлбэмээр юм байна даа.

-Тэгэлгүй яах вэ

-Иэх юм яах билээ.Юм үлдсэн үү?

-Үлдсэнх байх. Хансыг ачаа тээшни йхээ ихэнхийг гаргаж авсан гэж найдаж

байна Явъя, үзье! гэлээ.

Бид нүхнээс гарлаа. Надад сайн саар хоёр бодол нэгэн зэрэг төрөв. Салан дээр ачсан бүх зүйл үгүй болсон байх гэж бодсон маань буруу болжээ. Эсны эрэгт очиход тэнд нямбайлан эгнүүлж тавьсан бөөн зүйл дунд Ханс зогсож байлаа. Нагац, түний гарыг атган баярласнаа илэрхийлэв. Үнэнч хүн, биднийг унтаж байх зуур амралтгүй ажиллажээ. Тэр, амь биеэ хайрлалгүй зүтгэж хамгийн хэрэгтэй зүйлсийг гаргаж авчээ. Гэвч буу зэвсэг гэх мэт их зүйл алджээ.

-Багаж хэрэгслүүд бүрэн байна уу? гэж асуухад

-Хамги йн хэрэгтэй зүйл болох манометр энэ бана. Үүнтэй байсан цагт газрын гүнийг хэмжиж, хэзээ дэлхийн төвд хүрэхээ мэдэж чадна гэж нагац хэллээ.

-Луужин хаана байна?

-Бүб бүтнээрээ энэ байна. Бас хронометр, термометр ч энд байна. Манай газарч үнэхээр сайн хүн юм даа гэв.

Бас шат, олс, зээтүү, ёотуу зэрэг багаж хэрэгслийн зүйлс элсэн дээр хөглөрч хэвтэнэ.

-Хүнсний зүйл яалаа? Гэвэл нагац:

-Юу байгааг нь харъя гэв

Хатсан талх, утсан мах, хатаасан загастай хайрцгууд эрэг дээр байв. Эд бүгд дахин дөрвөн сөр хэрэглэхэд ч хүрэлцээтэй ажээ.

-Дөрвөн сар ч хүрэлцээтэй юм байна. Хүрдэг газраа хүрээд буцахад ч хүрэлцэнэ гэж нагац дуу алдаад

-Ийм их юмтай үлдсэнээ хойш цөмөөрөө нэг сайн хооллож авъя! Гэв.

Түүний занг би сайн мэдэх боловч үргэлж гайхал төрүүлж явдаг хүн билээ.

-Одоо усаа нөөцөлж явъя. Аадар бороо боржин чулууны хонхорт ус тогтоосон байна. Бид цангаж үхэлгүй. Хансыг салаа зас гэж хэлнэ. Муу сал явах аргагүй болсон байх гэхэд нь би:

-Тэгээд яах гэж? гэв

-Дүү минь над нэг бодол төрлөө. Ер нь ирсэн замаараа буцахаа больё гэхэд нь би "галзуурч байгаа юм биш биз" гэсэн байдалтай харвал тэр:

-За явж өглөөнийхөө хоолыг идье гэв.

Би түүнийг дагав. Хатсан мах, талх идэж, цай уугаад сайхан хооллосон болов. Агаар цэвэр, тогтуун чир тавтай сайн хооллож авлаа.

Хоол идэх зуур ахаас бид хаана байгаа тухай асуугаад:

-Тооцоо хэмжээ гаргахад баахан төвөгтэй байгаа байх гэхэд

-Тийм, шуурганы гурван хоногт явсан хурд зүг чигээ тэмдэглэж чадсангүй. Гэвч хаа байгааг тогтоож болно гэв.

-Нээрээ, оргилуур булагтай арал дээр хамгийн сүүлчийн ажиглалт хийсэн билүү...

-Тийм, Аксель арал дээр хийсэн. Тэр бол газрын гүн дотор анх удаа нээгдсэн арал юм.

-За тийм байж! Бид Аксель арал дээр байхдаа тэнгисээр 270 бээр явж Исландаас 600 бээр холдоод байсан.

-За тэгвэл тэндээс хөөж бодъё! Шуурганы дөрхөв хоногт өдөр бүр 80 бээрээс доошгүй хурдтай явсан гэж бодъё.

-Би ч бас тэгж бодож байна. Тэгээд барагцаалахад 300 орчим бээр явж шүү дээ.

-Зүйтэй. Ингэхлээд Лиденброк тэнгис нэг эргээс нөгөөг хүртэл 600 бээр зайтай байх нь. Бараг газар дундын тэнгис шиг том байх нь байна шүү гэхэд би

-Хэрэв тооцоо зөв бол одоо яг бидний толго дээр жинхэнэ газар дундын тэнгис байна даа гэв.

-Нээрээ юу?

-Нээрээ, учир нь бид Рейкьявикаас 900 бээр холдоод байна шү дээ!

-Үгүй ер, мундахгүй явж дээ, хүү минь! гэхдээ Туркийн дор ч юм уу, Атлантын далайн дор ч ирээд байж болно шүү дээ?

-Салхины чиг огт өөрчлөгдөөгүй болохоор эргийг Граюбен боомтоос зүүн өмнө зүгт байгаа гэж бодож байна.

-Луужинг харвал дорхноо мэдэгдэнэ. Аль вэ харъя гээд профессор луужин уруу зангав. Тэралгаа илж их л тааламжтай байх бөгөөд залуу хүн шиг хөгжилтэй байлаа. Би түүнд луужинг авч өгөв.

Нагац луужинг авч тэгшхэн тавиад ажиглаж байнсаа нүдээ нухалж дахиад харав. Тэгээд над уруу харж гайхсан байдлаар

-Юу болж байгаа нь энэ вэ? гээд намайг хар гэж ддохив. Би бас гайхсандаа дуу алдав. Луужингийн зүү бидний өмнө гэж бодож байсан зүгийг хойд гэж зааж байв! Сэгсрээд үзвэл эвдрэл гажиггүй зөв зүгээр байх юм.

Шуурганы үеэр салхи эргэснийг мэдэлгүй анх гарсан эргийн зүг буцаж явсан хэрэг байх нь дээ гэж бодлоо.

Профессор Лиденброкийн сэтгэлд юу бодогдсоныг тодорхойлон бичих аргагүй байлаа. Нагац луужинг хараад анхандаа гайхсан боловч эцэстээ бухимдан уурласан билээ. Аюул аймшигийн дундуур туулж гарсан ядаргаат замаа давтах гэж үү! Явж өнгөрсөн олон бээрийн газрыг дахин туулах гэж үү?

-Аяа Хий салхи, гал, ус эд бүгд хүчээ зангидан явах замыг минь саатуулж буй хэрэг үү! За яах вэ! Гэвч зориг юу чаддагийг эд үзнэ. Яасан ч бууж өгөхгүй дээ. Хүн байгаль хоёрын алин нь ялахыг үзүүлнэ! Гэж нагац занаж байв.

Хадан хясаа дээр гарч зогсоод ингэж хашгирч байлаа. Отто Лиденброк үнэхээр цог золбоотой байж билээ. Түүнийг тайтгаруулах санаатай

-Та намайг сонсоно уу? Аливаа юманд хэмжээ хязгаар гэж байдаг, дийлэхгүй зүйли йн эсрэг тэмцээд яах вэ! Бид далайн аялалд бэлхэн биү байна. Салхи шуурга салыг маань хэхчээд залах залуурдах юмгүй болжээ. Санашгүй бэрх замыг хоёр дахь удаа туулах гэдэг солиотой хүний ажил! Гэж би эрс шийдэмгий өгүүлэв. Арваан минутын туршид учирлаж ярьсан миний ярианаас профессор нэг ч үг тоож сонссонгүй. Харин:

-Саландаа! Гэж командлав. Чулуунаас хатуу тийм зори гтой хүн байлаа. Энэ үед Ханс салаа засаж дууссан байв.

Профессор газарчид нэг үг хэлбэл, Ханс даруй ачаа бараагаа ачаалж юу юугүй явахаар зэхэж гарав. Агаар нилээд тунгалаг, салхи ч намжуухан байна.

Тэр хоёрыг би ганцаар эсэргүүцээд хэрхэх билээ? Хэрэв Ханс миний талд

байсан бол бас ч яах вэ! Гэтэл тэгсэнгүй. Тэр исланд, эхэндээ үнэнч итгэлтэй учир дураараа дургиж чадахгүй байсан биз. Явахаас өөр аргагүй боллоо.

Намайг сал дээр гарч суух гэтэл ах гараас барьж зогсоогоод:

-Маргааш болгож байж замд гарна шүү. Нэгэнт энд ирснээс хойш, явахаасаа өмнө эндэхийн байдалтай танилцъя гэж бодож байна гэв.

Тэнгисийн хойд эрэгт буцаж очсон гэхэд анх бидний гарсан газар юутай ч гэсэн биш байсныг хэлэх хэрэгтэй. Граюбен боомт арай баруугаар ч байж мэднэ гэж бодоод

-За явъя, үзье! гэж зөвшөөрөв.

Тэгээд Хансыг ажил дээр нь үлдээгээд бид явлаа.

Тэнгимсийн эрэг тэнэгэр өргөн бөгөөд зүсэн зүйлийн хэлбэртэй том жижиг дун хясаа хөлд гишгэгдэнэ. Эрт галавын амьтад ийм дун хуягшийн дотор амьдардаг байжээ.

Профессор хад цохио бүрийг анхааралтай ажиглаж шинжиж хэмжинэ. Заримдаа Граюбен боомттой төстэй газар, гол горхи, усан хүрхрээ дайралдахаар нхь аминд орсон Ханс горхи маань мөн байна, амь хоргодож байсан өнөөх агуйдаа эргэж ирж дээ гэмээр байлаа. Гэтэл хэдэн алхам цаашлаад үзэхээр гол горхи нь ч хад цохио ч эргэлзээ төрүүлнэ.

Профессор ч бас тэгж бодож байгаа бодолтой.

-Бид амь гарсан газартаа эргэж ирсэн нь үнэн болов уу даа. Тэгсэн бол эрэг дагаж явсаар Граюбен боомтод хүрэх ёсто доо гэхэд нагац:

-Тэгвэл сал дээрээ очъё, чи андуураагүй биз гэв.

-Хад цохио бүхэн хоорондоо адилхан тул андуурахгүй гэж хэлэхэд хэцүү байна. Харин Хансын с ал дархалсан мөнөөх газрыг таних байх гэж сана. Манай жижиг бомт энэ биш ч гэсэн эндээс холгүй байх ёстой.

-Ээд, үгүй байх. Аксель минь, гэрэв тийм бол бид өөрсдийнхөө мөртэй дайралдах ёстой, гэтэл юу ч харагдахгүй... гэтэл нь би элсэн дээр хэвтэх нэг гялтганасан юм олж үзээд түүний зүг ухасхи йнгүүтээ:

-Би харлаа, энэ байна гэж дуу алдав

-Юу вэ?

-Энэ гэж хэлээд нэгэн чичлүүр илд хутга газраас авч ахад үзүүлэв

-Байз, чи чинь ийм хутгатай байл уу?

-Үгүй, харин танд байгаагүй юу

-Үгүй, над ерөөсөө байгаагүй.

Над ч гэсэн байгаагүй, ахаа.

-Яасан хачин юм бэ?

-Хачин юм юу байх вэ% Исландчууд л голцуу ийм хутгатай байдаг. Тэгэхээр Ханс л үүнийг гээчихсэн хэрэг гэвэл ах хутгыг их л анхааралтай ажиглаж хараад:

-Аксель минь энэ хутга бол Ханс, чи бид гурвын хэнийх ч биш, харин арван зургадугаар зууны үеийн Испаниас гаралтай нэгэн төрөл зэвсгийн зүйл байна гэв.

-Та юу яриад байна аа?

-Аксель минь, бид агуу их нээлти йн амсар дээр ирээд байна шүү! Энэ хутга энд элсэн дээр гурван зуун жил хэвтжээ.

-Хутга өөрөө энд ирээгүй нь лав. Тэгэхлээд хэн нэгэн хүн биднээс түрүүлж...

-Тиймээс, нэг хүн ирж

-Хэн байх вэ?

-Тэр хүн хутга дээрээ нэрээ сийлсэн байх! Бамс дэлхийн төв орох замыг өөрийн гараар тэмдэглэхийг ч оролдсон байх. За сайн шинжье! Гэв

Бид газар дээрх ор мөр бүрийг сонирхон нэгжиж мөшгиж гарлаа. Тэгсээр явтал тэнгисийн ус ханан хаданд ойртож эргийн өргөн нь долоон алхам илүүхэн болж нарийсав. Хоёр хадны завсраар харанхуй нүхний амсар онгойж харагдав. Тэнд нэгэн хавтгай боржин чулуун дээр үсэг мэт хоёр зураас байв. Энэ нь үл мэдэгдэх жуулчны овог нэрийн эхний үсгийг тэмдэглэсэн

Гэсэн томъёо байжээ.

“Арне Сакнусем! Арне Сакнусем гэж байна. Хаа явсан газар дандаа Арне Сакнусем дайралдах юм гэж нагац дуу алдав.

Аян замд анх гарсан цагаас хойш гайхамшигт учрал олонтаа тохиолдож хирийн юманд гайхахгүй боллоо гэж бодож явсан билээ.

Гэтэл гурван зуун жилийн өмнө хадан дээр сийлсэн хоср үсгийг үзээд ихэд цочин гайхлаа. Би алхимич эрдэмтний хадан дээр бичс эн нэрний нь үсги йг үзс эн төдийгүй бас түүнийг хэрэглэж явсан хутгыг нь бариад зогсож байсан хэриэг билээ. Тийм эрэмтэн байснаар барахгүй корьсон аяллаа биелүүлсэн гэдэгт эргэлзэхээ болив.

Ийнхүү элдвй йг бодох зуур профессор Лиденброк хэлсэн нь:

-Ёстой суут ухаан шүү! Хөрст дэлхийд үнээс өөр газрын төвд хүрэх зам олно гэж бүү бод. Чиний гишгэсэн мөрийг гурван зуун жили йн дараа хүн олж, нэр чинь өөр жуулчныг бас зорьсон газарт нь хөтлөн дагуулж болох нь байна шүү! Манай гаригийн төвд өөрийн чинь гараар сийлсэн нэр хожим дахин олдож болох нь байна. Ямар сайхан хэрэг вэ? Би ч бас энэ чулуун хуудсан дээр нэрээ сийлнэ! Ер нь тэнгисийн энэ хошууг Сакнусемийн хошуу гэж нэрлэе байз гэв.

Үүнийг сонсоод миний урам зори г ч сэргэж сэтгэлийн угт дахин гал бадрах шиг боллоо. Туул өнгөрүүлсэн аюул зовлон нэг мөсөн мартагдаж хүний хийсэн бүхнийг хийчихмээр санагдаад болохгүй, бүтэхгүй юм огт үгүй мэт болов.

-Явъя, үзье гэж хашгираад харанхуй агуй руу ухасхийтэл нагац профессор хориглож:

-Эхлээд Ханс дээр очиж салаа авчиръя гэв.

Би түүний тушаалыг дагав. Явах замдаа:

-Нагац аа бидэнд аз таарлаа шүү! гэж хэлэхэд нагац:

-Чи тэгж үзэж байна уу Аксель гэв

-Тэгэлгүй яах вэ. Салхи шуурга л биднийг шулуун замд орууллаа шүү дээ. Аадар бороо л энд авчирлаа. Хэрэв Лиденброк тэнгисийн өмнөд эрэгт очсон бол Сакнусемийн нэрийг олж үзэхгүй байжээ.

-Тийм нь ч тийм, Аксель минь Бүр гайхаад барахгүй зүйл боллоо. Нэг л юмны учир огт олдохгүй байнха.

-Учры нь олоод байх юу байх вэ? Ашиглавал л барав.

-Тэр ч тийм л дээ хүү минь, гэхдээ...

-Одоо умар зүг чиглээд л явъя. Бид Европын хойд хэсэг, Орос нутаг, Сибирийн доогуур гарна. Харин Африкийн цөл, далайн усан доогуур явахгүй нь.

-Тиймээс, Аксель минь, чиний зөв. Бүх юм сайн сайхан болоосой! Бид энэ тэнгисийг хөндлөн гарах хэрггүй, харин ямагт доошоо явах хэрэгтэй. Одоо дэлхийн голд хүртэл зөвхөн мянга таван зуун бээр үлдээд байгааг мэдэж байна уу?

-Эш, тэгвэл дэмий яриад яах вэ? Бушуухан явъя гэж би дуу алдав.

Ханс аян замын бүх зүйлийг бэлджээ. Биднийг салан дээр арч суухад Ханс салаа Сакнусем хошууны зүг залав. Оройн зургаан цаг болж байхад үзсэн эрэгт хүрлээ. Би нагац, газарч хоёрын араас эрэг дээр дэвхэрч буулаа. Энд ирсэн нь намайг эс тайвшруулав.

-Аян замдаа гаръя, цаг алдаад яах вэ гэж нагацаас шаардахад:

-Тэгнэ, хүү минь, урьдаар хэдүүл саяын агуйг шинжиж үзье. Шат хэрэгтэй болж мэднэ Аваарай! Гэж нагац өгүүлэв.

Агуйн амсар таван фут өргөн тул дотогш хялбархан нэвтэрч болох байлаа. Эхлээд бараг тэгшхэн газраар явж байснаа зургаа алхаад нэг том чулуун тулаад зогсов

-Золи гийн чулуу вэ! гэж нагац уцарлав.

Баруун, зүүн, дээгүүр доогуур нь хичнээн үзэвч тойрч гарах газар ер олдсонгүй. Ийм саад тохиолдсонд итгэлгүй чулууны доогуур нь шагайж дээгүүр өлийж харвал зай завсар огт алга. Ханс дэнгийнхээ гэрли йг хананд тусгаж нэгживч бас л юу ч олсонгүй. Нэвтэрч гарах ямар ч найдлагагүй боллоо. Би гайхаш тасраад газар дээр лангхийн суулаа. Нагац том том алхлан агуй дотуур холхино.

-Сакнусем яаж явсан байх нь вэ? гэж намайг асуухад нагац:

-Харин тийм ээ. Энэ чулуун хаалт түүнийг цааш алхуулаагүй гэж үү дээ? гэв.

-Үгүй, яасан ч тэгээгүй байх! Чулуу хожим ойчиж зам бөглөсөн байх. Та тэр том чулууны дээд талыг хараач энэ агуй хэзээ нэгэн цагт их лав чөлөөтэй урсдаг зам байсанх байна. Энэ чулуу доош гулгаж нэг өөдөр газар тулжээ. Тэгэхээр Сакнусемийг үүгээр явж өнгөрөхөд ийм саад байгааг үхэрэг. Үүнийг хөдөлгөж зайлуулахгүй бол бид дэлхийн төвд хүрч чадахгүй гэсэн үг! гэв.

Үүнийг ярихдаа би өнгөрснөө бүрмөсөн мартаад ирээдүйд юу болохоо ч бодоогүй, сэтгэлд дотно суурин тосгон, Ханбург хот, Конигстасс гудамж, хөөрийн Граюбенаа ч санасангүй билээ.

-За ёотуугаар арай л хатуудах юм гэлээ.

-Тэгвэл зээтүүдые!

-Зээтүүдэхэд дэндүү зузаанх юм даа!

-Тэгээд...

-Тэгээд үү? Дарь! Саадыг дэлбэлье!

-Дарь гэнээ!

-Тиймээс, хадыг цөм цохих хэрэгтэй гэтэл

-Ханс! Түргэлээрэй! Гэж нагац хашгирав

Исланд газарч даруй салан дээр очоод даринь нүх гаргахаар нэгэн ёотуу авчрав. Тавин фунт дарь багтаах нүх гаргана гэдэг бас ч амар ажил биш байв.

Хансыг нүх гаргах зуур би урь шидмэс бэлтгэхэд нь ахалд тусалж байв.

-Бид цааш явж болох бий гэж намайг хэлэхэд нагац:

-Явж болно гэж давтан өгүүлэв.

Гаргасан нүхэндээ шөнө дундийн үед тавин фунт дарь хийгээд профессор

-За маргааш болъё! Гэв.

Ингээд барагдашгүй зургаан цагийг хүлээх боллоо.

Дараагийн өдөр нь наймдугаар сарын 27. Пүрэв гариг. Энэ өдөр манай аяллын түүхэн тэмдэглэлт өдөр болсон юм. Үүнийг дурсан санахад одоо ч миний сэтгэл хөдөлж зүрих цохижл байна. Өглөөний зургаан цаг болоход бид хэдийнээ босоцгоосон байв. Боржин чулуун ханыг дариар дэлбэлэн зам гаргах цаг мөч ойртлоо.

Шидмэс асаах хүндтэй үүрэг над ноогдов. Шидмэсийг асаамагц сал дээр байсан нөхөдтэйгээ нийлж, далайн уудамд гарч аюулаас зайлах бодлоготой байв. Шидмэс арван минутын дотор шатаж дуусах завсар амжиж сал хүрэх ёстой байлаа.

Ингээд сэтгэд догдлом ажилдаа бэлтгэв

Хоолоо яаран идэцгээсний дараа нөгөө хоёр маань сал руугаа явж би шидмэс асаах дэнгээ аваад тэндээ үлдсэн юм.

-За хүү минь яв,хурдхан шиг эргээрэй гэж нагац захи в.

Тэр даруй би агуйн амсарт чиж дэнгийнхээ хоргыг нээгээд шидмэсний үзүүрийг авав.

Профессор хронометрээ атган:

-Бэлэн үү? Гэж хашгирахад би:

-Бэлэн гэв.

-За тэгвэл асаа! Хүү минь гэв.

Би шидмэсийг асаагаад усны эрэг уруу эргэж гүйлээ. Сал дээр хүрч ирэхэд:

-Бушуу суугаарай, явъя гэж нагац яаруулав. Хансыг салаа түлхмэгц эргээс даруй зуун алхам холдов. Энэ бол туйлын хариуцлага мөч байж билээ. Профессор хронометрийн зүүнээс нүдээ үл салган ширтэж:

-Таван минут үлдлээ, одоо дөрөв... гурав гэж тоолно

Зүрх түг түг цохиллов.

-Хоёр, нэг! ... Чулуун уул нуртугай гэж нагац хашгирав.

Тэгээд юу болдог бол гэж ажиглавал дуу чимээ огт дуулдаагүй мөртөө харсаар байтал хадан хясааны хэлбэр гэнэт өөрчлөгдөн хөшиг адаил хоёр тийш ярагдан уудам амсар гарч онгойв. Тэнгисийн усанд их давалгаа гарч салы маань тэртээ дээш нь сэгийлгэн өргөхөд бид тэнцвэр алдан ойчлоо. Нэгэн агшины зуур хрурц гэрэл гялсхийж хамгийн харанхуй газрыг ч гэрэлтүүлэн гийгүүлэх үед сал доош унах шиг болов

Багил харанхуй, их чимээ, аймшиг гайхамшиг бүхний эзэмдсэн боловч адал учрал нэгэнт болж өнгөрснийг би ойлгов. Таягдан шидүүлсэн хадны оронд агуйн амсар онгойн харагдаж газар хөдөлсөнх байдал санагдуулна. Гэтэл тэнгисийн ус, агуй уруу цутган юүлж бид бас урсгалд нь хамагдан орох нь тэр!

Одоо өнгөрчээ гэж бодогдлоо.

Нэг, хоёр, цаг лав болсон байх! Сайн мэдсэнгүй! Бид усанд ойчихгүйн тул гар гараасаа барилцан зууралдаж явлаа. Хонгил агуй зайтай нь илэрхий байв. Сакнусемийн явсан зам яриагүй мөн бололтой. Бид хэдүүлхнээ уруудахын оронд бүхэл бүтэн тэнгисийн хамт энд юзлэн оржээ.

Хурдан галт тэрэгнээс ч түргэн доош унаж байлаа. Ийм байдалд бамбар асааж болохгүй байв. Харамсалтай нь эцсийн ганц цахилган дэнгээ хагалчихсан байв. Гэтэл дэргэд мини гэнэт гэрэл гарв. Маш гайхаж харвал Хансын хэнэггүй тайван царай өөрий нь асаасан дэнгийн гэрэлд тодхон харагданха.

Хонгил агуй нилээд уудам учир дэнгийн бүдэг гэрэл агуйн хоёр нханыг нэгмөсөн гэрэлтүүлж чадахгүй байлаа. Усны урсгал нэн түргэн. Сал нүхний хананд ойртох нэгэн агшинд хэдий хир хурдан яваагаа тоймлосон бөгөөд цагт гучин бээрээс дутуугүй бололтой. Нагац бид хоёр хугарсан шорогийн ёрдгороос зууран барьж эргэн тйорноо тасралтгүй ажиглаж явав.

Цаг өнгөрсөөр атал байдал өөрчлөгдөхгүй хэвээр.

Би ачаа бараагаа жаахан янзалж засах гэж оролдох зуур нилээд зүйл үгүй болсныг мэдлээ. Дэн барьж сайтар шалгаж үзэвл багаж хэрэгслээс маань зөвхөн луужин, хронометр хоёр үлдсэн байх бөгөөд ажлын багажаас олсны тасархай төдий үлдээд зээтүү, ёотуу, алх сэлт цөм үгүй болжээ. Хүнсний зүйлээс нэг өдрийн хоол ч үлдсэнгүй. Эрээд эрээд өчүүхэн хэсэг борц, хэдэн ширхэг жигнэмэгээс өөр юм болдсонгүй.

Хичнээн ажиглавч тийм гэх тойм, алга. Ямар аюул заналхийлж байгааг бүү мэд. Сарын байтугай жилийн хүнстэй болж чадах байсан ч усны урсгалд автагдан орж исрэн энэ хонгилоос яаж гарах билээ? Өлсгөлөнгийн аюул тулгарч үхлийн ирмэг дээр ирдэг байжээ. Өлсөж үхэх цаг болсон гэж үү? Дэлхийн гадаргуу дээр гарч чадахгүй гэж үү? Хэрхэн хаагуур гарах вэ? Мянган найдвараас ганц нь ч гэсн байвал горь тасрах ёсгүй гэдэг билээ. Гэвч бидэнд өлсгөнөлөнгийн үхлээс зайлах арга юу байх билээ. Сэтгэлд бодогдсон бүхнээ нагацад хэлээд амьд байх цаг мөчөө тоолон хүлээж болох байсан боловч зори глосонгүй.

Энэ завсардэнгийн гол асаж дуусаад бөхөв. Хав харанхуй болоход би хүүхэд шиг нүдээ анив.

Нэгэн хэсэг болсны дараа хурд бүр нэмэгдэв бололтой. Налуу газраар уруудан урсах биш, эгч доош унах мэт боллоо.

Нагац, Ханс хоёр намайг хоёр талаас чанга барина.

Гэнэт сал маань нүхний ёроолд тулж зогсох шиг болов. Усан хүрхрээ тэр чигээрээ дээрээс асгаран буув. Азаар асар удсангүй уужим газар дахин гарч ирэв. Тэр хоёр гараас минь чанга атгаж гурвуул салан дээр арай ядан тогтов.

Ороын арван цаг болж байх шиг байлаа. Хонгил нүхний дотор чимээ шуугиан тасарч нам гүм болжээ. Бид удтал дуугүй байснаа эцэст нагац::

-Дээшилж байна шүү! гэв

-Юу гэнээ?

-Тийм, өгөгдөж байна, дээшилж байна гэв

Би хоёр гараа алдалбал хананд шүргэж зүлгэгдэн цус гарлаа. Тийм их хурдан дээшилж байжээ.

-Бамбар, Бамбар гэж профессор хашгирав.

Ханс оролдсоор арай хэмээн бамбар асаагаад эргэн тойрныг бүрэн ажиглаж болохтой болов.

-Тийм байхаа, тийм ч болов уу гэж бодсон юм. Өргөнөөр гучин фут хүрэхгүй зайтай бачуу цооногт оржээ.

Ус нүхний ёроолд дүүрч дахиад өргөдөхөд нь бид бас түүний хамт дээшилж байна гэж нагац өгүүлэв.

-Тэгээд хаа хүрдэг бол?

-Аан мэдэхгүй. Ер нь аливаад бэлэн л байх хэрэгтэй. Цылагт гурванх бээр хагасын хурдтай дээшилж байна. Энэ янзаар бол тун хол явах дагаа.

-Тиймээс, замд юм тээглэхгүй, тэгээд энэ цооног дээд талаа онгорхой бол ч их явна даа. Харин дээрээ битүү бол усны түрэлт бидний таазтай нь няц шахна биз гэхэд нагац маш тайвнаа:

-Аксель минь, байдал бараг найдваргүй болжээ. Гэхдээ бас нэг юм байна. Үхэж үрэгдэх агшин байхад аврагдаж амь гарах агшин мөн байж болно гэв.

-Тэгээд яах вэ?

-Юм идэж хүчээ салбэх хэрэгтэй гэхэд нь би гайхаж нагацыг ширтээд

-Юм идэх ий! гэвэл нагац:

-Тиймээс! Гээд даниар хэдэн үг хэлэхэд Ханс толгой сэгсрэв.

-Юу гэнээ! хүнсээ алдчихсан гэж үү? Гэж нагац дуу алдахад би:

-Тиймээс миний хэлснийг ойлгосонгүй бололтой урдаас ширтэхэд нь би:

-Тэр ч яах вэ. Т тэгээд аврагдаж болно байх гэж бодож байна уу? гэж асуусанхд тэр хариу үл хэлэв.

Нэг цаг хиртэй боллоо. Тун их өлссөнөө би сая мэдэрч эхлэв. Бусад маань ч бас л их өлсөж зовж байсан биз. Харин хэн маань үлдсэн өчөөүхэн хүнсэнд гар хүрсэнгүй.

Маш хурдан дээшилсээр л байлаа. Тэх тусам улам халуун болж дөчин градус шахлаа. Яагаад ийм болов? Халууны эрч хэдийд буурах бол? гэж бодохдоо дэлхийн дотоод галын тухай онол надад гарцаагүй үнэн хэвээр л байлаа. Магадгүй, бид шатам халууны дотор хадны голд орсон ч байж болно. Тэгээд профессор ингэж хэллээ.

-Бид усанд цацаж, чулуунд даруулж, өлсөж гуринхалж үхэхгүй гэхэд галд түлэгдэж үхэх нь зайлшгүй боллоо гэвэл нагац юу ч дуугарсангүй. Харин нэг цаг орчим өнгөрсний эцэст сая ам нээж:

-Ер нь нэг тийшээ шийдэх хэрэгтэй дээ гэв.

-Нэг тийшээ болно гэнээ?

-Тиймэс, хүч тамираа сэлбэх нь хэрэгтэй дээ. Үлдсэн жаахан хүсээийдэхгүй бол туйлдаа хүртэл сульдах болно.

-Тэгээд хүч тамираа сэлбэх ямар арга байна?

-Туйлдаа хүртэл ядрах нь алба биш шүү дээ

-Гэсэн ч нагац минь энэ өчүүхэн хэсэг махыг идчихээд юу өөрчлөгдөх вэ дээ?

-Юу ч болохгүй л дээ! Аксель минь, гэхдээ нүдээ ухаж идсэнээс дээр биш үү?

Чи ямар ч зориггүй чадалгүй хүн шиг ярих юм! гэхэд нь би:

-Таны итгэл найдвар тасраагүй л байна уу? гэвэл нагац:

-Үгүй, тасраагүй л байна гэж хатуу шийдэмгий хариулав

-Юу гэнээ! Та ямар нэг найдлага бий гэж бодож байна уу?

-Тиймээс заавал бий. Зори гтой хүнд хэзээ ч найдлага тасрах ёсгүй гэхэд юу хэлэв гэж байгаа юм бол! Ямар сонинхүн дэг вэ! гэж бодоод

-Тэгээд та яая гэж байна? гэвэ.

-Үлдсэн хүсээ идээ сульдсан хүчээ сэлбээ гэв.

-За яах вэ, тэгвэл идэцгээе гэж эцэстээ би зөвшөөрөв.

Нагац, хэсэг мах, хэдэн ширхэг жигнэмэгийг гурав адилхан хуваагаад даруй өөрийнхөө хувийг авч их л амтархан идэв. Би хэдийгээр өллсөж байвч дурамжхан идлээ. Харин Ханс жижиг жижиг хазаж тайван зажилж идээд дундуур устай бяцхан дашмаг гарган “уу!” гэж бидэнд өгөв.

Энэ бол бидний сүүлчийн хооллолт боловч сэтгэл санаа бага зэрэг тавигдаж билээ. Тэр үед өглөөний таван цаг болж байв. Хоол идсэний дараа дор бүрнээ гүн бодолд автагдав. Мухар сүжигт Ханс чухам юу бодож байсныг бүү мэд... Миний тухайд гэвэл би өнгөрсөн явдлаа дурсан санаж байлаа. Тэр бодол намайг газрын хөрсөн дээр эргэж гарсан мэт болгов. Кенигсрасс гудамжин дахь манай байшин, тэнд хоцорсон хайрт хон Граубен, сайхан сэтгэлт Марте авгай цөм нүдний өмнө дүрслэгдэн үзэгдэнэ. Дэлхий дээрх хот суурингийн хөгжөөнт дуу чимээ зузаан хөрсийг нэвтлэн сонсогдох шиг болно.

Нагац маань гартаа бамбар барьж чухам ямар байдалд байгаагаа мэдэх гэсэн бололтой ханын үе судлыг анхаарлтай ажиглана. Эрдэмтэн хүн хаана ч эрдэмтэн л байдаг ажээ.!

-Боржин чулуу үргэжлэхийгш бодоход эрт галавын үед л явж байна даа. Гэвч зогсотгүй дээшилж байна. Юу болохыг хэн мэдэх вэ? гэж тэр үглэнэ.

Хэн мэдэх вэ? гэдгийг нь бодвол түүний найдлага тасраагүй бололтой. Нагац ханыг гараараа шүргэж үзээд хэсэг зуур болсны дараа,

-Энэ чинь уулын талст чулуулаг байна! Одоо удахгүй завсрын үе судалд орно. Тэгээд... гэснээ дуугүй болов.

Профессор юу хэлэх гээ юм бол? Биднээс дээш хичнээн зузаан хөрс байгааг хэлэх гээ юм болов уу? Үүнийг зөв тооцоолох арга түүнд бий гэж үү? Манометрээ алдсан болохоо р ямар арга байх билээ

Халууны хэмжээ маш хурдан ихсэж байлаа. Шатах хийн дотор орсон мэт санагдана. Сүүл сүүлдээ бид хүрэм, хантаазаа удаа дараагаар тайлж хаяв. Халууны хувь илүү нэмэгдээд ирэхээр би:

-Шатах голомт өөд очиж байгаа юм биш биз? гэж дуу алдахад нагац:

-Үгүй, тэгэх ёсгүй, тэгэх учиргүй гэж хариулав.

Тьэгэхэд нь би ханад гараа хүргэж:

-Тэгвэл энэ хана улайсчихсан бадаг юу билээ гэж хэлээд усанд гараа дүрэн угз татангуут:

-Халхай, буцалмай ус байна гэж хашгирав

Профессор гагцхүү уурласан байдалтай урдаас ширвэ. Аймшигт бодол намайг эзэлж удтайл тайвиширч чадахгүй байв. Аюул сүйрэл ойрхон ирсэн бололтой. Мартаж зайлуулахыг хичнээн хичээвч дүрслэн хэлэхэд айдас хүрэм нэгэн бодол толгой тархиаас үл салан байн байн бодогдоно. Боржин чулуун хаан доргилон хөдлөхийг ажиглаад ямар нэг явдал гарцаагүй болох нь гэж мэдлээ. Үүнд цахилгаан гүйдэл учир холбогдолтой бололтой. Түүнээс болж халуун үүсэж, ус буцалж байх шиг байлаа... Би луужинг харав. Энэ луужинг харав. Энэ чинь юу вэ?

Юу болох нь энэ вэ? Луужингийн зүү урлд зүг цэг зааж хой зүг нэг зааж зүг

бүхэнд солбилзон эргэлдэнэ...

Нийтэд илэрхий онолын ёсоор бол дэлхийн газар шоро хэзээ ч үнэмлэхгүй байдалд байдаггүй йгэдэг билээ. Гэтэл түүнээс хэтэрсэн энэ үзэгдэл миний сэтгэлд арга буюу айм шиг төрүүлнэ.

Чимээ нүргэлгээн туйлын их нэмэгдэв. Тэр чимээ тасралтгүй нигжигнэх тэнгэрийн дуутай адаил ажээ. Цахилгаан гүйдэлд орсон луужин доргин чичигнэсээр... Газрын хөрст бут үсэрмээр болов. Нүсэр том боржин чулуу нурж биднийг хумхийн тоос болтол дарж алах вий!

Нагац аа! Нагац минь, одоо өнгөрлөө гэж намайг уду алдахад нагац:

-Бас л яагаад айж үхчи гээд байгаа юм бэ? Юу болов? гэж тайван өгүүлэв.

-Би ганцаараа айж байгаа хэрэг үү! Ганхаж багаа хана, хагас үсэрсэн хүдэр том чулуу, дариглан буцлах ус уур, галзуурсан мэт эргэлэх луужингийн зүүг хархгүй байна уу! Газар хөдөлж байна биш үү! Гэхэд нагац толгй сэгсрэн:

-Газар хөлдөлж байна гэнээ? Гэвү

-Тийм

-Үгүй хүү минь, чи эндүүрч байх шиг байна

-Яалаа гэж! Та газар хөдлөхийг мэддэггүй юм уу?

-Газар хөдөлнө гэнээ? Үгүй. Харин түүнээч ч илүү хэрэгтэй юм болж байна уу даа, гэж бодож байна.

-Тэгээд та юу гэх гээв?

-Аксель минь, галт уулын дэлбэрэлт болж бах шиг байна.

-Галт уулын дэлбэрэлт гэнээ! Тэгвэл элбэрдэг галт уулын цооног дотор орчихо юу? гэж асуухад профессор:

-Тийм л болов уу гэж бодож байна. Ингэсэн бол ч тун сайн хэрэг! Гэв.

Сайн хэрэг гэнэ үү? Галзуураагүй байгаа? Ямар юм ярьж байгаа нь энэ вэ? Юунд ийм санаа амар байна вэ? гэж бодоод:

-Яагаад тэр билээ? Бид дэлбэрч байгаа галт уул дотор орчихсон хэрэг үү? Хайлмаг лав, улайссан чулуу, буцламгай усан дээр яваа хэрэг үү! Тэгээд гал, чулуутай хамт агаарт шидэгдэх гэж үү? Энэ чинь юу нь сайн байгаа юм бэ? гэж дахин асуувал профессор намайгширтэн:

-Тиймээс, дэлхийн гадаргуу дээр эргэж гарах цорын ганц нйдлага л энэ байгаа юм гэсэн билээ.

Миний толгойд түм буман бодол хутгалдан орлоо. Нагацын хэлбэн түмэн зөв байжээ. Гэвч дэлбэрэлтээс сайн юм блно гээд санаа амар байх гэдэг бөх зүрх шүү!

Үргэлэж дээшилсээр шөнийг өнгөрөөв. Дуу чимээ хувь илүү ихсэж агаар дутагдан амьсгаа давхцаж ирэхэд амьд явах цаг мөч дуусчээ гэж бодогдоно. Бид галт уулын цооногт орсон нь гарцаагүй боловю. Салан дор буцламгай ус, усан дор хайлмаг лав, улайссан хад, эд бүхэн уулын тогоо црамад хүрээд найман зовхист цацагдана.

Энэ галт уул Снеффельсээс бүр ч илүү хурц идэвхтэй бололтой. Ямар уул бол? Дэлхийн аль хэсэг ордог бол? Бодвол хойд талын нутагт л байхаас зайлахгүй. Бид Сакнусемийн хошуунаас умар зүгт зуугаад бээр явсан юм даг. Ер нь исланд арлын дорх эргэж очсон хэрэг биш байгаа? Тэгвэл Хекл уул буюу эсвэл энэхүү арал дээрх өөр нэг галт уулын тогоо цармаар гарч болох нь ээ? Бас Спицбергээс холгүй

орших нэгэн бяцхан арал дээр Еск ч гэж нэг галт уул бий! Цөм л тогоо царамтай уулс даг.: Алинаар нь гардаг бол гэсэн бодол намайг эзэмдэв.

Өглөө болоход өргөгдөх нь бүр ч хурдан болж халуун ч улам эмэгдэв. Хэдэн зуун атмосферийн даралттай тэнцэх асар их хүч биднийг түлхэж байна гэдэгт эргэлзэхгүй байлаа. Ямар аюул болдог бол доо.!

Удалгүй цооног нүхэн дотор улаан туяа тусав. Цооног нүхний баруун, зүүн хананд хонгил нүхнүүд үзэгдэжтэндээс өтгөн уургарах бөгөөд хананаас нь гал улалзана.

-Хараач! Хараач! Нагацаа! Гэж намайг хашгирахад нагац

-Аан тийм, гал байна. Дэлбэрэлтийн гал жирийн галаас огт ялгаагүй юм байна гэв.

-Үгүй, тэгээд энэ гал биднийг шатаачих байгаа даа?

-Шатаахгүй!

-Тэгэхгүй ч гэсэн бүтэж үхвэл яана.

-Хонгил нүх дээшлэх тутам уужим болж байгаа тул бүтэж ч үхэхгүй. Тун болохгүй бол салаа орхиж хажуугийн нэг агуйд орж хоргодно.

-Дээшилж байгаа ус тийшээ юүлж орохгүй юу?

-Одоо ус байхгүй болсон. Аксель минь, гагцхүү лав л биднийг дорос өргөж тогооны амсарт хүргэнэ гэв.

Үнэхээр шингэн зүйл үгүй болжээ. Халууны хэмжээ далан градус хүрсэн бололтой. Хурдан яваагүйсэн бол хэдийнээ бүтэц үхэх байсан билээ.

Өглөөний найман цагийн орчимд хөдөлгөөн гэнэт зогсож сал маань хөдлөхөө болив.

-Юу болов оо! Гэж асуухад нагац:

-Амсхийж л байна гэв.

-Дэлбэрэлт намжлаа гэж ү?

-Үгүй боло уу гэж найаж байна.

Босож ойр тойрныг харвал лаван шахуурга өргөгдөхөө больсон байв.

-Дэлбэрэлт зогсох нь энэ үү? Гэж дуу алдахад нагац:

-Хэ! Хүү минь айх хэрэггүй. Нам тайван байдал удахгүй. Таван минут зогслоо. Одохон уулын оргил өөд дахин ява гээд нронометрээ харав. Үнэхээр тэ дауй сал өргөгдөж эхэлсэн боловч хоёрхон минутб болоод дахин зогсов.

-Аан мөн, арван минутын зайтай түлхэж байгаа юм байна гэхэд нь би:

-Арван минут ий? гэж асуувал:

-Тийм. Дэлбэрэлт тодорхой хугацаанд хүчтэй болоод нэг хэсэг амсхийхэхд нь бид бас хамт амарч байна гэв.

Нээрээ л тийм байлаа. Арван минут өнгөрмөгц асар хурдан өргөгдөж ирснээ дахин зогсов. Галт уулын гол цооноор арай л ороогүй болов уу гэмээр ажээ.

Түр зогсоод хөдлөх бүр улам хүчтэй, улам хурдан дэшилнэ. Амсхийлтийн үед бүтчих гээгд өргөгдөх үе шатчих гээд байх боллоо. Гучин градус хүйтэн умар зүгийн газар ронд очно гэхэд над жаргад жаргал шиг санагдаад цасан дундуур зугаалыг мөрөөднө. Сэтгэл үймж бодол хулжиж эхлэв. Ханс байгаагүйсэн бол би боржин чулуун хананд толгойго хага мөргөх байсан юм.

Дараагийн цөг мөчүүдэд юу болсныг санахгүй байна. Тэнгэр нүрэглэж, чулуун хана дайвалзан, гал улалзаж, шуурга болох шиг болсон. Эцсийн удаа надад гал

улаан өнгөтэй. Хансын нүүр харагдав. Тэгээд үхэр бууны аманд барьж хүлүүлээд буудуулах шиг болсон билээ.

Ухаан орж нүд нэвэл Ханс маань нэг гараараа намайг барьж нөгөө гараараа нагацыг түшээд байж байв. Хамаг бие бяцарсан мэт блжээ. Ажиглаваал нэг нүхнээс хоёрхон алхам зайтай газар уулын бэлд хэвтэж байлаа. Жаахан азнавал нүх уруу унаж үхэх байсан боловч намайг аварчээ.

-Бид хаана байна? гэж нагац асуумагцаа Газар дээр гарснаа мэдээд маш ууртай байх шиг байлаа. Газарч мөрөө өргөн хавчисхийн

-Исланд биш үү? Гэж намайг хсуухад

-Nej гэж Ханс хариулав.

-Биш ий? Яагаад биш гэж хэмээн профессорын дуу дуу алдахад

-Ханс эндүрч байх шиг байна гэж хэлээд би өндийв.

Гайхамшигт аяллын дараа бас л гайхалтай учрал тохиолдов. Умар зүгийг зэлүүд хоосон орны мөнх цас уулын шовх оргил үзнэ гэж бодож байсан билээ. Гэтэл бид хурц нар зэсэн нэгэн уулын бэлд бйж балаа.

Анхандаа итгэхгүй л байв. Гэвч галт уулын тогоо цармаар нүцгэн шалдан шахам гарч ирсэн бидний хамаг бишийг нарны халуун илч ээж байс ан болохоор эргэлзэх аргагүй байлаа. Хочёр сарын турш нарны бараа хараагүй явсан тул хурц туяанаас нүд гялбаж харж чадахгүй байснаа сүүлдээ дасаж ойр тойрноо харав.

Профессор хамгийн түрүүнд ам нээж:

-Энэ газар үнэхээр Исландтай адилгүй юм байна гэхэ нь би:

-Спицбергийн арал биш үү? Гэж асуув

-Биш ээ, хүү минь галт уул нь умар зүгийнх биш байна.

-Тэгээд...

-Аксель, чи өөрөө хар л даа! гэв

Бидний байсан газраас дээш таван зуугаад футийн өндөрт галт уулын амсар харагдана. Арван таван минут тутамд тогоо цармаас гнал утаа олгойдож чулуу, лав хаялна. Тэгэхэд уул тэр аяараа дргин донсолж байв. Тэндээс гарсан халуун лав уруугаа халин урсаж уулын хормой дахь ногоон ойд орж алга болно. Өвс ургамлын байдлыг ажвал умар зүгийн байаль биш өмнө зүгийнх балаа.

Алсад, тэнгисийн ус нүд алдам цэлийж харагана.

Битд хэдхэн бээрийн талбайта нэгэн бяцхан арал дээр гарсан бололтой. Холхонд цөөн байшин үзэгдээд жижиг тохой боомтод хэдэн усан онгож зогсож байв. Түүнээс цааш тэнгисийн цухуйсан бөөн арлууд харагдав. Баруун тийш харвал тэнгэрийн хаяанд уулс цэнхэртээд бас нэгний нь оройгоос утаа суунаглана. Хойт зүгт уудам их тэнгисийн ус цэлийж нарны туяанд ияралзанхан үзэгдэнэ. Энэ бүгд харж ханашгүй зэсгэлэн төөглдөр ажээ.

-Бид чухам хаа байна? гэж би дахин давтан үглэв.

Ханс, хаана ч байсан яах вэ гэсэн байдалтай нүдээ аниад суухад нагац учрыг нь олохгүй байга янзтай гөлрөн гайхаж байснаа:

-Энэ чухам ямар уул болохыг мэдэхгүй байна. Ямар ч болсон халуун халуун дулаан л газар байна. Дэлбэрэлт ч зогсолтгүй үргэлжилсэр л байна. Чулуунд толгойгоо хага цохиулах гэж галт уулнаас гараагүй болохоор одоо доош бууцгаая.

Дараа нь яахаа шийдье. Ер нь өлсөж, цангаж ч үхэх нь байна гэлээ.

Профессор үнэхээр алиаа зүйлийг жил дээр нь туршдаг хүн билээ. Миний тухайд бол өлсөх, цангах, ядра⁴хаа ч мартаад энд хэдэн цаг болсон ч амармаар байвч нөхдийг дагахаас өөр хэрхэх билээ. Галт уулын бэл маш эгц хазгай учир өнхөрч гулгасаар дорогш буулаа.

-Бид дэлхийн бөмбөрцгийн тэн хагасыг гэтэлж Ази тив хүрэд Энэтхэгийн буюу нномхон далайн нэгэн арал дээр гарч ирсэн шиг байна гэж намайг өгүүлэхэд нагц:

-Луужин аль зүгийг зааж балаа? Гэв.

-Луужингийн зааснаар бол ямагт умар зүгийг барин явж байсан.

-Луужин биднийг хуураагүй биз?

-Юу? Хуурах гэнээ

-Хэрэв луужин умарт туйлыг заагаагүй бол яана!

-Эгээ үгүй байгаа... гэв.

Энэ бол ой тойнд буумааргүй хачин зүйл байлаа. Ингэснээр нүд булаасан сайхь ойд ойртоод ирлээ. Өлдсөж, цангаж байна гэдэг жигтэйхэн. Дахин хоёр цаг явсны дараа чидун жимс, анар сэмбэрүү, усан үзэм тэргүүтэн бүрхсэн нэг сайхан газар хүрч ирлэ. Эннэ бүхэн нь хамаг амьтны тусын тулд байга юм шиг ажээ. Жис идэхэд юутай сайхан байсан гэж сана. Бас ойрхон модлны сүүдэрт өвсөн дотор булгийн хүйтэн ус хоржигнож байна. Тэнд очиж нүүр гараай тааламжтай угааж сэрүүцэцгээв.

Нилээд амарч айтал нэг хүхэд модон дотроос гэнэт гарч ирэв.

-Хүүе! Энэ сайхан нутгийн хүн ирлээ гэж би дуу алдав.

Тэр нь уранхай норхой хувцастай нэгэн ядуу жаал ажээ. Биднийг хараад тэр хүүхэд ихэд цочин айжээ. Үс сахал нь ургаж унжсан, нүцгэ шалдан биднээс үнэндээ ч хүн аймааро байсан биз. ЭНэ ёозоор бол алрлын бүх хүмүүсийг айлгаж ч магадгүй байлаа.

Хүхэд эргэж зугадтал Ханс араас нь ухасхийн барьж аваад хөлөөрөө газар балбан орилж чарлаж багаа хүүхдийг чирч авчирахад нагац маш тайвн байдлаар

-Бяцхан найз минь, энэ уулын нэрийг юу гэдэг вэ? гэж цэвэр германаар асуувал хүүхэд юу ч дуугарсангүй.

Тэгэхэд нь нагац:

-За тэгвэл бид германаас явахгүй нь гээд мөн асуултыг англиар асуув. Хүүхэд бас юу ч хариулсангүй.

Гадаад хэлний мэдлэгээрээ ихэд бахархдаг мань профессор дээрх ауултаа францаар асуув

Жаал хүү урьдын адил дув дуугүй байна.

-За тэгвэл, италиар ярья гээд нагац:

-Dove poi sioma?¹ гэхэд хажуугаас и тэсэж ядан:

-Тийм, бид хаана байна гэж давтан хэллээ.

Хүүхэд юу ч хэлэхгүй юм

Нагац бүр уцаарлаж.

¹ Италиар Бид хаана байна? гэжээ

-Чи чинь хэл мэддэг үү, үгүй юу? Come si noma gucstaisola?¹ гэж хашгирахад нөгөө жаал:

-Стромболи гэж хэлэнгүтээ Хансын гараас суга үсрэн жилийв. Санаанд орогүй юм болжээ. Стромболи! Бид газар дундын тэнгисийн тэг дунд байгаа байж! Дорно зүгт цэнхэрлэн харагдах уулс Италинуулс байх нь! Өмнө тэнгэрийн ха⁵яанд харагдах галт уул бол Этна байна.

-Стромболи! Стромболи! Гэж би дахин давтан өгүүлэв.

Аяа! Ямар сонин, юутай гайхамшигтай аялал хийв ээ! Нэг галт уулаар дотогш нэвтрээд нөгөөгөөр гадагш гардаг байна. Гэтэл нөгөө галт уул нь Исландын Снеффельс уулаас мянга хоёр зуун бээр алсан оршдог уул шүү! Дэлхийн хамгийн сайхан оронд иржэ. Цас мөсний оронд ногоон ой харагдана.

Бид жимс цадтал идэж, ус ханатал уугаад Стромболийн боомт чиглэн явцгав. Тэнд очоод хэрхэн явж энэ рал дээр ирснээ эс өгүүлэн гагцхүү онгоц сүйдэж аюулд учирсан улс гэж ярихад шийдэв.

Замдаа нагац:

-Тэгээд луужин юу болов! Луужин умар зүгийг зааж байсан гэж байгаа! Үүний учрыгяж тайлах вэ? гэж байн байн үглэхэд нь би:

-Хэ! Тшүүний учрыг тайлж цөхөх юу байх билээ! гэвэл

-Нээрээ, Хабургийн профессор хүн энэ мэт үзэгдлийг учрыг олохгүй байна гэж үү дээ? Хэрхэвч болохгүй хэрэг! Гэж билээ. Ийнхүү ярихдаа эрдсийн ухааны профессор маань хэрцгий догшин хүн болж хувирсан шиг байв.

Нэг цагийн дараа Сан-Виксанзо гэдэг боомтод хүрч ирлээ. Энд Ханс арван гуравдахь долоо хоногтоо бидэнд үйлчилсний хөлсийг нэхэв. Профессор мөнгийг тоолж газарчид өгөхдөө гарыг нь чанга атгав. Тэгэхэд Ханс үл мэдэг инээмсэглэж билээ.

Миний гайхамшигт өгүүлэл үүгээр дуусаж байна. Сан Виксанзо боомтод биднийг үнэхээр онгоц нь сүйдэж аюулд учирсан хүмүүс гэж хүлээн аваад хувцас хунар, хоол унд өгсөн билээ. Хоёр хоногийн дараа наймдугаар сарын 31-нд нэгэн бяцхан хөлөг онгоц биднийг Мессина хотноо хүргэж өгөв. Тэнд хэд хоног амарч ядаргаагаа гаргав

Есдүгээр сарын 4-ний баасан гаригт бид “Вольтурне” хэмээх францын хөлөг онгоцноо сууж гурван хоног явсны дараа Марсель хотод буулаа. Энэ завсар өнөөх золигийн луужингаас бусад асуудал цөм толгойноос арилж үгүй боллоо. Есдүгээр сарын 9-ний орой Ханбургт ирэв.

Сайн санаат Сартэ авгай, ижилдэн дассан гоо Граюбен хосрын гайхсаныг дүрслэн бичихийн аргагүй.

-Одоо чи ёстой баатар болжээ. Аксель минь, намайг дахин бүү орхиорой гэж хайрт бүсгүйн хэлэхэд инээвхийлсэн нүднээс нь баярын нулимс бөмбөрөн унаж байв.

Профессор Лиденброкийн эргэж ирсэн тухай Ханбург хотод ямар их шуугиан дэгдсэн гэж бодно! Профессорыг дэлхийн төвийг зорин аянд гарсан тухай Мартэгийн

¹ gucstaisola-Италиар энэ арлыг юу гэдэг вэ? гэжээ.

ярьсныг дуулсан хүмүүс түүнд үнэмшээгүй бөгөөд удтал итгэхгүй байлаа.

Харин энэ завсар Хансын эргэж ирсэн тухай Исландаас мэдээлсний дараа олны бодол сая аажмаар өөрчлөгдсөн билээ. Ингээд ах их цуутай хүн боллоо. Бм цуутай хүний дүү болохоор бас зүгээр өнгөрсөнгүй. Ханбург хотынхон биднийг хүндэтгэн баяр ёслол үйлдэв. Нагац профессор өөрийнхөө аяллын талаар олны өмнө яриа хийсэн боловч өнөөх луужингийнхаа тухай юу ч ярилгүй өнгөрөв. Нагац мөн өдөр Сакнусемийн тухай өнөөх баримт бичгийг хотын хуучин бичиг хадгалах газар аваачиж өгсөн байна. Энэ нь Исланд жуулчны мөрөөр дэлхийн төвд хүртэл явж чадаагүйн баталгаа болсон бөгөөд бодит нөхцөл муйхар зоригоос хүчтэй болохыг үзүүлжээ.

Дэлхийн дотоод дахь гал халууны талаар профессор Лиденброкийн баримталдаг үзэл нь шинжлэх ухааны сургуультай харшилж байсан юм. Гэвч тэр энэ асуудлыг шүүмжлэн хэлэлцэж няцаах үед л нагац маань үнэхээр гомдолтой байж билээ.

Төдий удалгүй Ханс маань Ханбургээс явав. Бид энэ хүний ач тусыг хариулах ёстой байсан боловч өөрөө өсөн төрсөн нутгаасаа алсад байхыг хүссэнгүй.

Тэрээр нэг өдөр бидэнд:

-Farval! гэсэн салах ёслолын энгийн нэгэн үг хэлчихээд Рейкьявик орохоор яваад өглөө.

Амь насыг маань аварсан тэр ачит хүнийг би хэзээ ч мартахгүй. Түүнтэй дахин уулзахгүйгээр би ер сэтгэл амар нүд анихгүй билээ.

“Дэлхийн төвийг зорин аялсан нь” гэдэг энэ ном ертөнц даяар асар их шуугиан дэгдээснийг нэмж хэлэх хэрэгтэй. Тэр ном бүх улсын хэлнээ орчуулагдаж аяллын гол гол адал учрал сонин сэтгүүлд нийтлэгдэв.

Нагацын алдар нэр гарч өглөө. Америкийн Нэгдсэн улс, өөрийн оронд айлчлан ирж зөвхөн зүсээ харуулсан төдий их шан өгнө гэж хүртэл амлах боллоо. Гэвч их алдар цууны гүн дотор тусгүй зүйл бас байлаа. Бид өнөөх луужингийн учрыг одоо болтол олж чадаагүй байлаа. Энэ нь эрдэмтэн ахын сэтгэлийг ихэд зовоож байсан юм. Түүний сэтгэл амарвал юутай сайн билээ

Би нэгэн өдөр өөрийнхөө өрөөнд эрдсийн цуглуулга янзалж байгаад өнөөх луужин дайралдахаар нь авч үзэв.

Зургаан сарын турш энэ буланд тоосонд дарагдан хэвтсэн луужин гэв гэнэт миний гайхлыг төрүүлэв. Гайхсандаа дуу алдан хашгирахад ах гүйн орж ирээд:

-Юу болов? гэхэд би:

-Өнөөх луужин!... гэлээ

-Тэгээд яагаав?

-Луужингийн зүү умар зүг заахгүй өмнө зүг зааж байна!

-Чи юу яриад байна вэ?

-Та хардаа, туйл нь эргэж орхиж!

-Эргэж гэнээ! гээд нагац түүнийг харж баярласандаа бахирч дэвхцэв. Бид хоёр гэгээн гэрэлд гарах шиг боллоо.

-Одоо мэдлээ! гэж нагац дуу алдаад

-Биднийг Сакнусем хошуунд хүрэхэд луужин умар зүгийн орон өмнө зүгийг зааж байсан биз дээ! гэв

-Тийм яриагүй тэгсэн
-Тэгвэл бүх зүйл тодорхой боллоо. Гэвч чухам юунаас болж туйл өөрчлөгдсөн байх вэ?
-Үүнийг тайлбарлаж ядах юу байх вэ?
-Тэгвэл чи тайлбарла даа, хүү минь!
-Лиденброк тэнгист азарган бороо орох үед тохиолдсон галт бөмбөлөг луужингийн маань чиг баримжааг алдуулжээ! гэхэд нагац:
-Мөн! гэж инээд алдан хашгираад
-Тэр чинь цахилгааны үйлчилгээгээр тийм болсон хэрэг байна шүү! гэлээ.
Энэ өдрөөс хойш нагац маань дэлхийн эрдэмтдийн дотроос хамгийн аз жаргалтай болж билээ. Би ч бас аз жаргалтай хүн байв. Энхрий хайрт бүсгүй минь эрдэмтний зээ миний гэргий болоод Кенигстрасс дахь байшинд суух болов. Түүний ах алдарт профессор Лиденброк дэлхийн таван тивийн шинжлэх ухаан, газар зүй, эрдсийн ухаан бүх нийгэмлэгүүдийн хариуцлагатай гишүүн болж билээ.

Эх сурвалж:

www.e-pada.com

**Формат, фонт зэргийг бага зэрэг
янзалж pdf хэлбэр уруу
хөрвүүлсэн:**

The Weatherman

<http://weatherman.blog.banjig.net/>